


Баяр
хөөр

ИЛЧЛЭЛТ

Библи судлал



ИЛЧЛЭЛТ НОМНЫ ТАНИЛЦУУЛГА

Удахгүй болох ёстой юмсыг Өөрийн боолууддаа үзүүлэхийн тулд Бурханы түүнд өгсөн Есүс Христийн илчлэлт. Тэр тэнгэр элчээ илгээж Өөрийн боол Иоханд үүнийг мэдүүлжээ. Иохан нь Бурханы үг болон Есүс Христийн гэрчлэлийг төдийгүй өөрийн үзсэн бүхнээ гэрчилсэн болой. Энэхүү эш үзүүлэлтийн үгсийг уншигч болон сонсоод, үүнд бичигдсэн зүйлсийг сахигчид нь ерөөлтэй ээ? Учир нь цаг ойрхон байна.

Илчлэлт 1:1-3

Илчлэлт ном нь Библийн хамгийн сүүлийн ном бөгөөд Библийн эхний ном болох Эхлэл номноос ялгаатай байдаг. (Эхлэл номонд бид нар тэнгэр газрыг хэрхэн бүтээсэн тухай үздэг.) Сатан гарч ирсэнээр гэм, уй гашуу, үхэл хүний амьдралд орж ирсэн төдийгүй Амийн модонд хүрэх эрхээ хүртэл хүн төрөлхтөн хасуулсан юм. Илчлэлт номонд бид нар Сатан болон түүний муу ёрын ажил хэрхэн нурж байгаа мөн гэм, уй гашуу, үхэл ялагдан дийлэгдэж Амийн мод шинэ дэлхий дээр дахин сэргэж Аврагч хэмээн итгэсэн хэн боловч аврагдаж Бурханы мөнхийн улсад амьдрах тухай үзнэ.

Энэ номны гарчиг нь Есүс Христийн Илчлэлт. "Илчлэлт" эсвэл Грекээр "Апокалипс" гэдэг нь ил гаргах, нээх, илрүүлэх гэсэн утгатай. Энэ номноос бид нар Есүс Христийг үнэхээр тэнгэр газрыг бүтээгч Эзэн гэдгийг түүний магтаал, алдар цуунаас мэдэх болно. Бид орчуулганд анхаарлаа төвлөрүүлэхээс илүүтэйгээр энэ номны гол хүн болох Есүс Христэд оюун бодлоо төвлөрүүлцгээе. Тэр хүн болгонд бишрүүлж хүндлүүлэх зохистой нэгэн юм.

Бид Илчлэлт номын үйл явдал яг хэзээ болсныг нарийн сайн мэдэхгүй байна. Гэвч бид энд бичигдсэн бүх зүйл үнэн мөн тодорхой гэдэгт итгэлтэй байж болно. "Тэнгэр газар үгүй боловч, Миний үгс огтхон ч үгүй болохгүй" (Матай 24:35). Энэ Библи судлал бидний зүрх сэтгэлийг Есүс рүү улам их хандуулах болтугай. Энэ номыг судалсны дараа Эзэн Христийг бишрэн хүндэлж түүнд баяр хөөртэйгээр үйлчлэх болно.

ХИЧЭЭЛ 1. ЕСҮС БИД НАРТ МЭДЭЭ АВЧИРСАН

Илчлэлт 1:4-11

Иоханаас Ази дахь долоон чуулганд илгээв. Байгаа болон байсан, мөн хожим ирэх Түүнээс болон Түүний сэнтийн өмнө байх долсон сүнснээс, мөн илтэмжит гэрч ба үхэгсдээс анх төрсөн бөгөөд газрын хаадын захирагч Есүс Христээс нигүүлсэл ба амар тайван нь та нарт байх болтугай. Биднийг хайрладаг бөгөөд өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлж, биднийг хаанчлал болоод Бурхан ба Өөрийн Эцгийн төлөөх тахилч нар болгосон Түүнд үеэс үед алдар хийгээд ноёрхол нь байх болтугай. Амен. Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна. Тэр байтугай Түүнийг жадалсан хүмүүс ч

харна. Дэлхийн бүх оюу Түүнээс болж гашуудах болно. Тиймээ, Амен. Би бол байгаа болон байсан, мөг хожим ирэх Төгс хүчит Альфа ба Омега гэж Эзэн Бурхан айлдаж байна.

Есүс доторх гай зовлон, хаанчлал, тэвчээрийг хамтран хуваалцагч ба ах дүү чинь болох Иохан би Бурханы үг болон Есүсийн гэрчлэлээс болж Патам хэмээх арал дээр байв. Эзэний одор би Сүнс дотор байсан бөгөөд ард маань бүрэн дуу мэт чанга дуу гарах нь сонсогдож, Чи юу харснаа хуйлмал номд бичиж Ефес, Смирна, Пергам, Туатейр, Сардей, Филадельфи, Лаодикт буй долоон чуулгануудад илгээ гэв.

Есүс Христийн амьдрал

1. Есүс Эцэг Бурханаас үнэнийг гэрчлэхээр дэлхий уруу илгээгдсэн юм. Исаиа түүнийг зөгнөсөн: "Үзэгтүн, Би Түүнийг хүмүүсийн гэрч, хүмүүсийн удирдагч, жанжин болгоно" (Исаиа 55:4). Есүс өөрийгөө хэлэхдээ, "Би үнэний тухай гэрчлэхээр төрсөн бөгөөд үүний тулд л ертөнцэд ирсэн,... (Иохан 18:37б)



2. Есүс үхлээс дахин төрсөн нь анхных байв. Есүс үхлийг ялан дийлсэн анхны хүн байсан ба дахиж хэзээ ч үхэхгүй. "Үхэл цаашид түүнийг захирахгүй" (Ром 6:9б)

3. Есүс дэлхийн хаадын Эзэн юм. Тэр бол "хаадын Хаан, эздийн Эзэн" (1 Тимот 6:15б)

4. Есүс бид нарт хайртай бөгөөд тэр өөрийн цусаараа бидний гэм нүглийг угаасан. "Харин Тэр өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний хүү Есүсийн цус биднийг нүглээс ангижруулдаг" (1 Иохан1:7).

Есүс бидний төлөө үхсэн бөгөөд ингэснээр Түүний цус бидний гэм нүглийг угаадаг. "Цус бол амийн төлөө эвлэрүүллийг хийдэг юм" (Левит 17:11б). Та өөрийн гэм нүглээ угаалгахыг хүсэж байна уу? Есүс яг одоо таныг сонсож чадна. Түүний өмнө бүх гэм нүглээ хүлээн зөвшөөр, гэмээ гэмшигтүн. (гэмээ өөрөөсөө зайлуул). Чиний бүх гэм нүглийг уучилсан Түүнд таларх. Түүний сүнс чиний дотор амьдрах бөгөөд гэмийг дийлэхэд чинь туслах болно.

5. Есүс үхлээс дахин амилж тэнгэрт өргөгдөн гарсан шигээ дэлхий дээр дахин эргэж ирнэ. "Тэр ийнхүү айлдсныхаа дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж, тэдэнд харагдахгүй болов. Түүний одохыг харж тэнгэр өөд гөлрөн байсан тэдний хажууд цагаан өмсгөлтэй хоёр хүн зогсоод хэлсэн нь Галилын эрчүүд ээ, юунд та нар тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас



өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нар Түүнийг тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн буцаж ирнэ гэв" (Үйлс 1:9-11) Түүнийг эргэн ирэхэд та түүнтэй уулзахад бэлэн байна уу? "Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар Түүний дотор бай. Тэгвэл Түүнийг үзэгдэх үед бид Түүний өмнө зоригтой байж, Түүнийг ирэхэд өмнө нь ичгүүргүй байх болно" (1 Иохан 2:28). Түүнтэй уулзахад бэлэн биш байгаа хүмүүс гашуудах болно. Харин Түүнтэй уулзахад бэлэн байгаа хүмүүс баярлах болно.

Есүс Христ бол Бурхан

Есүс Өөрийгөө "Альфа ба Омега" гэж дуудсан. Грек цагаан толгойн анхны үсэг нь "Альфа", Хамгийн сүүлийн үсэг нь "Омега". Иймээс Есүс эхэн болон эцэс: Тэр бол мөнх." Харин Хүүгийн тухай [Бурхан] хэлэхдээ: " Бурхан минь, Таны хаан ширээ үеийн үед" (Еврей 1:8а)


Иохан хавчигдсан нь



Есүс Христийг гэрчилснийхээ төлөө Иохан, Патмос гэдэг нэгэн жижиг арал уруу цөлөгдсөн. " Үнэндээ, Христ Есүс дотор бурханлаг амьдрахыг хүсэгч бүх хүмүүс хавчигдах болно" (2 Тимот 3:12). Төгсөх үе ойртох тусам, илүү их хавчлага Есүсийн жинхэнэ дагалдагч нарт ирэх болно. Иохан эхлээд Есүсийн үгийг бичсэн: "Хэрэв ертөнц та нарыг үзэн ядвал, та нараас өмнө Намайг үзэн

ядсаныг мэдэгтүн. (Иохан 15:18)." Та нарыг алах хүн бүр өөрийгөө Бурханд үйлчилж байна гэж бодох цаг ирж байна. (Иохан 16:26). "Ертөнцөд та нар зовлонтой байна. Гэвч зоригтой байгтун. Би ертөнцийг ялсан гэж айлдлаа" (Иохан 16:33б).

ХИЧЭЭЛ 2. ИОХАН АЛДАРШУУЛАГДСАН ХРИСТИЙГ ХАРСАН НЬ



Илчлэлт 1:12-20

Надтай ярьж байсан дууг үзэхээр би эргэн хартал долоон алтан дэнлүүний суурийг харлаа. Дэнлүүний сууриудын дунд, хөлдөө хүрсэн урт дээл өмссөн, цээжээрээ алтан бүс бүсэлсэн Хүний хүү шиг Нэгэн байлаа. Түүний толгой, үс нь цагаан ноос мэт, цас мэт цав цагаан бөгөөд нүд нь галын дөл мэт, хөл нь зууханд улайсгаад өнгөлсөн хүрэл мэт, дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэр

баруун мутартаа долоон од барьжээ. Түүний амнаас хоёр талдаа хурц иртэй илд цухуйх бөгөөд нүүр нь өөрийн хүчээр гэрэлтэх нар мэт байлаа. Би Түүнийг хармагцаа үхсэн хүн шиг хөлд нь уналаа. Тэр баруун мутраа над дээр тавьж, бүү ай. Би бол эхэн ба эцэс бөгөөд амьд Нэгэн мөн. Харагтун, Би үеийн үед амьд байна. Надад үхэл ба үхэгсдийн орны түлхүүр бий. Тиймээс чи юу харснаа, юу байгааг болон эдгээрийн дараа юу тохиолдохыг бичигтүн. Чиний харсан Миний баруун мутарт буй долоон од болоод долоон алтан дэнлүүний суурийн нууцын тухайд, долоон од нь долоон чуулганы тэнгэр элч бөгөөд долоон дэнлүүний суурь нь долоон чуулган юм.

Хийх Зүйлс

Асуулт бүрт хариулан бичнэ үү! Дээрх Библийн хэсгийг хариултаа болгон харна уу. Асуулт болгоны ард тухайн асуултанд хамаарч, хариу болж чадах Библийн ишлэл байгаа. Хамгийн арын хуудаснаас холбогдох хариуг мэдэж болно.

1. Хүний Хүү шиг нэгэн алтан дэнлүүний сууриудын дунд байлаа. (13-р ишлэл). Энэ алтан

дэнлүүнүүд нь долоон (20-р ишлэл).

[Есүс энэ долоон сүмд тушаасан захидал Илчлэлт номны 2,3 бүлэгт агуулагддаг]

2. Хүний Хүү шиг хүрсэн дээл өмссөн, мөн цээжээрээ бүс бүсэлсэн.

(13-р ишлэл). [Энэ хувцас нь Есүсийг тэнгэрлэг агуу нэгэн болохыг харуулж байна.]

3.Түүний толгой, үс нь ноос мэт, цагаан мэт (14).

[Даниел Бурханы харааг харсан (Даниел 7:9 өгүүлсэн байдаг) Даниел хэлсэн" "Түүний толгой үс нь цэвэр ноос шиг байв" Тэр

Бурханыг мөнх гэдгийг илтгэн "Өдрүүдийн Хамгийн Эхнийх" гэж оршин байгааг нь илэрхийлсэн. Илчлэлт номонд Иохан, Хүний Хүү Есүсийг Мөнх гэдгийг илчилсэн.

Мика 5:2, Тэр урьдчилан зөгнөж цорын ганц Түүнийг Бетлехемээс Израилийг захирах тухай хэлсэн байдаг "Энэ нь эртнээс хийгээд мөнхөөс үүдэлтэй." Есүс хүний төрхийг олсон Бурхан байсан.]

4. Түүний нүд нь мэт.

[Эзэний нүд бүх зүйлийг олж хардаг.] "Эзэний мэлмий хаа ч байдаг, хорон муу хийгээд сайныг хардаг.(Сургаалт үгс 15:3) " Эзэний мэлмий зөв шударга хүн руу чиглэсэн байдаг бөгөөд, түүний сонор тэдний хашхирахыг чагнадаг. (Дуулал 34:15).]

5.Түүний хөл нь зууханд улайсгаад өнгөлсөн мэт.

6. Түүний дуу хоолой ньшуугиан мэт.

[“Эзэний дуу хоолой усан дээгүүр байна. Алдрын Бурхан нүргэлдэг. Эзэн их усан дээгүүр байна. Эзэний дуу хоолой хүчтэй” (Дуулал 29:3, 4а).]



7. Тэр баруун мутартаа долоон..... барьжээ (16). Долоон од нь долоон чуулганы юм. (20)

[“Хэрсүү ухаантай нь тэнгэрийн мандлын гэрэл шиг туяарч, олныг зөв шударга байдалд авчрагчид нь од мэт үүрд мөнх гэрэлтэх болно”.(Даниал 12:3). Есүс өөрийн боолуудаа од мэт гартаа атгаж байдаг.Тэд энэ харанхуй ертөнцөд гэрэлтэх болно.]

8. Түүний амнаас хоёр талдаа хурц иртэй..... цухуйна. (16)

[“Бурханы үг Есүсийн амнаас гардаг.”Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй,хоёр талдаа иртэй ямарч илднээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм”.(Еврей 4:12). Бурханы үг биднийг шүүдэг.]

9.Түүний нүүр нь өөрийн хүчээр гэрэлтэх мэт байлаа.

[Есүс гэдэг нэрийн өөр нэг утга нь “Зөв шударгын нар гэсэн утгатай”.“ Гэвч Миний нэрээс эмээгч та нарын төлөө зөв шударгын нар мандах бөгөөд түүний гэрэл эдгээх т у я а г а гийгүүлнэ”. (Малахи 4:2а)



Тэр дэлхий дээр амьдарч байхдаа, Түүний нүүр нь нар мэт гэрэлтэж, хувцас нь гэрэл мэт цагаан болсон байв. (Матай 17:2).]

10. Иохан Хүний Хүүг хармагцаа хүн шиг хөлд нь уналаа. (17).

[Есүсийн арван хоёр дагалдагчдын нэг, сургаал заагч Иохан Есүсийг дэлхий дээр байхад нь хамгийн ойрын дагалдагчийнх нь нэг байсан. Гэвч алдаршуулагдсан Христ түүнд дэндүү их агуу санагдсан. Их Эзэн Есүс үнэхээр их

хүндлүүлэх зохистой нэгэн. Гэвч Есүс түүнд надаас бүү ай гэж хэлсэн.]

11. Есүс хэлэхдээ түүнд(там) ба түлхүүр бий.

[Нэг удаа Есүс Петрт хэлсэн нь Би өөрийн чуулганыг босгох бөгөөд үүнийг үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. (Матай 16:18).]

12. Иоханы хэлсэн гурван зүйл:

(а) "Чи юу (Өнгөрсөнд)

(б) "Юу (Одоо)

(в) "..... юу тохиолдохыг (Ирээдүйд)

Есүс мөнхөд амьд

Есүс бидний гэмийн төлөө цовдлогдон нас барсан нь Бурханы төлөвлөгөө байсан. "Тийнхүү хүүхдүүд нь цус ба махан биеийн тасархай болов. Ингэснээр тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдсаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм. (Еврей 2:14,15).

Гэвч гурав хоногийн дараа Есүс амилж үхлийг ялан дийлсэн. Есүс хэлэхдээ "Би болачилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдрана. Амьд бөгөөд надад итгэгч



бүхэн хэзээ ч үхэхгүй. (Иохан11:25б,26а). Би амьд байна, та нар ч амьд байна. (Иохан14:19б)

ХИЧЭЭЛ 3. ЕСҮСИЙН ЕФЕС ХОТЫН ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 2:1-7

Ефес дэх чуулганы тэнгэр элчид бичигтүн.

Баруун мутартаа долоон одыг баригч Нэгэн, долоон алтан дэнлүүний суурийн дунд алхагч Нэгэн үүнийг айлдаж байна. Би чиний ажил үйлс, нөр хөдөлмөр, тэвчээрийг чинь болон муу хүмүүсийг тэсвэрлэж чадаагүйг болон өөрсдийгээ элч нар гэдэг атлаа, чухамдаа элч биш хүмүүсийг шалгаж, хуурамч хүмүүс байсныг нь илчилснийг чинь мэднэ. Чи тэвчээртэй байж, Миний нэрийн төлөө хүлцэн тэвчиж, цуцаагүй. Харин Надад чиний

эсрэг зүйл байна. Юу гэвэл чи анхны хайраа орхижээ. Тиймээс чи хаана унаснаа санаж гэмш. Чи анх хийж байсан үйлсээ үйлд. Хэрэв чи гэмшихгүй бол, Би чам руу очиж, дэнлүүний чинь суурийг байрнаас нь зайлуулах болно. Гэвч чамд сайн юм бий. Юу гэвэл миний үзэн яддаг николайчуудын үйлсийг чи ч мөн үзэн яддаг. Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун. Бурханы диваажинд буй амийн модноос идэхийг Би ялагч нэгэнд соёрхоно.

Есүс сүм нэг бүрийг шалгасан нь

Тэдний сүнслэг байдлыг шалгах гэж Есүс Ази дахь (одоогийн Турк) долоон сүм дотор алхаж байна. "Шүүлт Бурханы гэр бүлээс эхлэх цаг болжээ" (1 Петр 4:17а). Есүс дэлхийг шүүхээсээ өмнө сүмүүдийг шүүх болно.

Сүм магадгүй хэн нэгэнд магтагдаж эсвэл үзэн ядагдаж болно. Энэ бол гол асуудал биш. Гол асуудал нь Христ сүм нэг бүрийг юу гэж боддог вэ ?

Есүс сүм нэг бүрийг "Би чиний хийж байгаа ажлыг мэднэ" гэж хэлсэн. Христ таны сүмийн тухай юу гэж хэлэх байсан бол? Эдгээр сүмүүдэд бичсэн захидлууд бидэнд их юм бодогдуулна. Есүс сүмүүдэд бичсэн илгээмжийг тэнгэр элч хэмээн хаягласан. Тэнгэр элч гэдэг үг нь илгээгч гэсэн утгатай. Энэ нь сүмийн ахлагч нарт хамаатай байж болох

юм. Есүсийн илгээмж бүр өөрийг нь тодорхойлсон байдаг бөгөөд энэ сүм бүрд онцгой утга илэрхийлдэг. Ихэнхи захидлууд сүмийн сайн талыг сайшаасан байдаг. Гэвч бүх захидлуудын хоёр нь хатуу зэмлэсэн байдаг.

Захидал бүр сүмийн жинхэнэ итгэгч нарт онцгой амлалтыг амласан байна. Бурханы нигүүслийг хүн бүр авах болтугай. “Бузар муугаар бүү дийл, харин бузар мууг сайнаар дийлэгтүн” (Ром 12:21).

“Бурханаар төрсөн бүхэн ертөнцийг ялдаг. Ертөнцийг дийлсэн ялалт нь бидний итгэл болой” (1 Иохан 5:4). “Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ.Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм” (Илчлэлт 12:11).

Хийх Зүйлс

Хоосон зайд зөв үгийг нөхөж бич.

1. Христийг тодорхойлох: “Энэ зүйл түүнийг баруун мутартаа долоон баригч нэгэн” гэж хэлдэг. (ишлэл 1). [Бурханы баруун мутраар хамгаалуулах нь хичнээн гайхамшигтай вэ ! “Би тэдэнд мөнх амийг өгнө. Тэд хэзээч мөхөхгүй бөгөөд Тэднийг хэн ч Эцэгийн гараас булааж чадахгүй” (Иохан 10:28).]

2. Магтаал: Би чиний ажлыг мэднэ, чиний , чиний , мөн чи хүмүүсийг тэсвэрлэж чадаагүйг” (2). “Миний үзэн яддаг николайчуудын үйлсийг ч чи”.

[“Николайчууд” гэдэг үг нь “хүмүүсийг эзэмдэх” гэсэн утгатай. Магадгүй санваартан болон итгэгч нар салангид байсан байж болох юм.” Та нарын дунд байгаа Бурханы хонин сүргийг хариул. Ингэхдээ албадлагаар бус, харин сайн дураараа, Бурханы хүслийн дагуу харгалзан, хомхой ашгийн төлөө бус, харин хичээл зүтгэлээр, өөрсдөд чинь даалгасан хүмүүсийг ноёлох бус, харин хонин сүрэгтээ үлгэр дуурайл болон хариул.” (1Петр 5:2,3).

3. Зэмлэл: Надад чиний эсрэг зүйл байна, чи..... орхижээ. (4).

4. Ялагчдад амласан амлалт: Бурханы буй идэхийг би ялагч нэгэнд соёрхоно” (7). [Бурхантай үүрд хамт байна гэдэг нь хичнээн гайхамшигтай вэ!]

Ефес:Анхны хайраа орхисон сүм

Ефес хот нь Грекийн соёл болон сүсэг бишрэлийн гол төв байсан. Эртний долоон гайхамшгийн нэг болох Артемисын сүм тэнд байрлаж байв.(Үйлс19:35). Акул, Приска, Аполлос нар энэ хотод ажиллаж байсан. Мөн Паул энд гурван жил сургаал зааж байжээ. Ефес ном нь Паулын Ефесийн сүмд бичсэн захидал юм. Хожим нь элч Иохан Ефес хотод 30 жилийн турш үйлчилжээ.

Хэрэв хайр хөрвөл

Ефесийн сүм Эзэний хайраар дүүрэн юм шиг харагдаж байсан. Тэд Бурханы төлөө маш завгүй үйлчилж байв. Мөн тэд Бурханы үнэн Үгийг тууштай хамгаалж байв. Гэвч Есүс тэдэнд нэг юм байхгүйг олж харсан юм. Тэд Бурханыг хайрлаж байсан анхны хайраа орхижээ. Эзэнд үйлчилснээр Бурханы хайрыг хэзээ ч авч явж чадахгүй.

Та нар Мартаг санаж байна уу ? Түүний дүү Мариа Есүсийн үгийг сонсож байхад харин тэрбээр завгүй үйлчилж байсан. Есүс түүнд хэлсэн нь “Марта, Марта чи мөн ч их зүйлд санаа тавьж зовох юм даа. Үнэндээ ганцхан зүйл хэрэгтэй билээ. Мариа өөрөөс нь зайлуулагдашгүй сайныгаа л сонгон авчээ гэв” (Лук10:41б, 42).

Чиний анхны хайр яасан бэ? Христийг хайрлах хайр чинь хөрснийг хэрхэн олж мэдэх вэ? Есүс бидэнд юу хийх тухай хэлсэн:

1. Хаана унаснаа сана. Есүсийн нэг сургаалд нэгэн хүү буруу амьдралаар амьдран өв хөрөнгөө үрэн таран хийсэн тухай гардаг. “Тийнхүү тэр ухааран, “Эцгийн минь хөлслөсөн хүмүүсийн хичнээн нь ч талхаар элбэг дэлбэг байдаг билээ дээ. Гэтэл би энд өлсөж үхэх нь” (Лук15:17).

2. Гэмших.Есүсийн сургаал дээр гардаг үрэлгэн хүү

гэмээ ухааран аав дээрээ эргэж очихоор шийджээ. "Би босоод эцэг уруугаа очье. Тэгээд түүнд аав аа, би тэнгэрийн эсрэг, таны өмнө нүгэл үйлджээ" (Лук15:18).



3. Анхны ажилаа хий. "Тэгээд тэр

босож эцэг рүүгээ явжээ. Харин эцэг нь түүнийг холоос хараад, ихэд ерөвдөн гүйн ирж, тэврээд үнсэв"

(Лук15:20). Христтэй ойр харилцаатай байх нь бидний амьдралын тэргүүнд тавигдах чухал зүйл юм. Хэрэв чи Христийг хайрласан анхны хайраа орхивол Есүс юу хийх тухай ингэж хэлсэн. "Дэнлүүний чинь суурийг байрнаас нь зайлуулах болно". Сүм эсвэл хувь хүн нь гэрэл байж чадах чадвараа алдах боломжтой юм. "Хэрэв хэн нэгэн нь Миний дотор байхгүй бол мөчир мэт хаягдаж хувхайрна" (Иохан 15:6а).

Есүс сонсохыг хүсэж байна

Есүс бүх сүмд хандан ингэж хэлж байна: "Чуулгануудад сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун." Бид Бурханы үгийг сонсохдоо яг үр авч байгаа хөрс шиг байдаг. "Сайн хөрсөнд унасан нь үгийг сонсдог ба ойлгодог нэгэн байх бөгөөд тэр нь үнэхээр үр жимс гаргадаг. Зарим нь зуу, зарим нь жар, зарим нь гуч дахинг авчрах болно гэж айлдав" (Матай 13:23).

ХИЧЭЭЛ 4. ЕСҮСИЙН СМИРНА ДАХЬ ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 2:8-11

Смирна дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. "Үхсэн бөгөөд амилсан эхэн ба эцэсүүнийг айлдаж байна. "Би чиний зовлон шанлал, ядуу байдлыг (гэвч чи баян) болон өөрсдийгөө иудейчүүд хэмээгчдээр доромжлогддогийг чинь мэднэ. Харин тэд иудейчууд биш бөгөөд Сатаны синагог юм.

Эдлэх гэж буй зовлонгоосоо бүү ай. Үзэгтүн, Диавол та нарыг сорихын тулд та нараас заримыг чинь шоронд хаях гэж байна. Та нарт арван өдөр гай зовлон учрах болно. Үхэл хүртэл итгэмжтэй бай. Тэгээд Би чамд амийн титмийг өгнө. Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтүн. Ялагч нь хоёр дахь үхлээр хохирохгүй.

Хийх зүйлс

Хоосон зайд байгаа ишлэлүүдийг нөхөж бич.

1.Христийг тодорхойлох: бөгөөд, ба (ишлэл 8).

[Хавчлагаас болж зовж байгаа сүмд, үхлийг ялан дийлсэн Христийн энэ илгээмж хичнээн их тайтгарал болж байна вэ!].

2.Магтаал: "Би чиний ажлыг мэднэ, чиний, (гэвч чи)" (9).

[Тэр хүн өөрийнхөө төлөө эд баялагийг хураагч бөгөөд Бурханы өмнө баян биш болой. (Лук 12:21) "Миний хайрт ах дүү нараа, сонсогтун. Бурхан энэ ертөнцийн ядуусыг Өөрийг нь хайрлагсдад амласан хаанчлалын өвлөгчид болгож, тэднийг итгэл дотор баян байлгахын тулд сонгоогүй гэж үү?" (Иаков 2:5).]

3. Зэмлэл: Байхгүй.


[Хавчлага ихэнхдээ сүмийг ариун болгодог. Есүс хавчлагад өртсөн энэ сүмээс алдаа дутагдал олоогүй.]

4.Ялагчдад амласан амлалт: "Ялагч нь хоёр дахь

(11). [Тэгээд үхэл ба үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой (Илчлэлт 20:14).]

Смирна: Хавчлагад өртсөн сүм.

“Смирна” гэдэг үг нь “Мирр” гэдэг ургамалтай ижил утгатай бөгөөд энэ ургамал нь бяцрах үедээ үнэртэн ялгаруулдаг. Христэд итгэдэг хүмүүсийн эсрэг Ромын хууль хүчтэй байсан. Азид байдаг итгэгчдийн ихэнх нь Смирнад хавчигдаж байв.



Сургаал номлогч Иоханы найз Поликарп энд шатаж үхсэн. Эртний сүмүүд Ромын эзэнт гүрний үе үеийн хаадуудад хавчигдаж байсан. Энэ үед ойролцоогоор таван сая итгэгчид амь үрэгдсэн гэж үздэг. Диокладын төр барьж байх үед сүүлийн арван жил итгэгчдийг агуй болон ойгоос агнан алж байжээ. Итгэгчдийг шатааж, зэрлэг амьтанд бариулж, бүхий л төрлийн үхлээр шийтгэж байв. Гэвч Диокладын эхнэр охин хоёр Христэд итгэсэн юм. Хавчигдаж байгаа сүм Бурханы анхилуун үнэрийг тарааж байдаг. “Харин Бурханд талархлууд нь өргөгдөх болтугай. Тэр нь биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр анхилуулдаг” (2 Коринт 2:14).

Хавчлагаас бүү айгтун

Биднийг дэлхий дээр амьдарч байхад юу тохиолдох тухай Есүс дагалдагчиддаа ингэж хэлсэн. “Хэрэв тэд намайг хавчсан бол, та нарыг бас хавчих болно. Хэрэв

тэд миний үгийг сахисан бол, та нарынхыг мөн сахих болно". (Иохан 15:20б).

Хавчлага маш олон хэлбэрээр ирдэг. Гүтгэлэг, доог тохуу хийх, зэмлэх, гутаах, зодох, үхэл г.м. Хавчлага Сатанаас ирдэг. Сатан өөрсдийгөө ахан дүүс хэмээн дууддаг чөтгөрийн хүүхдүүдийг ашиглаж болох юм. "Бурханы хүүхдүүд ба диоволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг үйлддэггүй аливаа хүн Бурханых биш. Ах дүүгээ хайрладаггүй нэгэн ч Бурханых биш". (1Иохан 3:10).

Бид хавчлагаас айх ёсгүй, Учир нь Бурхан бидэнтэй хамт байдаг. "Тиймд бид зоригтойгоор Эзэн миний туслагч мөн. Би айхгүй. Хүн намайг яах юм бэ? гэдэг" (Еврей13:6). Үхлээс айлгүй үнэнч үлдсэн хүмүүст Есүсийн амласан амлалт хичнээн сайхан бэ! Тэр тэдэнд мөнхийн титмийг өгөх болно. "Итгэлийг Эхлүүлэгч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс үрүү хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийн баруун гарт заларсан юм". (Еврей12:2).

Чиний эргэн тойронд байгаа хүмүүс хавчлагаас болж унаж магадгүй. Есүс үүнийг тайлбарлахдаа "Чулуурхаг газар унасан нь үгийг сонсоод тэр даруйдаа баяртайгаар хүлээж авч, харин өөрт нь бат үндэс байхгүй тул түр зуур байдаг аж. Үгнээс болж хавчлага, эсвэл зовлон тохиолдоход тэр дороо л унадаг. (Матай 13:20,21). Бурханы үгийг бид гүн суулгаж, ямар ч нөхцөл байдалд Түүнд итгэх хэрэгтэй. Түүний хайр энэрэл цаг үргэлж бидэнд хангалттай байдаг.

ХИЧЭЭЛ 5. ЕСҮСИЙН ПЕРГАМ ДАХЬ ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 2:12-17

"Пергам дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. "Хоёр талдаа хурц илдтэй Нэгэн үүнийг айлдаж байна." Би чиний хаана нутагладгийг

болон тэнд чинь Сатаны сэнтий байдгийг мэднэ. Чи Миний нэрийг бат сахидаг бөгөөд Миний итгэлийг үгүйсгээгүй, бүр Сатаны

нутагладаг газарт, та нарын дунд алагдсан Миний гэрч, Миний итгэлт нэгэн болох Антипын өдрүүдийн үед ч үгүйсгээгүй билээ. Харин чиний эсрэг хэдэн зүйл Надад байна. Яагаад гэвэл чиний тэнд Балаамын сургаалыг сахигчид байдаг. Балаам нь Израилийн хөвгүүдийн өмнө бүдрүүлэх саад тавиулах гэж, шүтээнүүдэд тахисан юмсыг идүүлж, садар самууныг үйлдүүлэх гэж Балакийг сургасаар байсан. Тэрчлэн

үүний адилаар николайчуудын сургаалыг сахигчид ч чамд бий. Тиймээс гэмшигтүн. Эс бөгөөс би чам уруу даруй очиж, амныхаа илдээр тэдэнтэй тулалдах болно. Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун. Ялагчид Би нууцалсан маннагаас өгнө. Би түүнд цагаан чулуу болон түүнийг хүлээн авагчаас өөр хэн ч мэдэхгүй чулуун дээр бичигдсэн шинэ нэр өгнө.”

Хийх зүйлс

Хоосон зайд байгаа ишлэлүүдийг нөхөж бич.

1. Христийг тодорхойлох : Хоёр талдаа ирт Нэгэн үүнийг айлдаж байна. (Ишлэл12).

[Бурханы үг энэ сүмд маш их хэрэг болж байсан. Учир нь буруу номлогчид энэ сүмд байсан юм.]

2. Магтаал: Чи миний бат сахидаг бөгөөд итгэлийг (13).

3. Зэмлэл: Чиний тэнд сургаалыг сахигчид байдаг. (14). Тэрчлэн үүний адилаар миний үзэн яддаг сургаалыг сахигчид ч чамд байдаг. (15).

[Балзам нь Израилийн хөвгүүдийн өмнө бүдрүүлэх саад тавиулах гэж, шүтээнүүдэд тахилын юмыг идүүлж, садар самууныг үйлдүүлж байсан.” Тэд тогтворгүй сэтгэлтэнгүүдийг уруу татдаг бөгөөд шуналд дадлагажсан зүрхтэй хараалын хүүхдүүд юм. Тэд зөв шулуун замыг умартан, зөвт бус байдлын хөлсийг хайрлагч Беорын хүү Балаамын замыг даган төөрөлджээ”. (2 Петр 2:14б,15) Энэ сүм яг Балаам шиг итгэгчдийн дунд хоосон номлогчдоор

сургаал заалгаж байсан. Гуравдугаар хичээл дээр Ефес дахь чуулган Николайчуудыг үзэн яддаг тухай гардаг. Харин Пергам дахь чуулган хоосон номлогчийг үзэн ядаагүй.]

4. Ялагчдад амласан амлалт: Ялагчдад Би нууцалсан өгнө. Би түүнд чулуу, чулуун дээр бичигдсэн шинэ өгнө. (17).

[Хуучин Гэрээн дээр Бурхан Израилийг цөл газар байхад нь маннагаар (нарийн хоол) тэжээж байсан. Есүс өөрийгөө талхтай зүйрлэсэн. “Би бол амийн талх байна. Над руу ирдэг хүн өлсөхгүй, Надад итгэдэг хүн хэзээ ч цангахгүй” (Иохан 6:35б). Цагаан чулууг эрт үед буруугүй гэдгээ баталж шиддэг байсан. Христээс цагаан чулуу мөн шинэ нэр олж авснаар Бурханы өмнө зөвтгөгдөх баталгаа болдог. “Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Учир нь Христ Есүс дотор амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ” (Ром 8:1,2)]

Пергам: Ертөнцтэй адил сүм

“Пергам” гэдэг үг нь “гэрлэсэн” гэсэн утгатай. Пергам дахь чуулган нь энэ ертөнцтэй маш эв нэгдэлтэй ойр байсан. Энэ хотыг Сатаны сэнтий гэдэг. Учир нь энэ хот Вавилоны хамгийн гол соёлын төв хот байсан. Есүс энэ чуулганыг гэмш, эс бөгөөд Өөрийн амнаас гарах хурц илдээрээ тулалдана гэсэн. Зөвхөн Бурханы үг буруу хоосон номлогчтой тулалдаж чадна. “Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм” (2 Тимот 3:16,17) Иохан энэ чуулганыг сайшаасан. “Үнэн эсэхийг мэдэхийн тулд Судрыг өдөр бүр нягтлан үзэж байлаа” (Үйлс 17:11б).

ХИЧЭЭЛ 6. ЕСҮС ТУАТЕЙР ДАХЬ ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 2:18-29

Туатейр дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн.

Галын дөл мэт нүдтэй, өнгөлсөн хүрэл мэт хөлтэй, Бурханы Хүү үүнийг айлдаж байна. “Би чиний ажил үйлс, хайр, итгэл, үйлчлэл, тэвчээрийг болон эцсийн ажил үйл чинь эхнийхээсээ агуу гэдгийг мэднэ. Гэвч чиний эсрэг зүйл Надад байна. Юу гэвэл өөрийгөө эш үзүүлэгч хэмээн нэрлэдэг Иезебел гэгч эмэгтэйд Миний боолуудыг сурган, төөрөлдүүлэхийг чи зөвшөөрсөн. Тэгснээр тэд садар самууг үйлдэн, шүтээнүүдэд өргөсөн юмсыг иддэг ажээ. Би тэр эмэгтэйд гэмших хугацаа өгсөн. Харин тэр садар самуун үйлдсэндээ гэмшихийг хүсдэггүй. Харатун, Би түүнийг орон дээр хаяна. Хэрэв тэр эмэгтэйн үйлдэлд гэмшихгүй бол, түүнтэй завхайрагчдыг үлэмж гай зовлонд унагана.

Түүний хүүхдүүдийг Би үжлээр хөнөөнө. Би бол оюун санаа хийгээд зүрхийг Нягтлагч гэдгийг бүх чуулганууд мэдэх болно. Би та нарын хүн нэг бүрд үйлсийнх нь дагуу хариу өгнө. Харин энэ сургаалыг сахьдаггүй, өөрсдийнх нь нэрлэдэгээр Сатаны гүн юмсыг мэддэггүй, Туатейр дахь бусад хүмүүс болох та нарт Би халье. Би та нарын дээр өөр дарамт тавихгүй. Гагцхүү юу байгаагаа намайг очтол бат сахь. Ялагч ба Миний үйл хэргийг эцэс хүртэл хамгаалдаг хүнд Би үндэстнүүдийг захирах эрх мэдэл өгнө. Би Эцэгээсээ эрх мэдлийг хүлээн авсан. Үүнчлэн тэр хүн шавар сав суулгануудыг хага цохих адил тэднийг төмөр таягаар захирах болно. Би түүнд үүрийн цолмонг өгнө. Чуулгануудад юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун.”

Хийх зүйлс

Хоосон зайд байгаа ишлэлүүдийг нөхөж бич.

1.Христийг тодорхойлох : Хүү үүнийг айлдаж байна. Галын дөл мэт, өнгөлсөн хүрэл

мэт.....(Ишлэл18).

[Аврагчийн нүд бүх муу зүйлийг ялган хардаг. Бүх муу зүйл түүний хөлөн доор шүүгдэнэ.]

2.Магтаал: Би чиний ажил үйлс,, болон эцсийн чинь, агуу гэдгийг мэднэ.(19).

3.Зэмлэл:, гэгч эмэгтэй өөрийгөө, гэж нэрлэдэг. Миний боолуудыг сурган, үйлдэн, өргөсөн зүйлийг иддэг ажээ.

4.Ялагчдад амласан амлалт: Ялагч ба Миний үйл хэргийг эцэс хүртэл хүнд би бүх захирах өгнө.(26). Би түүнд үүрийн өгнө.(28).

[Христийн мөнхийн улсад ахлагч нар өндөр байр суурьтай байх болно." Хэрэв бид тэвчвэл, Мөн түүнтэй хамт хаанчлах болно" (2 Тимот 2:12а). Илчлэлт номны 22:16 Есүс өөрийгөө үүрийн цолмон гэж тодорхойлсон." Бид илүү баттай болгогдсон эш үзүүллэгийн үгтэй. Үүр цайж, үүрийн цолмон зүрхэнд тань гийх хүртэл, харанхуй газарт гэрэлтэж буй дэнлүүг анхаарах мэт та нар түүнд анхаарал тавихдаа сайн байдаг". (2 Петр 1:19) 2.Магтаал:

Туатейр: Буруу эш үзүүлэгчтэй чуулган

Туатейр хот нь сургаал номлогч Паулын өөрчилсөн Европын анхны хот юм. "Туатейр хотоос ирсэн, нил ягаан өнгийн бүс давуу худалдаалдаг, Бурханд мөргөгч Лудиа гэгч нэгэн эмэгтэй тэднийг сонсож байлаа. Паулын ярьж буй зүйлийг анхааруулахын тулд Эзэн тэр эмэгтэйн зүрхийг нээжээ" (Үйлс 16:14). Туатейр хот нь эмэгтэй хүний хувцас үйлдвэрлэдгээрээ алдартай хот байсан. Есүс энэ сүмийг буруу эш үзүүлэгч Иезебел хэмээх бүсгүйг зөвшөөрсөн хэмээн буруутгасан. Тэр эмэгтэй буруу хоосон номлол болон муу үйлсийг тэргүүлж байсан. Тэр Бурханы зарц нарыг хавчсан Ахабын эхнэр Иезебелийн хийж байсан зүйлийг хийж байсан.Иезебелийн ажлыг

тодорхойлбол нарийндаа Сатаны ажил юм. Есүс түүнд гэмших хугацаа өгсөн. Гэвч тэр гэмшсэнгүй. Одоо тэрбээр шүүгдэх болно. Түүний сургаалыг дагаагүй үнэнч үлдсэн хүмүүсийг Түүнийг иртэл бат зогсохыг Есүс тушаасан. "Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав. Учир нь хүмүүс өөрсдийгөө хайрлагчид, мөнгийг хайрлагчид, сагсуурагчид, доромжлогчид, эцэг эхдээ захирагдахгүй, үл талархагч, ариун бус, үл хайрлагч, эвлэрэшгүй, гүжирдэгчид, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагчид, Тэрслэгчид, бодлоггүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагчид байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагчид байх болно. Тэд бурханлаг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг нь үгүйсгэдэг. Чи ийм хүмүүсээс зайлсхийж яв. Тэдний дунд айлд гэтэж ороод, нүгэлд автагдаж, зүсэн бүрийн хүсэл тачаалдаа хөтлөгдсөн сул дорой эмэгтэйчүүдийг олзолдог хүмүүс ч байна. Тийм эмэгтэйчүүд үргэлж суралцавч, үнэний мэдлэгт хэзээ ч хүрч чадахгүй" (2 Тимот 3:1-7).

Христ хүн болгонд үйлсийнх нь дагуу өгнө гэж хэлсэн. Харин энэ сүмийн хувьд маш их гай зовлон учрах болно. Бид Бурханы анхааруулгыг болгоомжтой авах хэрэгтэй.

Тэд нарыг хэн гэдгийг Есүс мэднэ.

"Би сайн Хоньчин мөн. Би Өөрийнхийгөө мэдэх бөгөөд Өөрийнхөн минь Намайг мэднэ" (Иохан 10:14). "Хэрэв хүн Бурханд хайртай бол тэр хүн түүгээр танигдсан байна. (1 Коринт 8:3)." Хэдий тийм боловч Бурханы бат суурь нь хэвээрээ байна. Энэ нь "Эзэн өөрийн хүмүүсийг таньдаг", "Эзэний нэрийг нэрлэгч хүн бүр бузар муу явдлаас хол байгтун" гэсэн тамгатай. (2 Тимот 2:19).



ХИЧЭЭЛ 7. ЕСҮС САРДАЙ ДАХЬ ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 3:1-7

“Сардай дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Бурханы долоон Сүнс ба долоон одтой Тэр үүнийг айлдаж байна. “Би чиний үйлсийг, чиний амьд гэдэг нэртэй боловч үхдэл гэдгийг чинь мэднэ. Сэрэгтүн, үхэх гэж байсан үлдсэн юмсаа тэнхрүүл. Учир нь миний Бурханы өмнө чиний үйлс гүйцэлдсэнийг Би олсонгүй. Тиймээс чи юу хүлээн авсан болон сонссоноо сана. Түүнийг сахь, гэмш. Хэрэв чи сэрэхгүй бол Би хулгайч мэт очно. Ямар цагт Миний чам

дээр очихыг чи мэдэхгүй. Гэвч хувцасаа хиртүүлээгүй цөөн хүн Сардейд чамд бий. Тэд Надтай хамт цагаан хувцастай алхах болно. Яагаад гэвэл тэд зохистой хүмүүс мөн. Энэ мэт ялагч нь цагаан хувцас өмсөнө. Би түүний нэрийг амийн номноос баллахгүй. Би Өөрийнхөө Эцэгийн өмнө болоод Түүний тэнгэр элч нарын өмнө түүний нэрийг хүлээн зөвшөөрнө. Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун.

Хийх зүйлс

Хоосон зайд байгаа ишлэлүүдийг нөхөж бич.

1. Христийг тодорхойлох : Бурханы Сүнс ба, одтой. (Ишлэл1).

[Исаиа Есүсийг амраах далан Бурханы? сүнстэй ярьж байсан. “Эзэний Сүнс, мэргэн ухаан болон ойлголтын сүнс, зөвлөх болон хүч чадлын сүнс, Эзэнээс эмээхүй болон мэдлэгийн сүнс түүн дээр оршино” (Исаиа 11:2).]

2. Магтаал: Чамд хувцасаа цөөн хүн байна. [Энэ сүмд цөөхөн хүн ариун амьдралаар амьдарч байсан.]

3. Зэмлэл: би чиний үйлсийг, чиний гэдэг нэртэй боловч гэдгийг мэднэ. Чиний үйлс Би олсонгүй.

[Сардей дахь чуулган амьд гэсэн нэртэй байсан боловч

Бурханы хараагаар үхдэл байсан. Есүс бид нарыг төгс яг Христ шиг төлөвшсөн байхыг хүсдэг учир нь Бурханы сүнс бидэнд байдаг." Тиймээс тэнгэрлэг Эцэг чинь төгс байдаг шиг та нар төгс бай" (Матай 5:48). "Тэсвэр хатуужил нь төгс үр дүнтэй байг. Тэгвэл та нар юугаар ч дутахгүй төгс, бүрэн бүтэн байна" (Иаков 1:4).

4. Ялагчдад амласан амлалт: Ялагч нь хувцас өмсөнө. би түүний нэрийг
..... Би өөрийнхөө эцэгийн өмнө болоод Түүний тэнгэр элч нарын өмнө түүний нэрийг(5).

Сардей: Үхмэл чуулган

Үхмэл байдлаас гаргах Бурханы хүч Сардей дахь чуулганд хэрэгтэй байсан. Энэ хотын чуулганы үхмэл байдал хичнээн гунигтай вэ! Амь зөвхөн Есүс Христээр дамжин ирдэг. Сардей дахь чуулган анх хүлээн авсан болон сонссоноо мөн гэмшихийн төлөө тэмцсэн. "Харин муу хүмүүс, мэхлэгч нар хуурч, хуурагдан улам бүр муу болно. Харин чи хэнээс сурснаа мэдэж, юунд итгэсэн болон юу сурсан дотроо байнга бай. Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай Ариун Бичээсүүдийг чи бага наснаасаа мэдэх болсон. (2Тимот 3:13 –15). Бид өдөр бүр Судрыг судалж санах хэрэгтэй." Таны эсрэг нүгэл хийхгүйн тулд Таны үгийг би зүрхэндээ хадгалсан" (Дуулал 119:11)." Харин тэрээр Эзэний хуульд баярлаж, Түүний хуулийг өдөр шөнөгүй тунгаан бяслагадаг" (Дуулал 1:2). Бурханы үг биднийг гэмээс хол байлгадаг. "Үнэн дотор тэднийг ариусгаач. Таны үг бол үнэн. (Иохан 17:17). "Сардей" гэдэг нь "Үлдэгдэл" гэсэн утгатай үг. Бурханд таларх учир нь Бурханы хараанд бузартаагүй цөөхөн хүн үлдсэн юм." Явдал үйл нь гэм зэмгүй Эзэний хуулиар явагч хүмүүс юутай ерөөлтэй вэ! " (Дуулал 119:1). "Юу хүнийг бузарладаг вэ? "Учир нь дотроос, хүмүүсийн зүрхнээс хорон муу бодол, садар самуун, хулгай, аллага, завхайрал, мөн заль мэх, тачаангуй байдал, атаархал, гүтгэлэг, бардам зан,

мунхаглал нь гардаг. Энэ бүх хорон зүйлс нь дотроос гарч хүнийг бузарладаг гэж айлдлаа. (Марк 7:21-23).” Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариусгалыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой. Хэн чинь ч Бурханы нигүүлслээс салахгүйн тулд болон ямар ч гашуун үндэс урган хор учруулан, түүгээр олон хүн бузарлагдахгүйн тулд сэрэмжил. (Еврей 12:14,15).

Есүс зарим нэгэнд нь хулгайч мэт ирнэ.

Есүс биднийг үргэлж сэрэмжтэй байхыг шаарддаг. Ингэснээр Түүнийг эргэж ирэх тэр цагт бид бэлэн байх юм. Тэр яг шөнө дунд хулгайч мэт ирнэ. Гэвч тэр итгэгч хүнийг гэнэт авч явахгүй. “Учир нь Эзэний өдөр нь шөнөөр ирэх хулгайч мэт ирэхийг та нар өөрсдөө маш сайн мэддэг. “Амар тайван, аюулгүй байдал” гэж ярьж байх үед жирэмсэн эмэгтэйд төрөлтийн хүчтэй өвдөлт учрахын адил тэдэн дээр сүйрэл нь гэнэт ирэхэд, тэд зугтааж огт чадахгүй. Гэвч ах дүү нар аа, та нар харанхуй дотор байдаггүй учраас тэр өдөр нь та нарыг хулгайч мэт бариад авахгүй. Учир нь та нар бүгдээрээ гэрлийн хөвгүүд бөгөөд өдрийн хөвгүүд юм. Бид шөнийнх ч биш, харанхуйнх ч биш. Тиймээс бид бусдын адил унталгүй, харин сэргэг бөгөөд эрүүл ухаантай байцгаая. (1Тесалоник 5:2-6).

ХИЧЭЭЛ 8. ЕСҮС ФИЛАДЕЛФИ ДАХЬ ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 3:7-13

“ Филаделфи дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн.” Нээхэд нь хэн ч хаахгүй, хаахад нь хэн ч нээхгүй. Давидын түлхүүртэй үнэн бөгөөд ариун Нэгэн үүнийг айлдаж байна. “Би чиний үйлсийг мэднэ. Харагтун, хэн ч хааж үл чадах

нээлттэй хаалгыг Би чиний өмнө тавьсан. Юу гэвэл чиний хүч бага бөгөөд чи Миний үгийг сахьж, Миний нэрийг үгүйсгээгүй билээ. Үзэгтүн, Иудей биш атлаа өөрсдийгөө Иудей хэмээн худал яригч Сатаны синагогийн хүмүүсийг Би

ирүүлж, хөлийн чинь өмнө бөхийлгөж, Миний чамайг хайрласан гэдгийг мэдүүлнэ. Миний тэвчээрийн үгийг чи сахьсан учраас Би бас чамайг сорилтын цагаас буюу газар дээр нутаглагсдыг сорихын тулд бүх дэлхий дээр ирэх гэж буй тэр цагаас хамгаалах болно. Би удахгүй очно. Хэнд ч титмээ алдахгүйн тулд өөрт байгаагаа бат сахь. Би

ялагчийг Өөрийн Бурханы Сүм дэх багана болгоно. Тэр цаашид тэндээс гарахгүй. Би түүн дээр Өөрийн Бурханы нэр, тэнгэрээс Миний Бурханаас буун ирэх шинэ Иерусалим буюу Өөрийн Бурханы хотын нэр, Өөрийн шинэ нэрээ бичнэ. Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун.”

Хийх зүйлс

Хоосон зайг ишлэлүүдийн үгээр нөхөж бич.

1.Христийг тодорхойлох: нь хэн ч
Давидын бөгөөд Нэгэн үүнийг айлдаж байна. (Ишлэл7).

[Есүс ариун байсан. “Нүглүүдийг зайлуулахын тулд Тэр үзэгдсэн гэдгийг та нар мэднэ. Түүнд ямар ч нүгэл байхгүй. (1Иохан 3:5).Есүс үнэн байсан. “Бид тэрхүү Нэгэн болох Түүний Хүү Есүс Христийн дотор байна. Тэр бол үнэн Бурхан бөгөөд мөнх амь билээ” (1Иохан 5:206).Түүнд Давидын гэрийн түлхүүр бий.” Би түүний мөрөн дээр Давидын гэрийн түлхүүрийг тавина. Түүнийг нээхэд хэн ч хаахгүй, түүнийг хаахад хэн ч онгойлгохгүй”. (Исаиа 22:22). Давидын хүү Есүст бүх эрх мэдэл бий.]

2. Магтаал: Чиний бага бөгөөд чи Миний сахиж Миний нэрийг, Миний үгийг чи сахьсан.

3.Зэмлэл: [Есүс тэдний сул дорой байдлыг зэмлээгүй.]

4.Ялагчдад амласан амлалт: Би ялагчийг Өөрийн Бурханы сүм дэх болгоно. Тэр цаашид тэндээс Би түүн дээр Өөрийн Өөрийн Бурханы нэр, Өөрийн, нэрээ бичнэ. (12).

[Хуучин гэрээний үед сүмд хоёр онцгой багана байсан. “Тэрээр хос баганыг гол танхимын үүдний танхимд босгосон байв. Баруун талын баганыг босгож Иахин гэж нэрлэн, зүүн талын баганыг Боаз гэж нэрлэжээ. (Хаадын дээд 7:21). Үнэнч итгэгч нарт, тогтвортой байдал болон хүч өгөгддөг. Бурхан итгэгч нарыг Өөрийн ариун сүнсээр тамгалдаг. “Бас Тэр биднийг тамгалсан бөгөөд бидний зүрхэнд Сүнсийг барьцаа болгон өгсөн аж. (2 коринт 1:22).]

Филаделфи: Нээлттэй хаалгатай сүм

Филаделфи гэдэг нь “ах дүүгийн хайр” гэсэн утгатай үг. Есүс энэ чуулганы хүмүүсийг онцгойлон хайрладаг байсан. Филаделфи дахь чуулган Христэд итгэгч болон элч нарт үүд хаалга нь нээлтэй байсан. Паул шоронд байхдаа итгэгч нараас үүд хаалга нээлтэй эсэх талаар асууж байсан. “Үгэнд зориулсан хаалгыг Бурхан нээж өгөг гэж бидний төлөө нэг цагт залбирагтун. Тэгвэл бид Христийн нууцыг ярих болно. Би үүний төлөө хоригдсон билээ. (Колосай 4:3). “Учир нь миний өмнө үлэмж том, үр нөлөөтэй хаалга нээгдсэн юм. Тэнд эсэргүүцэгчид олон байгаа. (1 Коринт 16:9). Бурханы ажил цэцэглэх үед Сатан зүгээр дэмий хоосон суудаггүй. Бурханы ажлын эсрэг Сатаны синагог нар хүмүүсийг төөрөгдүүлэх, будилуулах ажлыг хийдэг. Гэвч Есүс Христэд итгэгч хүмүүст яагаад хайртайгаа хэлсэн “Тэр чиний зөв шударгыг гэрэл мэт, Чиний шударга хэргийг үд дундын гэрэл мэт илэрхий болгоно. (Дуулал 37:6). Бурхан үргэлж хайртай нэгнээ сорилтын туршид хамгаалж байдаг. Тэр итгэгч нарыг өршөөх бөгөөд уур хилэнгээ үл итгэгч нар дээр буулгана. “Бурханлаг хүмүүсийг сорилтоос яаж ангижруулахыг болон зөвт бус хүмүүсийг шүүлтийн өдрийг хүртэл шийтгэлийн доор яаж барьж байхаа Эзэн мэддэг.

(2Петр 2:9).

Сул дорой байх үед Бурхан юу хийж чадах вэ

Хэрэв чи сул дорой байвал, өөрийн хүчээр Бурхан уруу

хар. "Бидний эсрэг ирж буй энэ асар их цэргийн өмнө сул дорой билээ. Бид юу хийхээ ч мэдэхгүй байна, Харин бидний хараа тань дээр байна гэжээ. (Шастирын дэд 20:126). Есүс бид нараас Түүнтэй үргэлж хамт байхыг хүсэж байдаг учир нь бид Түүнгүйгээр юу ч хийж чадахгүйг тэр мэддэг. (Иохан15:15). "Бид ямар нэг юмыг өөрсдөөсөө гаргадаг юм шиг шаардаж чадахгүй. Харин бидний чадвар Бурханаас гардаг юм. (2 Коринт 3:5). "Харин Бурхан мэргэдийг ичээхийн тулд ертөнцийн мунхаг юмсыг сонгож, хүчит юмсыг ичээхийн тулд ертөнцын мөхөс юмсыг сонгожээ. (1 Коринт 1:27). "Тэр надад " Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөс байдал дотор "Миний" хүч бүрэн төгс болно" гэж айлдсан. Иймд би ихэд баяртайгаар мөхөс байдлуудаараа илүү сайрхана. Ингэх нь Христийн хүч миний дотор оршихийн тулд билээ.Иймд Христийн төлөө... Би хэзээ мөхөс байна, тэр үед хүчтэй байна"(2 Коринт 12:9,10). Сул дорой гэсэн сүм нь хамгийн хүчирхэг хамгийн хайртай сүм нь байдаг. "Харин Эзэнд найдагчдын хүч нь шинэчлэгдэнэ. Тэд бүргэд мэт жигүүр дээрээ элин халина. Тэд гүйхдээ үл ядран, алхахдаа үл цуцна. (Исаиа 40: 31). Бидэнд маш бага хүч байсан ч, Бурхан хэзээч биднийг дааж давашгүй сорилтоор сорьдоггүй. "Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм. (1Коринт 10:13).Тэр бидэнд хэрэгтэй сүнсний бүхий л хүч чадлыг өгдөг. "Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний Бурханлаг хүч бидэнд амь болоод бурханлаг байдалд хамаатай бүхнийг соёрхсон. (2Петр 1:3а).Зөвхөн сул дорой байгаа хүмүүс хүч чадал нь бурханаас маш их хамаардаг гэдгийг мэддэг. "Буурайгаас хүчирхэг болгогдож. (Еврей 11:34а).Бурхан Өөрөө Өөрийн хүмүүсийн хүч юм." Махан бие ба зүрх минь үгүй болж болно. Харин Бурхан бол мөнхөд зүрхний минь хүч болон миний хувь юм. (Дуулал 73:26).

ХИЧЭЭЛ 9. ЕСҮС ЛАОДИК ДАХЬ ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

Илчлэлт 3:14-22



“Лаодик дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Амен, Итгэмжит бөгөөд үнэн Гэрч болох Бурханы бүтээлийн Анхдагч нь үүнийг айлдаж байна. “ Би чиний үйлсийг хүйтэн ч биш, халуун ч биш гэдгийг чинь мэднэ. Чамайг хүйтэн юмуу, эсвэл халуун байгаасай гэж Би хүсэж байна. Тийнхүү чи халуун ч биш, хүйтэн ч биш бүлээвтэр тул Би чамайг амнаасаа бөөлжиж гаргана. Яагаад гэвэл чи “Би баян. Баяжсан тул дутах зүйл ер

байхгүй” гэдэг. Чи өөрийнхөө өрөвдөлтэй, ядуу, сохор, нүцгэн байгааг мэдэхгүй байна. Баян болохын тулд галд цэвэршүүлсэн алт, өөрийгөө хувцаслахын тулд олон нүцгэн байдлын чинь ичгүүр ил болохгүйн тулд цагаан хувцас, харахын тулд нүдээ тослох нүдний тосыг Надаас худалдаж ав гэж би чамд зөвлөө. Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм. Тиймээс зүтгэлтэй бай, гэмш. Харагтун, Би үүдэн дээр чинь зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно. Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийд заларсны адил Надтай хамт Миний сэнтийд залрахыг ялагчдад соёрхоно. Чуулгануудад сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонссогтун” гэв.

Хийх зүйлс

Хоосон зайг ишлэлүүдийн үгээр нөхөж бич.

1.Христийг тодорхойлох : “....., бөгөөд гэрч болох Анхдагч нь үүнийг айлдаж байна. (Ишлэл14).

[Амен гэдэг нь тууштай, баттай мөн итгэлтэй гэсэнэй дүйдэг. Есүс Амен хэмээн Бурханы амлалтуудыг байгуулсан. “Учир нь Бурханы бүх амлалт Түүний дотср “за” гэдэг. Тиймд бид Бурханы алдрын тулд Түүгээр дамжуулан “Амен” гэдэг. (2 Коринт 1: 20). Есүс бүхий л бүтээлийн анхдагч. “Тэр бол үл үзэгдэгч Бурханы дүр мөн бөгөөд бүх бүтээлийн Ууган нь мөн. Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс, үзэгдэх ба үл үзэгдэх юмс, хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд ч бүтээгдсэн. Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна. Тэр бүх юмсын урьд байна. (Колосай 1:15 -17). Есүс мөн бүх шинэ бүтээлийн (итгэгч нар) Эзэн. “Хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, Шинэ болсон байна. (2 коринт 5:17).]

2. Магтаал: байхгүй

3. Зэмлэл: Би чиний үйлсийг, гэдгийг чинь мэднэ. (5) Чи тул чамайг амнаасаа гаргана. Чи өөрийгөө гэдэг. тул дутах зүйл гэдэг. Чи өөрийнхөө хөөрхийлөлтэй, өрөвдмөөр байгааг мэдэхгүй байна.

4.Ялагчдад амласан амлалт: Ялагчдад би Эцэгийнхээ хамт Түүний сэнтийд адил Надтай хамт миний ялагчдад соёрхоно.

[“Тэр намайг хайрласан учраас Би түүнийг аварна. Тэр Миний нэрийг мэдсэн учраас Би түүнийг өргөмжилнэ. (Дуулад91:14). “Хэрэв бид тэвчвэл, Түүнтэй хамт хаанчлах болно.(2 Тимог 2:12а).” Өчүүхэн сүрэг өз, бүү ай. Учир нь Эцэг тань хаанчлалаа та нарт өгөхийг баяртайгаар сонгосон юм. (Лук 12:32).]

В. Илчлэлт 3:20 бичээд цээжил.

Лаодик: Бүлээвтэр чуулган

Лаодик гэдэг нь хүмүүсийн эрх эсвэл хүмүүс удирдах гэсэн утгатай. Нэг үгээр хэлбэл энэ сүм эрх чөлөөтэй байсан бөгөөд Сүнслэг удирдагч нар болон Бурханы үгийг дагахаа больсон байв. Лаодик Колоссе болон Хиераполын хажуудах хөндийд байралдаг байсан. Мөн сургаал номлогч Паул хэлэхдээ Ефапр энэ хотын чуулганы төлөө маш их хүчин чармайлт гаргаж байсныг дурдсан. (Колоссай 4:12,13). Хиераполоос эмчилгээний зориулалттай халуун ус гардаг байв. Гэвч Лаодик усан хоолойгоор усаа авдаг байсан. Ус Лаодикт ирэхэд бүлээн болж ирдэг байв. Есүс энэ чуулганыг бүлээвтэр гэж тодорхойлсон. Есүс Лаодик дахь чуулганы үйлсийг бүлээвтэр учраас бөөлжиж гаргана гэж хэлсэн. Өөрийгөө ихээр өргөмжилсөн энэ чуулганыг Есүс ямарч үгээр магтаагүй юм.

Хөрөнгө Мөнгөний аюул



Лаодик дахь энэ чуулган хөрөнгө мөнгөнөөс өөр сүнсэнд юу хэрэгтэй байдгийг мэддэггүй байсан бололтой. Судар бид нарт эд баялгаас болгоомжлохыг анхааруулсан байдаг." Хэрэв Бидэнд хоол хүнс хувцас хунар байвал эдгээрээр бид сэтгэл хангалуун байх болно. Харин баяжих хүсэлтэй хүмүүс сорилтод ба урхи, мөн зүсэн бүрийн мунхаг, хор хөнөөлтэй хүсэлд унадаг. Эдгээр энэ хүмүүсийг сүйрэлд хүргэдэг. Учир нь мөнгөний хайр бол бүх бузар муугийн үндэс юм. (1 Тимот 6:8-10а). Хэрэв бид дэлхий дээр эд баялаг эзэмшиж байвал энэ бүгдийг Бурхан өгсөн гэдгийг санагтун. (Дэд хууль 8:18). Битгий зүрх сэтгэлдээ хүс. Бурханаар өөрийгөө удирдуул. Тэгвэл чи баяр хөөр, ерөөлийг олох болно." Та нарын эд баялаг хаана байна, зүрх сэтгэл чинь тэнд байна. (Матай 6:21).

Хэрхэн сүнсний ядуурлаас гарах вэ

Лаодик дахь чуулган сүнсээр ядуу, сохор, нүцгэн байсан. Гэвч юу хийх ёстойг Есүс хэлсэн:

1. Баян болохын тулд надаас галд цэвэршүүлсэн алт худалдан ав.

(Доор байгаа бүлгээс тайлбарыг харна уу).

2. Ичгүүр чинь ил болчихгүйн тулд надаас цагаан хувцас худалдан ав.

3. Харахын тулд нүдний тосыг надаас худалдан ав. Хөрөнгө мөнгөтөй чуулгануудад энэ үг хичнээн тохирсон байна вэ!

Бид Бурханы үгийг хичээнгүйлэн сонсох үедээ Түүнээс хангалттай сүнс авах болно." Цангасан хүн бүр ус уруу ирэгтүн. Мөнгөгүй хүн бүр ирж, худалдан авч идэгтүн. Намайг анхааралтай сонсож сайныг нь ид, элбэг хангалуун өөрийгөө жаргаа. (Исаи :551а,26).

(1) Галд цэвэршүүлэгдсэн алт

Бурханд алтнаас илүү үнэтэй юу байдаг вэ?

"Ингэснээрээ та нарын итгэлийн баталгаа нь галаар тунгаагдах боловч мөхөх алтнаас ч илүү үнэтэй байн, Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм. Та нар Түүнийг хараагүй боловч Түүнийг хайрладаг. Эдүгээ та нар Түүнийг харахгүй байгаа боловч, Түүнд итгэдэг. Та нар хэлэхийн аргагүй, алдраар дүүрэн баяр хөөрөөр ихэд баярладаг. (1Петр 1:7-8). Өөрийн амьдралдаа жинхэнэ сүнслэг байдлаар амьдарвал Христийн баяр хөөр бидэн дээр ирдэг.

(2) Бидний ичгүүрийг нуух цагаан дээл

Бидэнд ямар сүнслэг хувцас хэрэгтэй вэ? "Би шударга зөвийг өмсөж, тэр намайг хувцаслав. (Иов 29:14а). Есүс бидэнд зөв шударгаар авралын нөмрөгийг өгдөг. Хуучин гэрээний үед Иошуа Сатаны эсрэг байсан. Бурхан Сатаныг зэмлэж Иошуаг дуудсан. "Иошуа бузар муу хувцас өмссөн байх бөгөөд тэнгэр элчийн өмнө зогсож

байв. Тэнгэр элч өөрийнхөө өмнө зогсогчдод хандан Түүнээс бузар муу хувцсыг нь тайлан ав гээд түүнд дахин Харагтун, Би чиний гэм бурууг чамаас авч , ёслолын дээлээр чамайг хувцаслана гэв. (Зехариа 3:3-4). Бурхан бидний өмссөн бузар гэмтэй хувцсыг зайлуулан бидэнд баян гайхамшигтай нөмрөгийг өгдөг. Түүний хайр нигүүлсэл хичнээн гайхалтай вэ! Бид хэзээ ч өөрсдийн үйлсээр үүнийг олж авч чадахгүй. Зөвхөн Христ Бурханы зөв шударга болзлыг хангаж чадна. “Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин Өөрийнхөө ершөөлийн дагуу шинэтгэлийн угаал ба Ариун Сүнсний сэргээлтээр аварсан юм. (Тит 3:5).

Бид Түүний зөвт байдлыг хэрхэн олж авч чадах вэ? “Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ. (Ром 10: 9-10).

Христийг зүрх сэтгэлдээ хүлээн авч Түүний дотор алхвал бид Түүнийг бидний гэмийн төлөө үхэж бидэнд шинэ амьдрал өгсөнийг мэдэх болно.

(3) Хараа өгөх нүдний тос

Есүс дэлхий дээр байхдаа сохор хүнийг эдгээсэн. Есүс мөн сүнсний сохор байдалд сүнсний хараа өгөх гэж ирсэн.

“Хэрэв бидний сайн мэдээ нууцлагдсан бол энэ нь мөхөж буй хүмүүсийн хувьд нууцлагдсан хэрэг. Энэ үеийн бурхан үл итгэгчдийн бодол санааг сохолсон учраас тэд Бурханы дүр болох Христийн алдрын сайн мэдээний гэрлийг үзэж чадахгүй болжээ. (2 коринт 4:3-4). Гэмтэй хүн бүр харанхуй дотор алхдаг.

“Харин ах дүүгээ үзэн яддаг нэгэн бол харанхуйн дотор байгаа. (1 Иохан 2:11). Харин бид Христийг хүлээн авахад энэ бүх харанхуй гэрэл болдог. “Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав. (Иохан 8:12a).

Есүс хайрладаг хүмүүсээ сахилгажуулдаг

Есүс чамайг сахилгажуулж эсвэл зэмлэж байна уу? Тэр чамд хайртай учраас ингэдэг юм." Хүү минь Эзэний сахилгажуулалтыг бүү дургүйц, зэмлэлийг нь бүү огоор. Учир нь хүүгээ таалдаг эцэг хүний адил Эзэн хайрладаг хүнээ зэмлэдэг юм. (Сургаалт үгс 3:11,12).

"Харин бид шийтгэгдэхдээ Эзэнээр сахилгажуулагддаг. Ингэснээр бид ертөнцтэй хамт яллагдахгүй юм. (1 Коринт 11:32).

Бидний тэнгэрлэг эцэг биднийг хайр дотор хүмүүжүүлдэг. "Тэр бидний сайн сайхны төлөө ажээ. Тэгснээр бид Түүний ариун байдлыг хуваалцах юм. (Еврей 12:10б). Бурхан бид нарыг зөвт байлгахын тулд хайраар сахилгажуулдаг нь хичнээн сайхан бэ!

Сүнс юу хэлж байгааг сонс

Есүс дэлхий дээр байхдаа амлалтыг орхиод явсан. "Харин Туслагч буюу Миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлсийг заах бөгөөд Миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно. (Иохан 14:26). Есүс дагалдагч нартаа Ариун Сүнсний тухай мэдүүлэх болно хэмээн амласан учир нь сүнс зөвхөн хамт байгаад зогсохгүй тэр бидний дотор амьдрана. (Иохан 14:17). Ариун Сүнс чиний дотор байх үед, Тэр чамайг гэм болон шүүлтээс чөлөөлөх болно." Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш. (Ром 8:9 б). Магадгүй та Лаодик шиг байж болох юм. Энэ хичээл таныг сүнсний ядуу байдал, сохор, нүцгэн байдлыг чинь ойлгуулсан байх. Та Бурханы Ариун Сүнс таны дотор байхгүйг ухамсарласан. Гэвч Христ нигүүслээр дүүрэн бөгөөд та сүнсний хараагаар шинэ хувцас өмсөнө. Христ таны дотор амьдрахад та шинэ бүтээл болдог. Энэ таны зүрхний хүсэл биш гэж үү? Есүсээс ирсэн энэ захидал танд сайн мэдээ юм. Есүс хэлэхдээ "Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр

надтай хамт хооллоно. (Илчлэлт 3:20). Тэр таны зүрхний хаалгыг тогшиж байна. Тэр тантай хамт байж нөхөрлөхийг хүсэж байна. Та яг одоо зүрх сэтгэлээ нээж байна уу? Зүрх сэтгэлд тань орж ирэхийг түүнээс гуй. Хэрэв та залбирах хэрэгтэй бол энэ залбирал таныг удирдаж чадна. Баяр хөөр амар амгалан танд байх болтугай!



Эзэн Есүс минь
Миний төлөө үхэж миний гэмийг загалмайд цовдолсон Танд баярлалаа. Би гэмтэй гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Би бүхий л хийсэн буруугаасаа уучлалт гуйж байна. Би танаас өршөөл энэрэлийг гуйж байна. Эзэн минь та миний зүрх сэтгэлийг ариусгаач. Би таныг зүрх сэтгэлдээ аврагчаа болгон хүлээн авч байна.

**Есүсийн нэр дээр,
Амен.**

**I have received
life through Jesus!**

name

date

ХИЧЭЭЛ 10. ИОХАН БУРХАНЫ ХААНЧЛАЛЫГ ХАРСАН НЬ

Илчлэлт 4:1-11



“Үүний дараа би тэнгэрт нээлттэй хаалгыг харав. Анх надтай ярьсан бүрэн дуу мэт сонсогдсон тэр дуу

-Наашаа гараад ир. Үүний дараа юу тохиолдох ёстойг Би чамд үзүүлэе гэлээ. Тэр даруй би Сүнс дотор байв. Харагтун, Тэнгэрт сэнтий байсан бөгөөд сэнтийнд залрагч Нэгэн байв. Залрагч нь хаш чулуу ба молор эрдэнэ мэт дүртэй ажээ. Сэнтийг нь маргад эрдэнэ мэт үзэгдэх солонго хүрээлжээ. Сэнтийний эргэн тойронд хорин дөрвөн сэнтий байх бөгөөд цагаан хувцас өмссөн, толгойдоо алтан титэмтэй хорин дөрвөн ахлагчид мөнөөх сэнтийнүүдэд сууж байв. Сэнтийнээс аянгын гялбаа, нижигнээн, тэнгэрийн дуун гарав.

Бурханы долоон Сүнс болох долоон дэвлүү сэнтийний өмнө асаж байв. Сэнтийний өмнө болор адил шилэн тэнгис байлаа. Сэнтийний дунд болон эргэн тойронд нь ар өвөртөө дүүрэн нүдтэй дөрвөн амьтан байх ажээ. Эхний амьтан нь арслан адил, хоёр дахь амьтан нь тугал адил, гурав дахь амьтан нь хүнийх шиг нүүртэй, дөрөв дэх амьтан нь нисэж буй бүргэдтэй адил байв. Тус бүр нь зургаан далавчтай тэр дөрвөн амьтан нь дотроо болон эргэн тойрондоо дүүрэн нүдтэй. Тэд өдөр шөнөгүй тасралтгүйгээр

-Байсан, байгаа мөн хожим ирэх Төгс хүчит Эзэн Бурхан ариун, ариун, ариун гэж хэлэх аж. Амьтад нь сэнтийд залрагч ба үеийн үед амьд байгч Түүнд алдар, хүндэтгэл, талархлыг өргөхөд хорин дөрвөн ахлагч сэнтийд залрагчийн өмнө унацгааж, үеийн үед амьд байгч Түүнд мөргөх бөгөөд титмүүдээ сэнтийн өмнө шидээд

-Бидний Эзэн ба Бурхан минь Та алдар, хүндэтгэл,


хүчийг авах нь зохистой. хүслийн улмаас тэдгээр нь
Учир нь Та бүх юмсыг оршсон бөгөөд бүтээгдсэн
бүтээсэн билээ. Таны юм гэх ажээ.

Бурханы хаанчлал

“Эзэн өөрийн сэнтийг тэнгэрт залсан бөгөөд Түүний хаанчлал бүхнийг захирдаг.(Дуулал 103:19). Хичнээн их амар амгалан бэ! Сэнтийг маргад эрдэнэ мэт үзэгдэх солонго хүрээлсэн нь хичнээн сайхан бэ! Ноагийн үед Бурхан дэлхий дээр үер буулгасан ч дараа нь Тэр өршөөл үзүүлсэний тэмдэг болгон солонго гаргасан.” Намайг газар дээр үүл хуралдуулахад, тэр үүлэн дээр солонго харагдахад, Би Миний болон та нарын, мах цусны бүх амьтны хооронд байгуулсан өөрийн гэрээг санан дурсах болно. Ус хэзээ ч цустай бүхнийг устгах үер болохгүй. (Эхлэл 9:14,15) Бурхан санадаг! Тэр уурлаж байхдаа хүртэл өршөөхөө санадаг. (Хабаккук 3:2). Сэнтийнүүдэд сууж байгаа хорин дөрвөн ахлагч нь нэр төрөө эргүүлэн олж авсныг төлөөлдөг бөгөөд тэд нар цагаан нөмрөг мөн титэм (шагнал) авсан байдаг. Тэд дэлхийг хаанчлах болно. (Илчлэлт 5:9, 10)

Дөрвөн амьтан нь өдөр шөнөгүй Бурханы ариуныг тунхагладаг. Эдгээр амьтад эш үзүүлэгч Езекиелд харагдсан. Тэр тэднийг херубууд байна гэж таньжээ. (Езекиел 10:20).

Энд байгаа дүр зураг Хуучин Гэрээний үеийн дугантай төстэй. (Энэ нь жинхэнэ тэнгэрлэг дуганы илэрхийлэл байсан.) Бурханы тахилын ширээний өмнө байгаа долоон дэнлүү нь долоон тийшээ салаалсан дэнлүүний суурин дээр суурилсан байдаг. Далайн 7 хундага нь аягатай (угаалгын аяга) зохицох



агаад хаан ширээ нь Бурханы оршихуй оршиж байсан гэрээний авдартай адил. Дуган дотор үйлчилж байгаа 24 тахилч нь 24 ахлагчийг илэрхийлдэг. Нигүүслийн суудал дээр буй нуман хэлбэртэйгээр байрласан херубууд нь уг амьтнуудтай адилхан. Тэдгээр тэнгэрлэг хүндлэгч нар өөрсдийн титмийг бүх магтаалыг авах зохистой Бурханы өмнө хаялаа. Учир нь Тэрээр бүхнийг бүтээгч. Бурхан биднээр үйлчлүүлэх туйлын зохистой нэгэн. "Иймд ах дүү нараа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл нь мөн. (Ром 12:1)

ХИЧЭЭЛ 11. ТАМГАЛАГДСАН ХУЙЛМАЛ

Илчлэлт 5:1-14

"Сэнтийнд Залрагчийн баруун мутарт дотор нь болоод ар дээр нь бичсэн, долоон тамга дарж лацадсан хуйлмал ном байхыг би үзэв. Мөн

-Хэн хуйлмал номыг нээж лацнуудыг нь эвдвэл зохистой вэ? хэмээн чанга дуугаар тунхаглаж буй хүчит тэнгэр элчнийг би харав. Тэнгэрт ч, газарт ч, газрын доор ч хэн ч тэрхүү хуйлмал номыг нээж, доторхыг нь үзэж чадсангүй. Хуйлмал номыг нээж, доторхыг нь үзэх зохистой хүн нэг ч олдоогүй тул би ихэд уйлав. Ахлагчдын нэг нь надад

-Уйлахаа боль. Харагтун, хуйлмал номыг болон

долоон лацыг нь нээхийн тулд Иудагийн овгийн Арслан буюу Давидын Үндэс ялсан юм гэлээ. Тэгээд би сэнтий болоод дөрвөн амьтны хооронд, ахлагчдын дунд зогсож буй нядлуулсан мэт Хургыг харав. Тэр Хурга долоон эвэр болон долоон нүдтэй бөгөөд долоон нүд нь дэлхий даяар илгээсэн Бурханы долоон Сүнс юм. Тэр Хурга ирээд Сэнтийнд залрагчийн баруун мутраас авав. Түүнийг хуйлмал номыг авахад дөрвөн амьтан болон хорин дөрвөн ахлагч Хурганы өмнө унацгаав. Тэд тус бүр ятга болон утлагаар дүүрэн алтан савтай аж. Тэдгээр нь ариун хүмүүсийн

залбирлууд юм. Тэд шинэ дуу дуулж

-Хуйлмал номыг авч, лацнуудыг эвдэх зохистой нь Та мөн.

-Учир нь Та нядлуулсан бөгөөд бүх овог, хэл, ард түмэн болон үндэстнүүдээс хүмүүсийг Бурханд Өөрийнхөө цусаар худалдан авч өгсөн билээ.

-Та тэднийг бидний Бурханы төлөөх хаанчлал ба тахилч нар болгосон. Тэд дэлхий дээр хаанчлах болно гэцгээж байлаа. Би харж, сэнтий, амьтад, ахлагчдын эргэн тойронд олон тэнгэр элчийн дууг сонсов. Тэдний

тоо түм түмээрээ, мянга мянгаараа ажээ. Тэд чанга дуугаар

- Нядлуулсан Хурга хүч, баялаг, мэргэн ухаан, сүр хүч, хүндэтгэл, алдар ба магтаалыг авбал зохистой гэцгээж байлаа. Тэнгэрт, газар дээр, газар доор, тэнгис дээр байгаа аливаа бүтээгдсэн юмс болон тэдгээрийн дотор байх бүх юмс

- Сэнтийнд залрагчид ба Хурганд магтаал, хүндэтгэл, алдар, ноёрхол нь үеийн үед байх болтугай гэлцэхийг нь би сонсов. Дөрвөн амьтан нь

- Амен гэсээр байлаа. Ахлагчид унаад мөргөв.

Хуйлмал номыг нээх зохистой нь хэн бэ?

Долоон тамга дарж лацлагдсан хуйлмал ном байв. Ромын хуулийн дагуу амьдрал үхэлтэй холбоотой чухал баримтыг долоон удаа лацладаг байсан. Яагаад энэ хуйлмал чухал байна вэ? Олон библи судлаачид дэлхий дээр болж байгаа үйл хэрэг гэж үздэг. Адам гэмтэй болсноос хойш бүх бүтээл Сатан болон үхэлд боолчлогдсон. Адамын угсааны хэн ч үүнийг өвлөж авч чадахгүй. Энэ лацыг онгойлгох хэн ч олдсонгүй. Иохан уйлав. Энэ дэлхий дээр хэн үүнийг хөдөлгөж чадах вэ? Бурханд баярлагтун! Бүх уйлаан дуусгавар болж энэ дэлхийг захирагч зохистой нэгэн болох Эзэн Есүс Христ лацыг хөдөлгөхөөр гарч ирэв.

Еврейн газар эзэмших системд зөвхөн ойрын хамаатан газраа алдсан эзэний газрыг эргүүлэн авдаг байсан. Рүүтын түүх энэ хуулин дээр үндэслэгдсэн байдаг. Есүс бидний Аврагч, биднийг өөрийн цусаараа Бурханд эргүүлэн

авчирсан. Бурханы хүү “бүхний өвлөгчөөр томилогдсон...”
(Еврей 1:2). Тэр цорын ганц чөлөөтэй бүтээгч!

Есүс, Иуда овгийн Арслан

Есүс Иуда овгийн хүн байсан, тодорхойлбол яг арслан шиг. “Иуда чи бол арслангийн гүег
” Шилог иртэл хааны таяг Иудагаас салахгүй. (Эхлэл 46:9а,10б). Иудагийн арслан Есүс ноёлсон юм. Есүсийг төрөхөөс өмнө тэнгэр элч



Габриел онгон Мариад хэлсэн нь “Үзэгтүн, чи хэвлийдээ үртэй болж хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно. Тэр Хүү агуу Нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана. Эзэн Бурхан Түүнд өвөг Давидынх нь хаан ширээг өгөх болно Түүний хаанчлалд төгсгөл байхгүй. (Лук 1:31-33).

Есүс нядлагдсан хурга

Иохан арсланг харах гэж байгаад, тэр нядлагдсан хургыг олж харав. Арслан хурга байсан! Хурга бидний гэмийн төлөө дэлхий дээр үхсэн. Баптисм хүртээгч Иохан Иордан гол дээр Есүсийг ийнхүү хэлэн танилцуулсан “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун!” (Иохан 1:29б). Есүс дахин амилсан бөгөөд бүгдийг захирах, номыг нээх, ертөнцийг шүүх зохистой нэгэн юм. Эш үзүүлэгч нар Есүсийн зовох мөн алдаршуулагдахыг урьдчилан хэлж байсан. (1 Петр 1:11). “Тэр тамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй. Алагдахаар хөтлөгдөх хурга шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг тэр амаа нээсэнгүй” (Исаиа 53:7). Одоо ялгуулсан хурга маш хүчтэй (Долоон эвэр, хүч чадал эрх мэдлийг илэрхийлдэг) бүгдийг мэдэгч (Долоон нүд, төгс мэргэн ухааныг илэрхийлдэг).

Есүсийн дагалдагч бид нар, магтаалаас өмнө зовохыг таамаглаж мэдэж болно. “Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. Харин та нар Христийн зовлонгуудыг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгээр баярлах юм” (1 Петр 4:12,13).

Бүх бүтээл Бурханыг магтан дуулж байна.

Дууны нэр “Алдаршуулагдсан хурга!” Хурга дэлхий дээр байхдаа үзэн ядагдаж үгүйсгэгдсэн. Гэвч одоо Тэр талархлыг авч байна. “Тэр мөхөс байдлаас болж цовдлогдсон боловч Бурханы хүчээр амьд байна. (2 Коринт 13:4а). Хурганы хувьд Тэр загалмай дээр үхэж байхдаа хүртэл дуулгавартай байсан. “Тиймээс ч Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн бөгөөд аливаа нэрнээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд тэнгэрт байгаа, газар дээр байгаа, газрын доор байгаа бүх юмс өвдөг сөгдөж, мөн бүх хэл Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж хүлээн зөвшөөрөх ёстойн учир ажээ. (Филлипой 2:9-11). Бүх бүтээл Түүний өмнө бөхийх болно. Бид Түүнийг өөрийн Эзэн хэмээн яг одоо сөгдье!

Есүс бидний зүрх сэтгэлийг хаанчлахад бидэнд шинэ баяр хөөр ирж, өөрийн Аврагч Эзэндээ талархлыг өргөдөг. “Эзэнд шинэ дууг дуулагтун. Бүх дэлхий Эзэнд дуулагтун. (Дуулал96:1).” “Эзэнд шинэ дууг дуулагтун. Учир нь Тэрбээр гайхамшигт зүйлсийг үйлдсэн. (Дуулал98:1). Та Бурханд талархан дуулж байна уу? “Магтаал хүндэтгэлийн Эзэнийг дуудахад дайснуудаасаа би аврагддаг. (2 Самуел 22:4).”

ХИЧЭЭЛ 12. ХУРГА ЭХНИЙ ЗУРГААН ЛАЦЫГ ЭВДЭВ.

Илчлэлт 6:1-17

“Хурга долоон лацны нэгийг эвдэхийг би харав. Би мөн дөрвөн амьтны нэг нь	Ирэгтүн гэж аянгын дуун лугаа адил хэлэхийг сонслоо. Харагтун, Би нэгэн цагаан
--	---

морь харлаа. Түүнийг унасан нэгэн нь нумтай байсан бөгөөд түүнд титэм өгөгдөв. Тэр ялахын тулд ялсаар гарч ирэв. Тэр хоёр дахь лацыг эвдэх үед хоёр дахь амьтан нь

- Ирэгтүн, гэж хэлэхийг би сонслоо. Өөр нэгулаан морь гарч ирэв. Түүнийг унасан нэгэнд дэлхийгээс энх тайваныг булаан авах эрх болон хүмүүс бие биеэ алахыг соёрхсон бөгөөд түүнд том илд өгсөн байв. Түүнийг гурав дахь лацыг эвдэхэд, гурав дахь амьтан нь

-Ирэгтүн гэхийг би сонсов. Харагтун, би нэгэн хар морь харлаа. Түүнийг унасан нэгэн нь гартаа хос дэнс барьсан байв. Нэг денарт нэг хэмжүүр улаан буудай, нэг денарт гурван хэмжүүр арвай болно. Тос болон дарсыг бүү сүйтгэ гэж дөрвөн амьтны дундаас гарах мэт дууг би сонсов. Түүнийг дөрөв дэх лацыг эвдэхэд

- Ирэгтүн гэх дөрөв дэх амьтны дууг би сонсов. Харагтун, би цайвар ногоон морь харлаа. Түүнийг унасан нэгний нэрийг “Үхэл” гэдэг бөгөөд Үхэгсдийн орон түүнийг дагаж байлаа. Илд, өлсгөлөн, тахал, газрын

зэрлэг араатнуудаар хөнөөлгөхийн тулд дэлхийн дөрөвний нэгийг захирах эрх мэдэл тэдэнд өгөгдсөн байв. Түүнийг тав дахь лацыг эвдэх үед, Бурханы үг болон өөрсдийн сахьсан гэрчлэлээс болж алагдсан хүмүүсийн сүнснүүдийг тахилын ширээн доор байхыг би харав. Тэд чанга дуугаар Ариун ба үнэн Эээн, Та хэдий хүртэл шүүхгүй, газар дээр нутаглагчдаас бидний цусны өшөөг авахгүй юм бэ? гэж хашхиран байлаа. Тэдэнд тус бүрд нь цагаан дээл өгсөн байлаа. Өөрсөдтэй нь адил алагдах ёстой хамтран зүтгэгчид болон ах дүүсийх нь тоо гүйцэх хүртэл дахиж түр зуур амрах ёстой гэж тэдэнд хэлсэн ажээ. Түүнийг зургаа дахь лацыг эвдэх үед би харж байлаа. Асар хүчтэй газар хөдлөлт болж, нар хялгасаар хийсэн таар мэт харлаж, сар бүхэлдээ цус мэт улаан болов. Хүчтэй салхи сэгсэрэхэд боловсроогүй жимсээ инжрийн мод хаялах адил тэнгэрийн одод дэлхий дээр унж, хуйлсан хуйлмал ном лугаа адил тэнгэр ч заагдан салж, алив уулс, арлууд ч байрнаасаа хөдөлсөн байлаа. Дэлхийн

хаад, агуу хүмүүс, мянгатын дарга нар, баячууд, хүчтэнүүд, боол хийгээд чөлөөт хүн бүр агуй болоод уулсын хавцалд нуугдацгааж, уулс ба хадан цохионуудад хандан Бидний дээр унаж,

биднийг сэнтийнд залрагчийн нүүрнээс, Хурганы уур хилэнгээс далдлаач. Тэдний уур хилэнгийн агуу өдөр нь иржээ. Хэн тэсэж чадах вэ? гэгцгээв.

Хийх зүйлс

Хоосон зайг ишлэлүүдийн үгээр нөхөж бич.

1. Эхний лацыг эвдэхэд Иохан нэгэн морь харлаа. Түүнийг унасан нэгэн нь байсан бөгөөд түүнд өгөгдөв. Тэр ялахын тулд ялсаар гарч ирэв. (ишлэл2).

2. Хоёр дахь лацыг эвдэхэд өөр нэг морь гарч ирэв. Түүнийг унасан нэгэнд дэлхийгээс булаан авах эрх болон хүмүүс бие биеэ алахыг соёрхсон бөгөөд түүнд том өгсөн байв.

3. Гурав дахь лацыг эвдэхэд Иохан нэгэн морь харав. Түүнийг унасан нэгэн нь гартаа хос барьсан байлаа.

4. Дөрөв дахь лацыг эвдэхэд морь харлаа. Түүнийг унасан нэгний нэрийг гэдэг бөгөөд түүнийг дагаж байлаа., хөнөөлгөхийн тулд эрх мэдлийг өгсөн байлаа.

5. Тав дахь лацыг эвдэхэд Иохан хүмүүсийн дээр байхыг харав. Хүмүүс ямар шалтгааны улмаас нядлагдсан (алагдсан) бэ?

(А)

(Б)

6. Зургаа дахь лацыг эвдэхэд Хурганы уур хилэн ирэх өдөр ирнэ. Ямар долоон зүйл болох вэ?

А. Асар хүчтэй

Б. Нар хялгасаар хийсэн таар мэт

В. Сар бүхэлдээ мэт болов.

Г. Одод дэлхий дээр

Е.Тэнгэр ч заагдан

Ё. Алив, байрнаасаа
хөдөлсөн байна.

Ж. Дэлхийн бүх хүмүүс уулсын хавцалд,
биднийг сэнтийд Залрагчийн, Хурганы
.....

Эхний лац: Цагаан морь унасан нэгэн

Зарим хүмүүс энэ үзэгдлийг Христ болон түүний сүм энэ дэлхий дээр ирж сургаалаа зааж байна хэмээн дүрсэлдэг. Титэм өмссөн Христ Ургацаа хадах гэж ирэх нь тодорхой юм. Тэр цагаан морь унан өөрийн дагалдагч нартайгаа хамт дэлхийг эцсийн удаа шүүх гэж ирнэ. (Илчлэлт 19:11). Тэр ялах гэж мөн Сатаны цайзыг нураах гэж ирнэ. "Би өөрийн чуулганыг босгох бөгөөд Түүнийг үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. (Матай 16:186)." Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжуулан давуулан дийлдэг. (Ром 8:37). Бусад хүмүүс морь унагчийг хуурамч Христ, Анти-Христийн сүнс хэмээн тайлбарладаг. Энэ сүнс дэлхийг дипломат энх тайвны аргаар эзэлж авна. (түүнд нум байвч сум байхгүй) буруу энх тайван ирэх болно. "Амар тайван, аюулгүй байдал" гэж ярьж байх үед тэдэн дээр сүйрэл нь гэнэт ирнэ. (1 тесалоник 5:3а). Есүс ийм цаг ирэхийг анхааруулж байсан: "Хэн нэгэн нь та нарыг төөрөлдүүлэх вий, болгоомжил. Учир нь олон хүн "Би бол Христ" хэмээн миний нэрээр ирж, олныг төөрөлдүүлнэ. (Матай 24:46, 5). "Хуурамч Христүүд хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, хэрэв боломжтой бол сонгогдогсдыг хүртэл төөрөлдүүлэхийн тулд агуу тэмдгүүд, гайхамшгуудыг харуулах болно. (Матай 24:24).

Хоёр дахь лац: Улаан морь унасан нэгэн

Дайн болон дайны заналхийлэл дэлхийгээс энх тайвныг авах болно. "Хилэнцтэнд амар амгалан байхгүй" гэж миний Бурхан айлдаж байна. (Исаиа 57:21). "Та нар дайн болоод



дайны сураг чимээг удахгүй сонсоно. Айж сандруузай. Тэдгээр нь зайлшгүй болох учиртай бөгөөд төгсгөл нь хараахан биш юм. (Матай 24:6).

Гурав дахь лац: Хар морь унасан нэгэн

Дайн ихэнхдээ өлсгөлөн авчирдаг. Морь унагчийн гарт нь байгаа энэ дэнс, эдийн засгийг удирдаж байгааг харуулж байна. Хоол маш ховор байх бөгөөд нэг өдрийн цалин нэг кварт буудай л авахад хүрнэ. Есүс ингэж зөгнөсөн : “Энд тэндгүй өлсгөлөн болоод газар хөдлөлт болно. (Матай 24:7а). Хар, Африкт олон сая хүн иргэний дайнаас болж аль хэдийн өлсгөлөнгөөр үхээд байна.

Дөрөв дахь лац: Цайвар ногоон морь унасан нэгэн

Дэлхийн дөрөвний нэгийг захирах эрх мэдэл түүнд өгөгдсөн. Үхэл (махан биеийн үхэл) мөн Там (Сүнсний үхэл). Түүнд (1) сэлэм (хүчирхийлэл ба дайн), (2) өлсгөлөн (ядуу тарчиг байдал), (3) үхэл (хортон шавьж, тахал, байгалийн гамшиг) мөн дэлхийн араатанг захирах эрх мэдэл өгөгдсөн. Дэлхийн эмх замбараагүй байдал болон амьтны тахал хүн төрөлхтөнд их хохирол учруулсан. Харх хүмүүст дайнаас ч илүү үхэл авчирсан. Арван дөрөвдүгээр зууны үед хархнаас үүдэлтэй тахал Европын хүн амын гуравны

нэгийг хөнөөсөн. Есүс үүнийг анхааруулж байсан. “Энд тэндгүй өлсгөлөн болоод газар хөдлөлт болно. Харин энэ бүгд нь төрөх өвдөлтийн эхэн юм. (Матай 24:7б, 8).

Тав дахь лац: Бурханы үг болон өөрсдийн гэрчлэлээс болж алагдсан хүмүүс ил болсон нь

Бурхан алагдсан хүмүүст хандан өөрсөдтэй нь адил алагдах ёстой ахан дүүсийнх нь тоо гүйцэх хүртэл хүлээж байхыг сануулсан. Есүс энэ тухай урьдаас мэдэн хэлсэн: “Тэгэхэд хүмүүс та нарыг зовлон гамшигт тушааж та нарыг ална. Миний нэрээс болж та нарыг бүх үндэстэн үзэн ядах болно. Тэр үед олон хүн бүдрэх бөгөөд нэг нэгнээ тушааж, үзэн ядна. Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж олныг төөрөлдүүлнэ. Ёс бус байдал өссөнөөс болж олонх хүмүүсийн хайр хөрнө. Харин эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно. Хаанчлалын энэхүү сайн мэдээ бүх үндэстэнд гэрчлэл болж дэлхий даяар тунхаглагдана. Тэгээд төгсгөл ирнэ. (Матай 24:9-14). Үнэн үг дэлхийн өнцөг булан бүрт хүрэхэд, Итгэгч хүмүүс итгэлээсээ болж урьд хожид байгаагүйгээр үхэх болно. Итгэгч хүмүүс хавчлага үхэл тохиолдохыг мэдэх ёстой. Урьдах зуунуудыг нийлүүлсэнтэй тэнцэх хэмжээний итгэгч нар Хорьдугаар зуунд итгэлээсээ болж алагдсан. Зарим Библийн номыг уншихад хавчлага, үхэлтэй нүүр тулж байгаа тухай гардаг.

Есүс бидэнтэй хамт байна гэж амласан, Тэр биднийг хавчиж байгаа хүмүүст яаж хандахыг хэлсэн. “Харин би та нарт хэлье. Дайснуудаа хайрла. Та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир. (Матай 5:44). Гэсэн хэдий ч Тэр ирж залбирсан хүмүүсийг аврах гэж дайснуудыг шүүх болно.” Дэлхийн Шүүгч ээ босож бардамнагчдад нөхөн төлөөч, Хэдий болтол хорон муу хүмүүс баярлаж цэнгэх вэ? тэд Таны хүмүүсийг бяцалж,

Таны өв залгамжлалыг зовоодог. (Дуулал 94:2-5).

Хавчлаганд өртсөн хүмүүст амласан амлалт

Есүс өөрийг нь хавчсан хүмүүст гайхалтай хандаж байсан.

“Түүний нэрийн төлөө доромжлогдон зовох нь зохистой гэж үзэгдэх болсондоо баярлалдан тэд Зөвлөлөөс гарч явлаа. (Үйлс 5:41).

“Харин та нар зөвт байдлын төлөө зовлон эдлэхэд хүрлээ ч, та нар ерөөлтэй. Тэдний сүрдүүлгээс бүү ай., бүү зов. (1Петр 3:14).

“Хэрэв та нар Христийн нэрээс болж зүхэгдвэл ерөөлтэй. Учир нь алдрын ба Бурханы Сүнс та нарын дээр оршдог. (1Петр 4:14).

Есүс чиний төлөө энэ үгийг хэлж байна. “Зөвт байдлын төлөө хавчигдсан хүмүүс ерөөлтэй еэ, Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм. Надаас болж та нарыг хүмүүс доромжилж, хавчиж, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй еэ. Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа. Учир нь та нараас өмнө байсан эш үзүүлэгчдийг тэд ийнхүү хавчсан юм. (Матай 5:10-12).

Зургаа дахь лац: Хурганы уур хилэн ирсэн нь

Зургаа дахь лацыг эвдэхэд дэлхий болон тэнгэр дээр үймээн дэгдэх болно. Есүс энэ тухай урьдчилан хэлсэн. “Гэвч гамшгийн тэр өдрүүдийн дараа тэр даруй нар харанхуйлж, сар гэрэлтэхгүй, одод тэнгэрээс унаж, тэнгэрийн хүчнүүд сэгсрэгдэх болно. Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх овог гашуудан уйлж, Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр сүр хүч болоод агуу цог жавхлантайгаар ирэхийг харна. Тэр тэнгэр элч нараа их дуугаар илгээхэд тэд сонгогдогсдыг нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл дөрвөн салхинаас цуглуулах болно. (Матай 24:29-31) “Би тэнгэр болон газарт гайхамшгуудыг буюу цус, гал ба утаан багануудыг илэрхийлнэ. Эзэний агуу, аймшигт өдөр ирэхийн өмнө нар харанхуйлж, сар цус болж хувирна.

(Иоел 2:30-31). Хүмүүс уур хилэнгийн өдөр ирсэнийг мэдмэгцээ Хурганы уур хилэнгээс нуугдана! “ Бидний Бурханы өшөө авах жил тунхаглан, бүх гашуудагсдыг тайвшруулна. (Исаиа 61:2). Тэд үнэхээр Хүний хүү үүлэн дээр тэмдгүүдийг үйлдэж байхад Түүнийг харах болов уу? Тэр дэлхий дээр байгаа түүнийг үгүйсгэсэн овог аймгуудын төлөө гашуудах болов уу? Израиль Түүнийг Мессиа хэмээн таних цаг энэ мөн болов уу? “Тэд өөрсдийн жадалсан намайг харна, Тэд ганц хүүгийнхээ төлөө гашуудаж буй нэгэн мэт түүний төлөө гашуудан, ууган хүүгийнхээ хойноос асгартал уйлдаг шиг Түүний хойноос асгартал уйлах болно.

(Зехариа 12:10). Эзэний өдөр ирэхэд айдастай цаг үе ирнэ хэмээн судар тодорхойлж байна. “Түүний ирэх өдрийг хэн тэсвэрлэж чадах вэ? Түүнийг үзэгдэхэд хэн зогсож чадах вэ? Учир нь Тэр цэвэршүүлэгчийн гал шиг , угаагчийн саван шиг юм. (Малахи 3:2).

Бид Есүст итгэн нүглээ гэмшихэд Бурханы уур хилэнгээс хамгаалагдана.

“Хүүд итгэдэг хүн мөнх амьтай. Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн түүн дээр байдаг. (Иохан 3:36). Зөвхөн Хурганы цус биднийг Түүний уур хилэнгээс хамгаалж чадна.

Итгэгч нарыг Есүс хэрхэн буцааж авах вэ?

Бурханы жинхэнэ хүүхдүүд уур хилэнгээс аврагдсанд Бурханд талархъя. “Биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан. Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан уур хилэнгээс аврагдах болно. (Ром 5:8,9). Бурхан итгэгч нарт гайхамшигтай төлөвлөгөө төлөвлөсөн. Бид Христтэй уулзахаар тэнгэр өөд өргөгдөх болно. Энэ явдал хэзээ болох вэ?

Зарим итгэгч нар Бурханы уур хилэн дэлхий дээр буухаас өмнө энэ явдал одоо цаг үед болж байгаа гэж

үздэг. Харин зарим итгэгч нар эрт үед болсон гэж үздэг. Бусад итгэгч нар энэ явдал хожим болно гэж үздэг бөгөөд итгэгч хүмүүс яг энэ үед хамгаалагдсан гэж үздэг. Библид итгэдэг итгэгч хүмүүсийг энэ асуудал хуваах ёсгүй. Бид нэг зүйл дээр санал нийлж болно. Ийм зүйл болно!

Бурхан итгэгч нарт гайхалтай зүйлийг хэлсэн. “Эзэн өөрөө тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрээний дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно. Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно. (1 Тесалоник 4:16,17). Бид Бурхантай тэнгэр дээр уулзах хүртлээ бие биенийхээ итгэлийг босгон байгуулцгаая. Бурханд талархан Түүний уур хилэнгээс аврагдъя. Түүний авралын сайн мэдээг алс холд тараацгаая!



ХИЧЭЭЛ 13. 144,000 БООЛ ТАМГАЛАГДСАН НЬ

Илчлэлт 7:1-8

“Үүний дараа би дэлхийн дөрвөн өнцөгт зогсон, газар дээр ч, тэнгэр дээр ч, ямар ч модон дээр салхи салхилуулахгүйн тулд дэлхийн дөрвөн салхийг барих тэнгэр элчийг харав. Би мөн амьд Бурханы тамгатай өөр нэгэн тэнгэр элч наран мандах зүгээс гарч ирэхийг харав. Газар тэнгист хөнөөл учруулах эрхтэй дөрвөн тэнгэр элчид хандан

тэрээр чанга дугаар хашхиран –Бурханыхаа боолуудын духан дээр биднийг тамга дартал газарт ч, тэнгист ч, модонд ч бүү хөнөөл учруул хэмээв. Тамгалуулсан хүмүүсийн тоог би сонсов. Израилийн хөвгүүдийн овог бүрээс тамгалуулсан хүмүүсийн тоо нэг зуун дөчин дөрвөн мянга байв.

Иудагийн овгоос арван

хоёр мянга тамгалуулсан
бөгөөд Реубенний овгоос
арван хоёр мянга,
Гадын овгоос арван хоёр
мянга,
Ашерийн овгоос арван хоёр
мянга,
Нафталийн овгоос арван
хоёр мянга,
Манассегийн овгоос арван
хоёр мянга,

Сямеоны овгоос арван хоёр
мянга,
Левийн овгоос арван хоёр
мянга, Иссахарын овгоос
арван хоёр мянга,
Зебулуны овгоос арван хоёр
мянга,
Бенамины овгоос арван хоёр
мянган хүн тамгалуулсан
байлаа.

Тамгалагдсан Израилийн ул мөр

Еврейн овог бүрээс тамгалуулсан хүмүүсийн тоо арван хоёр мянга бөгөөд эдгээр хүмүүс Бурханы хамгаалалт доор байдгийг харуулж байна. Дэлхий дээр эдгээр хүмүүс Бурханы хүчийг харуулж байдаг.

Өнөөдөр жинхэнэ итгэгч нар ариун сүнсээр тамгалагдсан. “Та нарын авралын сайн мэдээг сонссоны дараа, мөн Түүнд итгээд, амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан байв. Тэр нь Бурханы илчлэлтийн золилт хүртэл бидний өвийн батлан даагч болж Түүний алдрыг магтуулахын тулд өгөгдсөн юм. (Ефес 1:13б-14).

ХИЧЭЭЛ 14. СЭНТИЙНИЙ ӨМНӨ ЗОГССОНГҮЙ ОЛОН ХҮМҮҮС

Илчлэлт 7:9-17

“Харагтун, үүний дараа
намайг харахад, сэнтийний
өмнө болон Хурганы өмнө
зогсон, цагаан дээл өмссөн,
гартаа далдуу модны
иайлзуур барьсан, үндэстэн
бүрээс, бүх овгоос, бүх ард
түмнээс, бүх хэлтнээс ирсэн
үй олон хүмүүс байв. Хэн ч
тэднийг тоолж чадамгүй

ажээ. Тэд чанга дуугаар
Аврал бол сэнтийд залрагч
бидний Бурханд ба Хурганд
байдаг гэж хашхирч байлаа.
Сэнтий, ахлагчид болон
дөрвөн амьтны эргэн
тойронд бүх тэнгэр элч нар
зогсож байлаа. Тэд
сэнтийний өмнө нүүрээрээ
унаад Бурханд мөргөж,

Амен. Магтаал, алдар, мэргэн ухаан, талархал, хүндэтгэл, хүч чадал ба сүр хүч нь бидний Бурханд үеийн үед байх болтугай. Амен гэгцгээв. Ахлагчдын нэг нь хариулж, надад хандан Цагаан дээлтэй эдгээр хүмүүс хэн бэ? Тэд хаанаас ирсэн бэ? гэлээ. Би түүнд Эзэн минь, Та мэднэ гэхэд тэр надад Эдгээр нь үлэмж их зовлонгоос гарч ирэгсэд бөгөөд тэд Хурганы цусаар дээлээ угааж, цагаан болгожээ. Тиймээс тэд Бурханы сэнтийний өмнө

байдаг бөгөөд Түүний Сүм дотор өдөр шөнөгүй Түүнд үйлчилдэг юм. Сэнтийд Залрагч асраараа тэднийг дээгүүр нь бүрхэнэ. Тэд цаашид өлсөх ч үгүй, цангах ч үгүй. Тэд наранд шарагдах ч үгүй, ямар ч халуунд халах ч үгүй. Яагаад гэвэл сэнтийний голд байгаа Хурга тэднийг хариулах бөгөөд амийн усны булгууд уруу хөтлөх болно. Бурхан тэдний нүднээс урсах нулимс бүрийг арчих болно гэлээ.

Хийх зүйлс

“Учир нь энэхүү өнөө үеийн зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү алдартай зүйрлүүлэшгүй гэж би боддог. (Ром 8:18).

Энэ ишлэлийг санан доорх хоосон зайг нөхөж бич.

1. Сэнтийний өмнө, бүрээс, бүх, бүх ард түмнээс, бүх, ирсэн үй олон хүн байв. (9)

[Авралыг бүх үндэстэн хэлтнүүд хүлээн авдаг.]

2. Эдгээр нь үлэмж их зовлонгоос гарч ирэгсэд бөгөөд Тэд хурганы, дээлээ цагаан болгожээ. (14)

3. Сэнтийд залрагч асраараа тэдний дээгүүр (15)

[Би бас дунд чинь алхаж, та нарын Бурхан болох бөгөөд та нар Миний ард түмэн байх болно. (Левит 26:12).]

4. Тэд цаашид ч үгүй, ч үгүй. [“Тэр өлсөхгүй, цангахгүй, Тэд аагим халуунд ч, наранд ч зохиулахгүй. Учир нь тэднийг Энэрэгч нь тэднийг удирдан,

усны ундрага уруу дагуулна.]

5.Тэд шарагдах ч үгүй, ямар ч халах ч үгүй.

["Эзэн бол чиний баруун гар тал дахь чиний сүүдэр юм. Өдрөөр нар ч чамайг хорлохгүй. (Дуулал121:5-6а).]

6. Сэнтийний голд байгаа хурга тэднийг бөгөөд амийн усны уруу хөтлөх болно. ["Эзэн бол миний Хоньчин, Надад дутах зүйл нэг ч үгүй. Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлж, Дөлгөөн усны дэргэдүүр хөтөлдөг. (Дуулал23:1,2)].

7. Бурхан тэдний нүднээс урсах арчих болно.

["Тэр үхлийг мөнхөд залгина. Эзэн Бурхан бүх нүүрнээс нулимсыг арчин, Өөрийн хүмүүсийн зэмлэлийг бүх дэлхийгээс зайлуулна. Учир нь Эзэн үүнийг айлдсан юм. (Исаиа25:8).]

ХИЧЭЭЛ 15. ХУРГА 7 ДАХЬ ЛАЦЫГ ЭВДСЭН НЬ

Илчлэлт 8:1-5

"Түүнийг долоо дахь лацыг эвдэхэд бараг хагас цаг тэнгэрт чив чимээгүй болов. Бурханы өмнө зогсох долоон тэнгэр элчийг би харав. Тэдэнд долоон бүрээ өгсөн байлаа. Алтан бойпор барьсан өөр нэгэн тэнгэр элч ирж, тахилын ширээний дэргэд зогсов. Түүнд их хэмжээний утлага өгчээ. Ингэснээр тэр тэнгэр элч түүнийг сэнтийний өмнө байсан тахилын алтан ширээн дээр бүх ариун

хүмүүсийн залбирлууд дээр нэмэх ажээ.

Утлагын утаа ариун хүмүүсийн залбирлуудын хамт тэнгэр элчийн гараас гарч Бурханы өмнө суунаглав. Тэгээд тэнгэр элч бойпорыг авч тахилын ширээний галаар дүүргээд, дэлхий уруу хаясанд, тэнгэрийн дуу, нижигнээн, аянгын гялбаа, газар хөдлөлт дагалдав.



Долоо дахь лац: Шүүхээс өмнө чимээгүй болсон нь.

Хурга долоо дахь лацыг эвдэхэд тэнгэрт чив чимээгүй болов. Бидэнд маш их гай гамшиг нүүрлэх нь мэдрэгдэнэ. “Бүх махан бие нь Эзэний өмнө дуугүй байгтун. Учир нь Тэр өөрийн ариун оршихуйгаас сэрэв. (Зехариа2:13). Бүх хуйлмал онгойжээ. Бурханы уур хилэнгээс болж дэлхий дээр гал нүүрлэх болно. “Учир нь өшөө авалтын өдөр Миний зүрхэнд байсан бөгөөд Миний золилтын жил ирсэн бөлгөө” (Исаиа63:3).

Бурхан өөрийн хүмүүсийн залбиралд хариулдаг.

Хуучин гэрээний үед Бурхан Мосед мөргөлийн газар тахилын ширээ байгуулахыг тушаасан. Ингэснээр Бурханы хүмүүс түүний төлөө өсөх боломжтой болж байсан. Эвлэрүүллийн өдрийн үед тахилч нарт ариун шүтээний газар нэвтрэх боломж олддог байсан бөгөөд тэнд тэд Бурхантай уулзан өршөөл гуйдаг байсан. Бидний гэмийн төлөө Есүс загалмайд цовдлогдон нас барснаар Тэр Бурхантай харилцах замыг нээж өгсөн. “Учир нь ганц Бурхан байна. Мөн Бурхан ба хүмүүсийн хооронд ганц зууч байна. Тэр нь хүн болох Христ Есүс билээ. Тэр өөрийгөө бүгдийн төлөө золиос болгон өгсөн. (1Тимот2:5,6а). Одоо бид Есүсээр дамжуулан Бурхантай шууд харилцаатай боллоо. “Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очигцооё.(Еврей 4:16).

Есүс биднийг залбирахыг урьж байна. “Та нар Миний нэрээр юуг ч гуйсан, Эцэг хүүгээрээ алдаршуулагдахын тулд Би түүнийг хийнэ. (Иохан 14:13).

“Хэрэв та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байвал та нар юу хүссэнээ гуй.Тэгвэл та нарын төлөө биелэх болно. (Иохан 15:7).

ХИЧЭЭЛ 16. ДӨРВӨН ТЭНГЭР ЭЛЧ БҮРЭЭГЭЭ ТАТСАН НЬ

Илчлэлт 8:6-13

“Долоон бүрээтэй долоон тэнгэр элч долоон бүрээгээ татахад бэлтгэв. Эхнийх нь бүрээгээ татгал, цустай холилдсон мөндөр, гал бий болж дэлхий уруу хаягдав. Тэнгисийн гуравны нэг нь цус болж, тэнгис доторх амьтай амьтдын гуравны нэг нь үхэж, усан онгоцнуудын гуравны нэг нь сөнөв. Гурав дахь элч бүрээгээ татгал, бамбар мэт шатаж буй агуу том од тэнгэрээс унав. Тэр од гол мөрний гуравны нэг дээр болон усны эх булгууд дээр унажээ. Тэр одны нэрийг “Агь” гэдэг бөгөөд усны гуравны нэг нь агь болов. Ус гашуун болсон тул

хүмүүс уснаас болж үхэцгээлээ. Дөрөв дэхь тэнгэр элч бүрээгээ татгал, нарны гуравны нэг, сарны гуравны нэг болон оддын гуравны нэг нь цохигдов. Ингэснээр тэдгээрийн гуравны нэг нь харанхуйлах бөгөөд, өдрийн гуравны нэг нь харанхуй болж, шөнийнх ч мөн адил болох ажээ. Тэгээд би тэнгэрийн дундуур нисэж буй нэгэн бүргэдийг харлаа. Тэр “Бүрээ татах гурван тэнгэр элчийн үлээж буй бүрээн дуу бий тул дэлхийд нутаглагсад золгүй еэ, гэж чанга дуугаар хэлэхийг би сонсов.

Цээрлэл үзүүлэх бүрээ

Долоон тэнгэр элч долоон бүрээг нэг нэгээр нь татахад бэлтгэв. Бурхан хүмүүст боломж олгосон. “Би өнөөдөр тэнгэр газрыг дуудаж та нарт гэрч болгон, чиний өмнө амь ба үхэл, ерөөл ба хараалыг тавъя.(Дэд хууль 30:196). Дэлхийн оршин суугчид Есүсийг үгүйсгэсэн. “Ариун агаад зөвт Нэгэнийг та нар үгүйсгэсэн атлаа алуурчныг өршөөхийг гуйсан боловч үхэгсдээс Бурханы босгосон амийн Зохиолчийг алуулсан билээ. (Үйлс3:14-15). Одоо дэлхий дээр амьдарч байгаа хүмүүс сонгох эрхтэй болсон. ТАНД боломж олдвол та амьдралыг сонгох уу?

“Хэрэв Эзэнд үйлчлэх нь та нарын хувьд нийцгүй мэт

байвал, хэнд үйлчлэх вэ? гэдгээ өөрсдөө сонго. (Иошуа24:156).

Эхний дөрвөн бүрээ

Энэ цээрлэл бидэнд Бурхан Израилийг Египетэд боол болгосныг сануулж байна. Он жил өнгөрсний дараа Израилийн ард түмэнд хортой ус уулгана хэмээн Бурхан амласан учир нь тэд зүрх сэтгэлийн сүсэг бишрэлийг дагасан юм. "Үзэгтүн, Би хүмүүс болох тэднийг агиар хооллож , тэдэнд хортой ус уулгахаар өгнө. (Иеремиа9:156).

Эхний гурван гай гамшиг ил болсон нь

Тэнгэр элч дараагийн гурван бүрээний цээрлэл хамгийн муу нь байх тухай илгээмжийг бидэнд өгсөн. Энэ илгээмж дэлхий дээр түр зуур оршин сууж байгаа хүмүүст зориулагдсан. Эдгээр хүмүүс түр зуурын гэр болох дэлхий дээр амьдардаг Христийг үгүйсгэсэн хүмүүс юм. Харин нөгөө талд Бурханы хүүхдүүд дэлхий дээр өөрсдийгөө гадныхан гэж бодсон. "Харин бидний иргэний харъяалал нь тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна. Тэр бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ бидний дорд биеийг Өөрийнхөө цог жавхлант биетэй адил болгон өөрчлөнө. (Филиппой 3:20-21a).

Таны иргэний харъяалал тэнгэрт байгаа болов уу? "Хайрт хүмүүсээ, сэтгэлийн чинь эсрэг дайн хийдэг махан биеийн хүсэл тачаалуудыг цээрлэхийг харь хүмүүс болон түр хугацаагаар байгч та нараас би гуйя.(1Петр 2:11). "Та нар оюун ухаанаа газар дахь зүйлс дээр биш, харин дээгүүрх зүйлс дээр төвлөрүүл. (Коллосай 3:2).

ХИЧЭЭЛ 17. ТАВ ДАХЬ БҮРЭЭГЭЭ ТАТСАН НЬ

Илчлэлт 9:1-12



“Тав дахь тэнгэр элч бүрээгээ таттал тэнгэрээс дэлхий уруу унасан одыг би харав. Тэр одонд ёроолгүй нүхний түлхүүрийг өгсөн байлаа. Өнөөх од ёроолгүй нүхийг нээтэл, асар том зуухны утаа мэт утаа нүхнээс гарав. Нүхний утаанаас болж нар, агаар харанхуйллаа. Утаанаас царцаанууд газар дээр гарч ирлээ. Газрын хилэнцэт хорхойнуудын хүч шиг хүчийг тэдэнд өгсөн байжээ. Дэлхийн өвс ногоонд ч, ямар ногоон юманд ч болон модонд ч хор учруулж болохгүй гэж тэдэнд хэлсэн ажээ. Зөвхөн духан дээрээ Бурханы тамгагүй хүмүүст болох юм. Тэднийг алахгүй харин таван сарын турш тарчилгахыг царцаануудад зөвшөөрсөн байв. Тэдний тарчилгалт нь

хилэнцэт хорхой хүнийг хатгахад тарчилгадагтай адил юм. Тэр өдрүүдэд хүмүүс үхлийг хайх бөгөөд түүнийг олохгүй. Тэд үхэхийг хүсэвч үхэл тэднээс зугтана. Царцаануудын дүр нь тулалдаанд бэлтгэгдсэн морьд мэт байлаа. Толгой дээрээ алт шиг титэм мэт юмтай, нүүр нь хүний нүүр шиг байв. Тэдний үс нь эмэгтэй хүнийх шиг бөгөөд тэдний шүд нь арслангийн шүд шиг байв. Тэд төмрөн цээживч мэт цээживчтэй байсан. Тэдний далавчных нь дуу чимээ тулалдаанд орохоор давхилдаж буй морьд тэрэгний дуу чимээтэй адил байлаа. Тэд хилэнцэт хорхойнхтой адил сүүл, хатгууртай юм. Хүмүүст таван сарын турш хор учруулах хүч тэдний сүүлэнд нь байдаг. Тэд өөрсдийг нь захирдаг хаантай бөгөөд тэр нь ёроолгүй гүний тэнгэр элч ажээ. Түүний нэр нь еврейгээр “Абаддон”, грекээр “Аполлуон” юм. Эхний гай тотгор өнгөрлөө. Харагтун, үүний дараа бас хоёр гай тотгор айсуу.

Ёроолгүй гүнээс гарч ирсэн чөтгөрийн цэргүүд

Есүс нэг удаа олон чөтгөрүүдэд эзэмдүүлсэн хүнтэй таарсан. Тэдгээр чөтгөрүүд тэдний байх ёстой ёроолгүй гүн уруу битгий явуулаач гэж Түүнээс гуйсан. (Лук 8:31). Хожим Есүс үүнийг тайлбарлахдаа тэнгэр дээрээс унасан нэгэн байсан гээд одоо түүнд ёроолгүй гүний түлхүүр өгөгдсөн гэжээ. “Би Сатаныг аянга адил тэнгэрээс буухыг харав. Харагтун, Би та нарт могой, хилэнцэт хорхойнуудад халдах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдэл өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй. (Лук 10:18б,19). Хэрэв та жинхэнэ итгэгч бол тэр танд (Түүний нэр дээр) чөтгөрүүдийг захирах эрх мэдэл өгсөн. Тэд танд хор хохирол учруулж чадахгүй.

Чөтгөрийн цэргүүд итгээгүй дэлхийг цээрлүүлэх гэж эрх чөлөөтэй болох үед ,тэдний учруулах гай зовлонгоос хамгаалах ямар ч хамгаалалт байхгүй байна. (Духан дээрээ Бурханы тамгагүй хүмүүсээс бусдыг). Хүмүүс үхлийг хүсэх боловч хэн ч үхэхгүй.

Абаддон” (сүйрэл) эсвэл “Аполлуон” (устгагч) толгойлдог. Сатаны зорилго таныг устгах гэдгийг та хэзээ ч мартаж болохгүй. Есүс амьдрал өгөх гэж ирсэн. “Хулгайч зөвхөн хулгайлж, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм. (Иохан 10:10). “Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг. Түүнийг бат итгэлээрээ эсэргүүц. (1 Петр 5:8-9а).

Чи өөрөө Сатан болон түүний Муу ёрын сүнсний эсрэг юу ч хийж чадахгүй. Гэвч санагтун, “Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханых бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу. (1Иохан 4:4).

Санагтун, хэрэв та Бурханы хүүхэд бол ямар ч цээрлэл танд байхгүй. “Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан уур хилэнгээс ч аврагдах болно.” (Ром 5:9). Бурханд талархъя!

ХИЧЭЭЛ 18. ЗУРГАА ДАХЬ БҮРЭЭГЭЭ ТАТСАН НЬ (ХОЁР ДАХЬ ГАЙ ЗОВЛОН).

Илчлэлт 9:13-21

Харагтун, үүний дараа бас хоёр гай толгор айсуу. Зургаа дахь тэнгэр элч бүрээгээ татгал, Бурханы өмнө байгаа тахилын алтан ширээний дөрвөн эврээс нэгэн дуу гарахыг би сонссон бөгөөд тэр нь бүрээ барьсан зургаа дахь тэнгэр элчид хандан Агуу их Евфрат мөрний дэргэд хүлэгдсэн дөрвөн тэнгэр элчийг сулла гэв. Тэгээд хүмүүсийн гуравны нэгийг хөнөөлгөхөөр тэр цаг, өдөр, сар, жилийн төлөө бэлтгэгдсэн байсан тэнгэр элч суллагдав. Морьт цэргийн тоо нь хоёр зуун сая аж. Би тэдний тоог сонсов. Тийнхүү би үзэгдэл дотор морьдыг болон, галын, бор улаан, хүхрийн өнгөтэй цээживчтэй морьтонгуудыг харлаа. Морьдын толгой нь

арслангийн толгой шиг бөгөөд амнаас нь гал, утаа, хүхэр савсана. Тэдний амнаас гарсан гал, утаа, хүхэр буюу эдгээр гурван гамшгаас болж хүмүүсийн гуравны нэг нь хөнөөгдсөн байлаа. Учир нь морьдын хүч нь тэдний аман дотор ба сүүлэнд нь байв. Тэдний сүүл нь могой адил бөгөөд толгойтой ажээ. Тэд түүгээрээ хор хөнөөл учруулдаг байна. Эдгээр гамшгуудаар хөнөөгдөөгүй үлдсэн хүмүүс нь гарынхаа үйлсдээ ч гэмшсэнгүй. Тэгээд чөтгөрүүдэд болон харж, сонсож, явж чаддаггүй алтан, мөнгөн, гуулин, чулуун, модон шүтээнүүдэд мөргөхөө больсонгүй. Тэд хүн алсандаа ч, ид шидэндээ ч, завхайрсандаа ч, хулгай хийсэндээ ч гэмшсэнгүй.

Тэд гэмшсэнгүй

Ефрат мөрөн Еден цэцэрлэг уруу цутгадаг шиг Муу ёрын сүнс дэлхий уруу нэвтрэн орсон. (Эхлэл 2:10,14). Харин одоо үхлийн 200,000,000 арми хүн төрөлхтний гуравны нэгийг устгах гэж чөлөөлөгдөнө. Харин үхээгүй үлдсэн хүмүүс өөрийн гэмээ гэмшсэнгүй. "Аврал хорон муу хүмүүсээс хол байдаг. Учир нь тэд Таны зарлигуудыг эрж хайдаггүй билээ.(Дуулал 119:155). Бурханд тахиж ёстой

зүйлийг үнэндээ чөтгөрүүдэд тахидаг. (1 Коринт 10:20). “Жигшүүрт юмсаар түүний хилэнг өдөөжээ. Тэд Бурханд биш, харин чөтгөрүүдэд тахил өргөжээ. (Дэд хууль 32:16б , 17а). “Сорсерис” гэдэг үг нь Шинэ гэрээний Грек хэлний “эмээр юм хийх” гэсэн утгатай. Энэ нь мөн ид шидтэй хамаатай юм. Өнөө үед ийм гэм нүгэл илүү их тархаж байгаа нь сайн зүйл биш. Энэ гэмүүд нь Бурханы сүнстэй хүмүүст байдаггүй гэмүүд юм. “Эдүгээ махан биеийн үйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар байдал, шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх гэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулъя. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй. (Галат 5:19-21).

Бурханы хүүхдүүдийн гаргадаг үр жимснээс ямар их ялгаа байна вэ!

“Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй юм. (Галат 5:22-23).

Зөвхөн Бурханы нигүүлсээр хүн нүглээ гэмшдэг. “Бурханы хүслийн дагуух гашуудал нь үл харамсах гэмшлийг бий болгон авралд хүргэдэг аж. Харин ертөнцийн гашуудал нь үхлийг бий болгодог. (2 Коринт 7:10). Үнэн сэтгэлээсээ, гэмээсээ болж гашуудах нь гэмшил харууслыг авчирдаг, Өөрчлөгдсөн амьдрал мөнхийн авралыг олно. Дэлхийн уй гашуудал нь зөвхөн гэмийнхээ үр дагавараас болж зовж байгаадаа гашууддаг. Ийм гашуудалд өөрчлөлт ирэхгүй бөгөөд мөнхийн үхэлийг авчирдаг. Хэрэв Бурханы сүнс таны гэмд ял тулгавал, та зүрхээ зөөлөн байгаа дээр гэмшигтүн. “Хэрэв та нар өнөөдөр Түүний дууг сонсох аваас, Та нар зүрхээ бүү хатуу болго. (Еврей 3:7б-8а). Хүний зүрх гэмээ гэмшихэд дэндүү хэцүү болох цаг ирж байна.

ХИЧЭЭЛ 19. НУУЦЛАГ ДОЛООН АЯНГАНЫ НИЖИГНЭЭН

Илчлэлт 10:1-11

“Үүлээр хувцасласан, хүчит нэгэн өөр тэнгэр элч тэнгэрээс буун ирэхийг би харлаа. Түүний толгой дээр солонго байсан бөгөөд түүний нүүр нь нар мэт, хөл нь галан багана мэт байв. Гарт нь дэлгэсэн бяцхан ном байв. Тэр баруун хөлөө тэнгис дээр, зүүн хөлөө газар дээр тавиад, арслан хүрхрэх адил чанга дуугаар хашхирав. Түүнийг хашхирахад долоон аянгын нижигнээн дуу гаргалаа. Долоон аянга нижигнэхэд би бичих гэтэл тэнгэрээс

-Долоон аянгын нижигнээний ярьсан юмсыг битүүмжил. Тэдгээрийг бүү бич гэх дуу гарахыг сонсов. Тэнгис, газар дээр зогсохыг нь миний харсан мөнөөх тэнгэр элч баруун гараа тэнгэр өөд өргөөд, тэнгэр болоод түүн дэх, тэнгис болоод түүн дэх зүйлсийг бүтээсэн үеийн үед амьд байгч Түүгээр тангаргалан

-Цаашид саатахгүй гэв.

Харин долоо дахь тэнгэр элчийн дуу гарах өдрүүд буюу бүрээ татах үед Өөрийн боолууд болох эш үзүүлэгчдэд Түүний тунхагласан илан Бурханы нууц нь төгсөнө. Тэнгэрээс миний сонссон мөнөөх дуу дахин надтай ярьж

-Яв. Тэнгис, газар дээр зогсогч тэнгэр элчийн гар дахь дэлгэсэн бяцхан номыг ав гэхийг би сонслоо. Би бяцхан номоо надад өг гэсээр тэнгэр элч уруу очив. Тэр надад

-Үүнийг ав. Үүнийг ид. Энэ чиний ходоодыг хорсгох боловч аманд чинь зөгийн бал мэт амттай байх болно гэхэд би тэнгэр элчийн гараас бяцхан номыг аваад идлээ. Тэр аманд маань зөгийн бал мэт амттай байсан боловч идсэний дараа ходоодыг минь хорсгов. Тэр надад

-Чи олон ард түмэн, үндэстнүүд, хэлтнүүд болон хаадын тухай дахиж эш үзүүлэх ёстой гэж хэллээ.

Тэнгэр элч ба жижиг ном

Энэ хүчирхэг тэнгэр элч “Эзэний тэнгэр элч”, Есүс

Христ одоо алдаршуулагдсан биетэй Хуучин гэрээний үед гардаг тэнгэр элч байж болох юм. Тэр өв залгамжлахад бэлэн болсон. Бурхан хүүдээ ингэж хэлж байв. “Надаас гуй. Би үндэстнүүдийг Чиний өв болгон, Дэлхийн хязгааруудыг ч Чиний эзэмшил болгон өгнө. (Дуулал 2:8).

Тэр баруун хөлөө далай тэнгис дээр зүүн хөлөө газар дээр тавьдаг?

Бурхан Иошуад ингэж хэлсэн “Хөлийн чинь ул гишгэх газар бүрийг чамд өгсөн билээ. (Иошуа 1:3а). Иуда овгийн архирах Арслан Өөрийгөө мэдэн



золиослосон. Долоон аянганы нижигнээн дуу авиа гаргасан. Иоханд сонссон зүйлээ бичих нь зөвшөөрөгдсөнгүй. Илчлэлт номны зөвхөн энэ хэсэг бидний мэдлэгээс битүүмжлэгдсэн. Гэвч Бурханд талархъя. Сударт авралыг болон ялсан амьдралыг олоход хангалттай зүйл илчлэгдсэн. “Нууц зүйл нь бидний Бурхан Эзэнд хамаарах бөгөөд харин илэрч мэдэгдсэн зүйлс нь бидэнд, бидний хөвгүүдэд үүрд хамаарна. Биднээр энэ хуулийн бүх үгсийг мөрдүүлэхийн тулд тэр юм. (Дэд хууль 29:29). “Тэрээр мэргэдэд мэргэн ухааныг, ухаарагч хүмүүст мэдлэгийг өгдөг. Тэр л гүн хийгээд нууц юмсыг илчилдэг. (Даниел 2:21б,22а).

Долоо дахь тэнгэр элч бүрээ татах үед эш үзүүлэгч, Бурханы нууц нь төгсөнө. Олон тохуурхагчид Эзэнийг хэзээ ч эргэж ирэхгүй гэж боддог. Гэвч Тэр өнөөдөр хүн болгонд гэмших боломж олгож байна. “Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Өөрийнхөө амлалтанд хойрго биш билээ. Харин ч Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та нарт тэвчээртэй ханддаг. (2Петр 3:9). Нэг л өдөр гэмших цаг хугацаа олдохгүй болно. “Харагтун, одоо бол “Тааламжтай цаг” байна. Харагтун, одоо бол “Авралын өдөр” байна. (2 Коринт 6:2б). “Бид ийм агуу авралыг үл хайхраад хэрхэн зугатаах билээ?

Бурханы нууцын нэг хэсэгт Бурхан өв залгамжлагч

болгоно хэмээн амалсан Еврейчүүдтэй хамт харанхуй хүмүүсийг өв залгамжлахыг урьсан.(Ефес 3:4-6)."Бурхан харь үндэстнүүдийн дунд энэхүү нууцын алдрын баялаг гэж юу болохыг тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Энэ нь та нарын дотор байгаа алдрын найдвар болох Христ мөн. (Колоссай 1:27). Энэ "нууц" Бурханы үгээр илчлэгдсэн.

Бяцхан номыг идэхэд яагаад Иоханы ходоодыг хорсгосон боловч аманд нь зөгийн бал мэт амттай байсан бэ? Магадгүй Бурханы үгийг хүлээж авахад баяр хөөртэй байдаг боловч хэрэгжүүлэхэд бэрх байдаг. Магадгүй Бурханы нигүүлсэл зөөлөн байдаг нь илчлэгдсэн боловч харин шүүхдээ тэр гашуувтар байдаг. Иохан хувь хүнийхээ хувьд бяцхан номыг идэх шаардлагатай байсан. Бид Бурханы үгээр явах шаардлагатай. "Таны үгс олдсон бөгөөд би түүнийг идсэн билээ. Таны үгс надад баяр хөөр болон сэтгэлийн минь таашаал болсон билээ. Учир нь түмэн цэргийн Бурхан Эзэн, би Таны нэрээр дуудагдсан билээ. (Иеремиа 15:16). Бурханы үг бидний хоол юм. Есүс хэлэхдээ "Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдрана." (Матай 4:4б).

Иоханы бэлтгэсэн энэ бяцхан ном дэлхий дээр хүрсэн байх хэрэгтэйг харуулж байна. Бид ч бас өөрсдийгөө Бурханы үгийг өөрийн дэлхий дээр гэрчлэхэд бэлдэх ёстой. Эш үзүүлэгч Езекиел мөн ийм зүйлтэй учирсан. "- Хүний хүү, Миний чамд өгч буй энэ хуйлмал номоор гэдсээ тэжээж, биеэ дүүргэгтүн гэв. Тэгээд би түүнийг идсэнд, тэр нь миний аманд бал мэт чихэрлэг байв. (Езекиел 3:3). Мөн эш үзүүлэгч Иеремиа дуулгаваргүй хүмүүст Бурханы үгийг дамжуулах болоход Бурхан түүнд "Миний чамд тушаах бүхнийг тэдэнд хэлэгтүн. Тэднээс бүү ай, эс тэгвээс Би чамайг тэдний өмнө айлгах болно. (Иеремиа 1:17а). Тэр Бурханы үгийг тэдгээр хүмүүст сонссон ч бай үгүйсгэсэн ч бай дамжуулсан юм. Бид нар хойч үедээ үнэнийг гэрчлэгч байцгааж, Хэрхэн хариу өгөхөөс нь үл хамааран Бурханы үгийг дамжуулцгаая.

ХИЧЭЭЛ 20. ХОЁР ГЭРЧЛЭГЧ ХАВЧИГДАН АЛАГДСАН НЬ

Илчлэлт 11:1-14

Тэгээд надад таяг мэт хулс өгөөд

- Бос. Бурханы сүмийг болон тахилын ширээг хэмж. Дотор нь мөргөгсдийг тоол. Сүмийн гадна байгаа хашааг нь орхи. Түүнийг бүү хэмж. Яагаад гэвэл түүнийг үндэстнүүдэд өгсөн юм. Тэд ариун хотыг дөчин хоёр сарын турш хөл доороо гишгэчих болно. Би хоёр гэрчдээ соёрхоно. Тэд таар өмсөөд мянга хоёр зуун жаран хоногийн турш эш үзүүлэх болно гэв. Эдгээр нь дэлхийн Эзэний өмнө буй хоёр чидун мод, хоёр дэглүүний суурь юм. Хэрэв хэн нэгэн нь тэднийг хорлохыг хүсвэл, тэдний амнаас гал гарч, дайснуудаа залгина. Хэрэв хэн нэгэн нь тэднийг хорлохыг хүссэн бол тэр хүн ингэж алагдах ёстой. Өөрсдийнхөө эш үзүүлэх өдрүүдийн туршид тэд бороо оруулахгүйн тулд тэнгэрийг хаах хүч тэдгээрт бий. Тэдэнд усыг цус болгох, хүссэн үедээ зүйл бүрийн гамшгаар дэлхийг цохих хүч бий. Тэднийг гэрчлэлээ

дуусгахад ёроолгүй гүнээс гарч ирэгч нэгэн араатан тэдэнтэй тулалдаж, тэднийг дийлж алах болно. Тэдний цогцос нь , Сүнсний хувьд Содом ба Египет гэж нэрлэгддэг агуу хотын гудамжинд хэвтэх болно. Тэнд мөн тэдний Эзэн цовдлогдсон билээ. Ард түмэн, овгууд, хэлтнүүд, үндэстнүүдээс ирсэн хүмүүс тэдний цогцсыг гурав хоног хагасын турш харах бөгөөд тэдний цогцсыг булшинд тавихыг зөвшөөрөхгүй. Дэлхий дээр нутаглагсад тэднээс болж баярлан хөөрч цэнгэцгээнэ. Тэд нэг нэгэндээ бэлэг илгээнэ. Учир нь энэ хоёр эш үзүүлэгч дэлхий дээр нутаглагсдыг тарчилгасан юм. Гурав хоног хагасын дараа Бурханаас амийн амьсгал гарч тэдний дотор ороход тэд хөл дээрээ зогсов. Тэднийг харж байсан хүмүүсийг үлэмжийн айдас нөмөрлөө. Тэнгэрээс чанга дуу гарч

- Наашаа гараад ир гэж өөрсдөд нь хэлэхийг тэд сонсов. Тэд үүлэн дотор

тэнгэр өөд одлоо. Дайснууд нь тэднийг харав. Тэр цагт асар хүчтэй газар хөдлөлт болж, хотын аравны нэг нь нурлаа. Газар хөдлөлтөнд долоон мянган хүн үхсэн

бөгөөд үлдсэн нь айн сүрдэж тэнгэрийн Бурханд алдрыг өргөв.

Хоёр гай тотгор өнгөрлөө. Харагтун, гурав дахь гай тотгор даруй айсуу.

Хоёр эш үзүүлэгч Бурханы гэрчлэгч байсан

Энэ хоёр гэрчлэгч Израилийн сүнслэг нөхцөл байдалд зовлон уй гашуу авчрах гэж таар өмссөн байсан. Тэд нарыг чидун мод болон Бурханы өмнө буй дэнлүүний суурь хэмээн тодорхойлсон. Зеруббабел Иошуа хоёрыг мөн ингэж тодорхойлсон. Захирагч, тэргүүн тахилч Вавилоны үед Иерусалим дахь сүмийг дахин барьсан. Энэ цаг үед тэнгэр элч ингэж хэлэв, “Энэ бол Зеруббабелд хандсан Эзэний үг юм. “Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, Харин Миний Сүнсээр” гэж түмэн цэргийн Эзэн айлдаж байна. (Зехариа 4:6б)

Эдгээр гэрчлэгч нар хэн байсан бэ? Зарим нь Елиа Енох хоёр гэж хэлдэг. Хуучин гэрээний үед үхээгүй бөгөөд харин Бурхан шууд тэнгэрийн улс уруу авч явсан. Харин бусад нь Мосе Елиа хоёр гэж үздэг. Учир нь

1. Хуучин гэрээний үед Мосед усыг цус болгох хүч чадал өгөгдсөн байсан.

Мосе Есүс болон Елиатай уулан дээр гарч ирсэн. (Матай17:1-3). Мөн тэргүүн тэнгэр элч Михаел диовалтай Мосегийн биеийн талаар сөргөлдсөн. (Иуда9). Мосегийн хүчирхэг гэрчлэлийг Сатан сэрэмжлүүлж байсан уу?

2. Эш үзүүлэгч Елиа, гэрчлэгч тэрбээр бороо оруулалгүй гурван жил хагас мөн тэнгэрээс гал гарган дайснуудаа устгадаг байсан. Эш үзүүлэгч Малахи урьдчилан хэлж байсан. “Харагтун, Эзэний аугаа, аймшигт өдөр ирэхээс өмнө Би эш үзүүлэгч Елиаг та нар уруу илгээнэ. (Малахи 4:5).

Мосе, Елиа хоёр хуулийг гэрчлэгч бэлэг тэмдэг болж

байна. "Харин эдүгээ Бурханы зөв нь Хуулиас ангид илэрхийлэгдэв. Үүнийг Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилсэн юм. Есүс христэд итгэх итгэлээр Бурханы зөв нь итгэгч бүх хүмүүст байна. (Ром 3:21-22а). Энэ хоёр гэрчлэгч зөвхөн гэрчлэлээ дуусгасаны дараа үхсэн. Сургаал номлогч Паул зовж байхдаа ингэж хэлсэн. "Би сайн тэмцлээр тэмцсэн. Би замаа дуусгасан, итгэлээ сахьсан. (2 Тимот 4:7). Есүс бас үхэхийнхээ өмнө Эцэг уруугаа залбирсан. "Хий гэж Надад өгсөн ажлыг тань гүйцэтгэн Би Таныг газар дээр алдаршуулав. (Иохан 17:4).

Бид мөн Бурханы бидэнд даалгасан ажлыг үнэнчээр хийж Түүхийг гэрчилье. " Мууг тэвч, сайн мэдээг дэлгэрүүлэгчийн ажлыг хий, үйлчлэлээ гүйцээ. (2Тимот 4:5б). Араатан (Илчлэлт 13:1 мөн 17:8) тэдэнтэй тулалдан тэднийг алав.Тэдний цогцос нь Египет ба Содомын гудамжинд хэвтэх болно. Тэднийг үхсэний дараа бүх дэлхий баярлан тэмдэглэнэ. Тэд Бурханаас сануулга авахыг хүсэхгүй. Гэвч энэ баяр баясгалан удаан үргэлжлэхгүй. Иерусалим хотод асар хүчтэй газар хөдлөлт болж амьд үлдсэн хүмүүс Бурханд алдрыг өргөв. Тэд гэрчлэгч хоёрыг тэнгэрт байхыг харсан ч тэдний зүрх сэтгэл өөрчлөгдсөнгүй. Есүс ингэж хэлэв. "Хэрэв тэд Мосе болон Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ?" гэжээ. (Лук 16:31б).

ХИЧЭЭЛ 21. ДОЛОО ДАХЬ БҮРЭЭГ ТАТСАН НЬ (ГУРАВ ДАХЬ ГАЙ ЗОВЛОН)

Илчлэлт 11:15-19



"Долоо дахь тэнгэр элч бүрээгээ татгал, тэнгэрт "Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон. Тэр үеийн үед хаанчилна гэх чанга дуу гарлаа. Бурханы

өмнө өөр өөрсдийн сэнтийнд суугч хорин дөрвөн ахлагчид нүүрээрээ унаж, Бурханд мөргөж

-Байгаа, байсан. Төгс хүчит Эзэн Бурхан минь ээ, Танд бид талархал өргөө. Яагаад гэвэл Та Өөрийн агуу их хүчээ авч, хаанчилж эхэллээ. Үндэстнүүд хилэгнэсэн бөгөөд Таны уур хилэн ирсэн. Үхэгсдийг шүүх цаг болон Таны боолууд болох эш

үзүүлэгчид ба ариун хүмүүст, Таны нэрээс эмээгч их бага хүмүүст шагналыг нь өгч, мөн дэлхийг устгагчдыг устгах цаг ирлээ гэлээ. Тэнгэр дэх Бурханы сүм нээгдсэн байв. Түүний гэрээний авдар сүм дотор харагдав. Тэгтэл аянга гялбан, нүргэлж, тэнгэр дуугарч, газар хөдлөн, том мөндөр буулаа.

Христийн хаанчлал тунхаглагдсан нь

Дэлхий дээрх улсууд уурлан Бурханы эсрэг хуйвалдана. Харин одоо Бурханы уур хилэн ирж тэдний үйлсийг дуусгана. "Яагаад үндэстнүүд уурандаа шатаж, Ард түмнүүд дэмий хуйвалдана вэ? Газар дэлхийн хаад бат зогсож, Удирдагчид хоорондоо зөвлөлдөж, Эзэн ба Түүний Тослогдсон Нэгэнийг эсэргүүцэн, "Бид тэдний гинжийг тасалж, Хүлгийг нь өөрсдөөсөө зайлуулцгаая" гэж тэд хэлэв. Тэнгэрт залрагч инээж, Тэднийг Эзэн тохуурхаж байна. Тэгээд Тэр тэдэнд Өөрийн ууранд айлдаж, Өөрийн хилэнгээр тэднийг айлган, (Дуулал 2:1-6). Есүс мөнхөд хаанчлах болно. Түүний хаанчлалд шударга ёс, үнэн зөвийг үеийн үед тогтооход, Түүний засаглал болон энх амгалан нь одоогоос үүрд мөнхөд байх болно.

(Исаиа 9:7а). Түүнд итгээгүй хүмүүст үхэх шийтгэл ирэх цаг болжээ. "Нэг удаа үхэх нь хүмүүст тогтоогдсон. Үүний дараа шүүгдэхийн адил" (Еврей 9:27б). 34-р хичээл бидэнд итгэгч биш хүмүүсийн үхлийн шийтгэлийн тухай илүү ихийг хэлэх болно.

Бурханд талархъя, Христийн дотор үхсэн итгэгч хүмүүст ямар ч ял байхгүй. "Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч

амь уруу шилжив. (Иохан 5:24). Итгэгч нарт хийсэн үйлсийнх нь дагуу мөн Түүний нэрнээс эмээдэг хүмүүст Есүс шагналыг нь өгнө. “Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариу өгнө. (Матай 16:27). “Тэгээд Эзэнээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад Эзэн анхаарал тавин сонссон. Эзэнээс эмээдэг болон Түүний нэрийг үнэлдэг хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ.” Би Өөрийн эзэмшлийг байгуулах өдөр тэд Минийх байх болно. Өөрт нь үйлчилдэг хүүгээ хүн өршөөдгийн адил Би тэднийг өршөөх болно” гэж түмэн цэргийн Эзэн айлдаж байна. (Малахи 3:16-17).

ХИЧЭЭЛ 22. ЛУУ ДЭЛХИЙ ДЭЭР ХАЯГДСАН НЬ

Илчлэлт 12:1-17

“Тэнгэрт нэгэн үлэмжийн тэмдэг үзэгдэв. Нарыг өмсөж, хөл дороо сар, тэргүүн дээрээ арван хоёр одны титэмтэй нэгэн эмэгтэй хэвлийдээ үртэй байсан бөгөөд төрөхөөр өвдөж, шаналсандаа хашхирлаа. Тэнгэрт өөр тэмдэг үзэгдэв. Харагун, долоон толгойтой, арван эвэртэй агуу том улаан луу байна. Толгойнууд дээр нь долоон титэм байх аж. Түүний сүүл нь тэнгэрийн оддын гуравны нэгийг шавхуурдаж, дэлхий дээр унагав. Луу эмэгтэйг төрмөгц хүүхдийг нь залгихын тулд төрөх гэж буй эмэгтэйн өмнө зогслоо. Тэр эмэгтэй бүх үндэстнийг төмөр таягаар

хариулах эрэгтэй хүүхэд төрүүлэв. Хүүг Бурханд, Түүний сэнтийнд аваачлаа. Өнөөх эмэгтэй Бурханы бэлдсэн газар бүхий цөл уруу зугтав.Тэнд түүнийг мянга хоёр зуун жаран хоногийн турш тэжээх юм. Тэнгэрт дайн болов. Михаел болон түүний тэнгэр элч нар луутай тулалдлаа. Луу болон түүний тэнгэр элч нар тулалдаад , тэдэнд хүч дутсан бөгөөд тэдэнд тэнгэрт байх газар олдсонгүй. Өнөөх агуу том луу буюу бүх ертөнцийг мэхлэгч Диавол ба Сатан гэгддэг эртний могой доош хаягдав. Тэр дэлхий уруу хаягдлаа. Түүний хамт тэнгэр элч нар нь ч доош хаягдав.

Би тэнгэрт чанга дуугаар ингэж халэхийг сонсов.

- Бурханы өмнө ах дүүсийг маань өдөр шөнөгүй буруутгадаг тэднийг буруутгагч доош хаягдсан учраас эдүгээ бидний Бурханы аврал, хүч, хаанчлал, ба Түүний Христийн эрх мэдэл хүрч ирлээ. Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр илжээ. Тэд үхэн үхтлээ амна сайрлаагүй юм. Тиймээс тэнгэрээ, тэнд нутаглагсад аа, баярлан хөөрөгтүн. Газар ба тэнгис золгүй еэ, Яагаад гэвэл диавол үлэмж их уур хилэнтэйгээр та нар уруу бууж ирсэн. Өөрт нь богинохон хугацаа байгааг тэр мэдэж байгаа. Луу дэлхий уруу хаягдсанаа

хараад, хүү төрүүлсэн өнөөх эмэгтэйг мөшгөлөө. Эмэгтэйг цөлд өөрийнх нь газарт нисэж очуулахын тулд түүнд асар том бүргэдийн хоёр далавч өгөв. Эмэгтэй тэнд могойноос алс байж нэг үе ба хоёр үе, хагас үед тэжээгдсэн юм. Эмэгтэйг голын урсгалаар урсгахын тулд түүний араас могой амнаасаа гол мэгусыг гаргаж урсгав. Газар эмэгтэйд туслан, амаа нээж лууны амнаасаа урсгасан голыг залгилаа. Луу мөнөөх эмэгтэйд хилэгнэж, Бурханы хуулиудыг болон Есүсийн гэрчлэлийг сахьдаг, эмэгтэйн бусад үр удамтай нь дайтахаар явав. Тэр тэнгисийн эргийн элсэн дээр зогслоо.

Хийх зүйлс

А.Хоосон зайг ишлэлүүдийн үгээр нөхөж бич.

1. Тэнгэрт нэгэн тэмдэг үзэгдэв. өмсөж хөл доороо, тэргүүн дээрээ одны титэмтэй байв. (Ишлэл1).

[Энэ эмэгтэйгээр Есүс Христийн мэндэлсэн Израилийн 12 овогийг дүрсэлж болох юм. Израилийг ихэнхдээ эмэгтэй хүнээр тодорхойлдог. Израилийн хөвгүүдийг од болгон харсныг Эхлэл номны 37:9 харж болно.]

2. Тэнгэрт өөр нэг тэмдэг үзэгдэв. Харагтун агуу том улаан байна. Луу эмэгтэйг залгихын тулд төрөх гэж буй эмэгтэйн өмнө зогслоо.

[Луу бол Сатан юм.(Ишлэл12). Есүсийг төрөх үед Сатан Түүнийг алах гэж хичээнэ. Харин тэнгэр элч Есүсийн эцэг эх Мариа Иосеф хоёрт Египет уруу зугтахыг зааварчилсан. Херод хаан Бетлехем болон түүний ойр орчимд (Есүсийн төрсөн газар) хоёр болоод түүнээс доош насны эр хүйсний бүх хүүхдийг хөнөөлгөхийг тушаав .(Матай 2:16).]

3.Тэр эмэгтэй бүх таягаар хариулах эрэгтэй хүүхэд төрүүлэв. Хүүг Бурханд, Түүний аваачлаа. (15).Түүнийг Есүс гэдгийг бид мэднэ. (Илчлэлт19:15 хар) “Ингээд Эзэн Есүс тэдэнд айлдсаны дараа тэнгэр өөд авагдаж, Бурханы баруун гарт залрав. (Марк 16:19).]

4. Өнөөх эмэгтэй бэлдсэн газар бүхий уруу зугтав. Тэнд түүнийг хоногийн турш тэжээх юм.

[Израиль Сатаны уур хилэнгийн он жилүүдээс хамгаалагдсан гэдэг нь тодорхой юм. “Гурав дахь хэсгийг нь Би гал дундуур гарган, мөнгийг цэвэршүүлж , алтыг тунгаадаг шиг тэднийг тунгаана. .(Зехариа 13:9a).

5. Тэнгэрт дайн болов(7)., болон түүний тэнгэр элч нар тулалдав. Өнөөх луу болон тэнгэр элч нар уруу хаягдав (9).

[Тэргүүн тэнгэр элч Михаел Израиль үндэстний төлөө байлдсан.

(Даниел 12:1). Түүхийн туршид Сатан бүх талаараа Израилийн эсрэг өс хонзон санадаг бөгөөд Бурханы хайртай хэнд ч өс хонзон санадаг.]

В. Илчлэлт12:11 цээжил.

Сатан Бурхан болон Түүний хүмүүсийн эсрэг байдаг.

“Агуу улаан луу” энэ бол Сатаны өөр нэг нэр юм.“ Тэрбээр диавол ба Сатан болох эртний могой буюу луу (Илчлэлт20:26).

Бурхан анхны хүн Адамд Еден цэцэрлэгийг харж байхыг захисан. “Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү

өгүүлэв.

-Чи

цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө



зайлшгүй үхнэ! хэмээн айлдав. (Эхлэл 2:16-17). Сатан болох могой Бурханы тушаалыг асуун *Еваг мэхэлсэн*. Тэр жимсийг идсэн бөгөөд харин Адам Бурханд дуулгаваргүй байсан юм. Түүний гэм нь Бурханы хэлснээр үхлийг дэлхий дээр авчирсан. Бурхан могойд ингэж хэлэв. Би чамайг тэр эмэгтэйтэй өс хонзонтой, Бас чиний үр хүүхдийг тэр эмэгтэйн үр хүүхэдтэй өс хонзонтой болгох болно. Тэр эмэгтэйн үр хүүхэд чиний толгойг няцалж, чи түүний өсгийг няцлах болно. (Эхлэл 3:15). Бүх түүхийн туршид -Устгагч- Сатан Бурханы хүмүүс болон амласан аврагчийг устгахыг оролдож байна. Есүсийг загалмайд цовдлогдон нас барахад Сатан Түүний өсгийг бяцарсан. Харин Түүнийг үхлээс дахин амиллахад Сатан хүч чадлаа алдсан. "Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ. (1 Иохан 3:86).

Ахан дүүсийг Буруутгагч

Сатаныг "Ахан дүүсийг Буруутгагч" гэж дууддаг. Бид түүний хийдэг ажлыг үнэнч шударга Иовын түүхээс харж болно. Нэг өдөр Сатан Бурханы өмнө ирж Иовыг сорихыг Бурханаас гуйсан. Учир нь Иов ихээр ерөөгдсөн байжээ. Бурхан Сатанд сорих зөвшөөрөл өгөв. Сатан бүхий л чадах муу зүйлээ хийв. Иовын арван хүүхэд алагдав. Тэр бүх хөрөнгөө дээрэмдүүлж устгуулсан юм. Түүний бие өвчилж биеэр нь хатиг гарсан байлаа. Түүний эхнэр Иовд "Бурханыг хараагаад үх гэв". Харин Иов Бурханы эсрэг

юу ч хэлээгүй юм. Харин ч тэр ингэж хэлэв. "Тэр намайг алах ч гэсэн би Түүнд найдах л болно. (Иов 13:15а). Харин Иов өөрийгөө Бурханы үнэнч дуулгавартай хүний жишээ болж байгаагаа мэдэхгүй байлаа. Гэвч тэр Бурханд итгэж байсан. Дараа нь Бурхан



түүнийг илүү их ерөөж түүнд илүү их олон хүүхэд мөн урьд өмнө байснаас нь илүү ихийг түүнд өгөв.

Санагтун: Хэрэв та Бурханых бол таныг ямар ч нөхцөл байдалд байсан Бурхан танд сайныг хийнэ.. "Бурханыг хайрладаг Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст тохиолддог бүхий л зүйл эцэстээ тэдний сайн сайхны төлөө байдаг гэдгийг бид мэднэ. Тэр өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм. (Ром 8:28-29).

Амьдралын хүнд сорилт Таныг улам Христ шиг болгоно. Энэ бол сайн!

Мөн санагтун: Бурхан таныг хэзээ ч буруутгадаггүй. Тэр таныг гэмшихэд, таныг нүглээсээ ангижрахад тань хөтөлдөг ба таныг хамгаалдаг. Эш үзүүлэгч Зехариа Тэргүүн тахилч Иошуагийн харааг олж харсан. "Дараа нь тэр надад Эзэний тэнгэр элчийн өмнө зогсож буй тэргүүн тахилч Иошуаг болон түүнийг буруутгахаар баруун гар талд нь зогсож буй Сатаныг үзүүлэв. Эзэн Сатанд

-Сатан аа Эзэн чамайг буруушааж байна Үнэхээр Иерусалимыг сонгосон Эзэн чамайг буруушааж байна энэ бол галаас авагдсан тамга бус уу гэв. (Зехариа 3:1-2).

Иошуа хир буртагтай (түүний шударга бус явдлыг дүрсэлсэн) дээлээ цэвэрхэн хувцсаар сольсон байв. Хэрэв та Бурханы замаар явбал таны гэм нүгэл уучлагдаж Бурхан Иошуад төлөвлөгөө төлөвлөсөн шиг танд мөн

төлөвлөнө. Танд Түүнд үйлчлэх газар байх хэрэгтэй. Таны өнгөрсөн гэмээс чинь болж "Ах дүүсийг буруутгагч" таныг итгэлгүй болгох гэж оролдоно. Гэвч та бүү тоогоорой. "Тэр нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө нүгэл болгосон юм. "Тэгснээр бид Түүний дотор Бурханы хүртээх зөвт байдал болох юм. (2 Коринт 5:21). Тэр таныг Өөрийнхөөрөө зөвтгөсөн.

"Тэгвэл бид эдгээр зүйлийн тухай юу хэлэх вэ? Хэрэв Бурхан бидний талд юм бол хэн биднийг эсэргүүцэх вэ?"

Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах вэ? Бурхан нь Зөвтгөгч нэгэн мөн.

Ялладаг нь хэн юм бэ? Христ Есүс нь үхээд, бүр амилуулагдсан, Бурханы баруун талд байдаг бидний төлөө зуучлан гуйдаг нэгэн юм. (Ром 8:31,33—34).

Бурхан таны ТӨЛӨӨ, Тэр Хүүгээ ТАНЫ төлөө үхүүлсэн. Тэр таныг зэмлэхгүй. Есүс таны төлөө яг одоо залбирч байгаа! Хэнд ч таны уучлагдсан гэмийг дахин сөхөхийг бүү зөвшөөр. "Хар санаат хүн хорон мууг ухаж гаргадаг. Түүний үгс дүрэлзэх гал мэт болой. (Сургаалт үгс 16:27).

Та Христийн шинэ амьдралаар амьдарч байгаа учраас, Бурхан таныг гэм хийлгэхийг хүсэхгүй. Гэвч та гэм хийсэн бол Христийн Сүнс танд гэм хийж байгааг чинь тодорхой сануулдаг. Даруу төлөв байж Түүгээр нүглээ уучлуул. "Хэрэв хэн нэгэн нь нүгэл үйлдвэл, Эцэгийн өмнө бид өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн. "Гэмийг уучилдаг, Өөрийн өвийн тэрслүү үйлдлийг хэрэгсдэггүй Тантай адил Бурхан хэн юм бэ? Тэр хувирашгүй хайранд баясдаг тул уур хилэнгээ мөнхөд хадгалдаггүй. (Мика 7:18). Сатан таныг буруутгахыг оролдох болно. Бурханы нигүүслийн талаар бага мэддэг хүмүүс хүртэл таныг буруутгах болно. Гэвч биднийг нүглээ гэмших үед Бурхан биднийг уучилдаг. Учир нь Есүсийн цус биднийг бүхий л зөвт бус байдлаас цэвэрлэсэн. (Иохан 1:7,9).

Хурганы цус

Илчлэлт номны 12:11 танд хэрхэн ЯЛСАН амьдралаар

амьдрахыг заадаг. Сатан бидэн руу дайрдаг бөгөөд учир нь Есүс Христийн цус бидний итгэлийг гэрчилдэг бөгөөд Түүний цус үхэлтэй тулгарахад хүртэл хамгаалдаг.

Есүсийн цус МАШ ЧУХАЛ. Яагаад цус Бурханд чухал гэж?

“Учир нь махан биеийн амь цусанд байдаг бөгөөд түүнийг Би та нарт өөрсдийн чинь амийн төлөө эвлэрүүллийг тахилын ширээн дээр хийхээр өргөсөн юм. (Левит 17:11).



Амьтнаар тахил тахьдаг бүх өдрийг төлөөлөн Бурханы гэмгүй Хурга, Есүс өөрийн цусаа урсган гэмийг өөрийн цусаар зайлуулсан. “Тэр ямаа болоод тугалын цусаар бус, харин мөнхийн золилтыг агуулан, Өөрийнхөө цусаар ариун газарт нэг удаа бүгдийн төлөө орсон. (Еврей 9:12). Та зөвхөн Есүсийн цус таныг гэмээс цэвэрлэнэ гэдэгт итгэж байна уу? Есүс таныг гэм үхлийн боолчлолоос чөлөөлсөн. Бурханд талархъя! “Учир нь Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, Өөрийн хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм. Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох золилт байна. (Колоссай1:13-14).

Итгэгч нартай хийх дайн

Сатан маш их уурлах бөгөөд учир нь түүнд мөнхийн үхэл уруу хаягдахад бага цаг хугацаа үлдсэнийг тэр мэдэж байгаа. Тэр таныг мөнхийн амьдралаас холдуулахын тулд бүхий л аргаар ятгах болно. Паул Тимотод хэлсэн нь “Харин Бурханы эр хүн ээ, чи энэ бүгдээс зайлсхий. Зөв байдал, бурханлаг байдал, итгэл, хайр, тэвчээр ба дөлгөөн занг эрхэмлэ. Итгэлийн сайн тэмцлээр тэмц. Мөнх амийг барьж ав, Чи мөнх амь уруу дуудагдсан бөгөөд олон гэрч нарын өмнө сайн гэрчлэл хийсэн. (1Тимот 6:11,12а).

Сатан таны сэтгэл санаа уруу халдах бөгөөд таныг хүмүүстэй үл ойлголцуулан уурлуулахыг оролдох болно. Гэвч та битгий алдаа гаргаарай. Бид хүмүүстэй байлдах ёсгүй. Бидний дайн бол Сатаны эсрэг сүнсний дайн юм.

“Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ. (Ефес 6:12).


Учир нь бидний дайн сүнснийх учраас, бид нар дэлхийн хүмүүстэй тулалдаж болохгүй. Бидэнд сүнслэг зэвсэг хэрэгтэй. Давидын аврага Голиаттай хэрхэн тулалдсан тухай та санаж байна уу? Тэр хэлэхдээ” Чи илд, бамбай, жад барьж ирж байгаа бол, Харин би Эзэний нэрээр чам уруу ирж байна. (1 Самуел 17:456).” Учир нь бидний байлдааны зэвсэг бол махан биеийнх биш, цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит зэвсгүүд юм. Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг. (2 Коринт 10:4,5).

Сатан бидний амьдралыг бүхий л талаар ялалхыг оролдох болно. Бидний оюун бодолд орж ирж байгаа Бурханы үгтэй нийцэхгүй бүхий л зүйл үгүйсгэгдэх ёстой. Бид оюун санаагаа Бурханы хүчирхэг зэвсэг болох үнэн үгээр дүүргэх ёстой.

Бурханы хуяг дуулга

“Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. Тэгээд бат зогс. Ингэхдээ та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэлж, зөвт байдлын хуягийг өмсөөд, амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс. Энэ бүгд дээр муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн бамбай авралын дуулгыг болон сүнсний сэлэм буюу Бурханы үгийг ав. Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. (Ефес 6:13-18а).

Зөвхөн Бурханы бүх хуяг дуулгыг өмссөн цагт бид нар чөтгөрийн заль мэхний эсрэг зогсож чадна. Үнэн Сатаны худал, заль мэхтэй тулалдах болно. Христийн зөвт байдлыг өмсөж Бурхантай хамт байж дайсны биднийг буруутгаж байгаа гэцийг ялан дийлцгээе. Бидний авралын баталгаа



нь Бурханы амласан Христийн цус бөгөөд бидний итгэлийг улам хүчтэй болгодог. Бурханы үнэн үгийг мэдэж байх нь бүх төрлийн сорилтыг даван туулахад тусалдаг. Есүсийг дэлхий дээр байхад диовал хэд хэдэн удаа Түүнийг сорьсон. Диовал сударыг ашиглан Христийг гэмд унагах гэж сорьж байсан. Тэр "Нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ. (Еврей 4:15а). Есүс соригдох бүрдээ Судраар хариу хэлж байв. Тэр Сатанд Түүнийг орхиж явахыг хэлээд мөн түүнд " ингэж бичигдсэн...", гэж Сударыг давтан хэлж байв. (Матай 4:4,7,10).

Учир нь Есүс сорилтыг ялан дийлсэн шигээ, Тэр таныг мөн ялан дийлэхэд тусалж чадна. "Учир нь Тэр Өөрөө соригдон зовлон эдэлж байсан тул сорилтод орогсдод тусалж чадна. (Еврей 2:18).

ХИЧЭЭЛ 23. ТЭНГИСЭЭС ГАРСАН АРААТАН

Илчлэлт 13:1-10

"Тэнгисээс арван эвэртэй, долоон толгойтой араатан гарч ирэхийг би харав. Түүний эврүүд дээр арван титэм, толгойнууд дээрээ Бурханыг доромжилсон нэрстэй байлаа. Миний харсан тэр араатан ирвэстэй адил

бөгөөд хөл нь баавгайнх шиг, ам нь арслангийнх шиг байв. Луу түүнд өөрийн хүч ба сэнтий, асар их эрх мэдлийг өгөв. Түүний толгойнуудын нэг нь алуулчихсан юм шиг байсныг харлаа. Үхлийн шарх нь эдгэсэн байв. Дэлхий

даяараа гайхширч, араатны араас дагалаа. Луу араатанд эрх мэдлээ өгсөн тул тэд луунд мөргөв. Тэд араатанд мөргөөд

-Хэн энэ араатны адил юм бэ? Хэн түүнтэй дайн хийж чадах юм бэ? гэгцгээв. Агуу юмсыг болон доромжлолыг хэлэгч амыг түүнд өгсөн бөгөөд дөчин хоёр сарын турш үйлдэх эрх мэдлийг түүнд өгсөн аж. Тэр Түүний нэр, асар болон тэнгэр дэх нутаглагсдыг доромжлохын тулд Бурханыг доромжлохоор амаа нээв. Ариун хүмүүстэй дайн хийж,

тэднийг ялах нь түүнд өгөгдсөн бөгөөд аливаа овог, ард түмэн, хэлтэн, үндэстнүүдийг захирах эрх мэдлийг ч түүнд өгсөн байлаа. Алагдсан Хурганы амийн номд ертөнцийн суурнас хойш нэр нь бичигдээгүй дэлхий дээр нутаглагч бүх хүн түүнд мөргөнө. Хэрэв чихтэй хүн байвал сонсогтун. Хэрэв хэн нэгэн нь баригдах тавилантай бол баригдана. Хэрэв хэн нэгэн нь илдээр алдаг бол тэр илдээр алуулах ёстой. Энд ариун хүмүүсийн тэвчээр, итгэл байна.

Христийг эсэргүүцэгчид

Цаг хугацаа төгсөх үед, Сатан Бурханы эсрэг хоёр төрлийн хорон аргаар тэмцсэн: Христийг эсэргүүцэгчид (тэнгисээс гарсан араатнаар дүрслэгдсэн.) Хуурамч эш үзүүлэгч (Газар доороос гарсан араатан дүрслэгдсэн 24-р хичээлийг үз.) Иохан Христийг эсэргүүцэгч сүнс аль хэдийн дэлхий дээр орж ирсэн гэж үзсэн: "Энэ бол Христийг эсэргүүцэгч буюу Эцэг болоод Хүүг үгүйсгэгч юм. (1 Иохан 2:22а).

"Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй сүнс бүр Бурханаас ирээгүй. Энэ бол Христийг эсэргүүцэгчийнх бөгөөд та нар түүнийг ирж байна гэдгийг сонссон ба тэр эдүгээ дэлхийд хэдийн байж байна. (1 Иохан 4:3). Та нар Христийг эсэргүүцэгч сүнснээс бүү ай. "Та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу. (1 Иохан 4:4б).

Нэгэн хүн гарч ирэх цаг ирэх бөгөөд, гэм нүглийн хүн,

тамын хүүхэд тэрбээр дэлхийг захирах болно. Түүнд

Сатаны бүх хүч чадал өгөгдөх бөгөөд тэр дэлхийг захирна. Тэр үхлээс дахин амилж байгаа мэт харагдана. Тэр биеэ тоож, эцэстээ өөрийгөө бурхан болгох гэж шаардана. Христэд итгэгч байх улам хэцүү болох бөгөөд, өөрсдийгөө Христэд итгэгч хэмээн илэрхийлдэг хүмүүс үнэндээ Христийн амьдралаар амьдарч чадалгүй унах болно. Жинхэнэ итгэгч нар Бурханы хүч чадлаас ирэх итгэлээр амьдрана. “Ах дүү нар аа, бидний Эзэн Есүс Христийн ирэх хийгээд бидний Түүн уруу цуглах тухайд эдүгээ бид та нараас гуйж байна. Эзэний өдөр ирчихлээ хэмээн та нар ухаан бодлоороо тэр даруй ганхаж дайвалгүй, эсвэл сүнсээр ч юм уу, эсвэл үг яриагаар ч юм уу, эсвэл биднээс ирсэн мэт захидлаар ч үймүүлэгдэхгүй байгтун. Хэн ч та нарыг ямар ч аргаар бүү мэхлэг. Учир нь эхлээд итгэлээс салах явдал гарч, сүйрлийн хөвгүүн болох ёс бусын хүн илчлэгдэхээс нааш тэр өдөр ирэхгүй. Тэр бол эсэргүүцэгч нэгэн бөгөөд өөрийгөө бурхан хэмээгдэгч бүрийн дээр, эсвэл шүтдэг зүйл бүрийн дээр өргөмжлөн зална. Тэгээд өөрийгөө бурхан болгон үзүүлж, Бурханы сүм дотор суудлаа эзэлнэ.

(2 Тесалоник 2:1-4). Хэрэв та Христийг эсэргүүцэгчдийн эцсийн сүйрлийн талаар мэдэхийг хүсвэл Даниел номны 7,8,11 бүлэгийг үз.

Христийг эсэргүүцэгчид Есүсийн амьдралыг олон аргаар дуурайх болно. Эхэндээ Израильчууд түүнийг Мессиа гэж харах болно. Есүс үүнийг зөгнөсөн. “Би Эцэгийнхээ нэрээр ирсэн юм. Гэтэл та нар Намайг хүлээж аваагүй. Хэрэв өөр нэгэн өөрийнхөө нэрээр ирвэл, та нар түүнийг хүлээж авна. (Иохан 5:43). Дэлхийн бүх хүн түүнд мөргөх бөгөөд зөвхөн Христэд итгэгчид л энэ араатанд мөргөхөөс татгалзах бөгөөд тэдний нэр Хурганы амийн номд бичигдсэн байдаг. Христэд итгэгч хүмүүст итгэл тэвчээр заавал хэрэгтэй. “Бузар мууг үйлдэгчээс болж бүү санаа зов, учир нь тэд өвс шиг удахгүй хатан хорчийж” (Дуулал 37:1а,2а).

ХИЧЭЭЛ 24. ГАЗАР ДООРООС ГАРСАН АРААТАН

Илчлэлт 13:11-18

"Газар доороос өөр нэгэн араатан гарч ирэхийг би харав. Тэр араатан хурга мэт хоёр эвэртэй бөгөөд луу мэт яриw. Тэр анхны араатны өмнө бүх эрх мэдлийг нь хэрэгжүүлдэг. Тэгээд дэлхий болоод тэнд нутаглагсдыг үхлийн шарх нь эдгэсэн анхны араатанд мөргүүлдэг ажээ. Тэр агуу тэмдгүүдийг үйлддэг төдийгүй хүмүүсийн өмнө тэнгэрээс газарт гал буулгадаг. Өнөөх араатны өмнө бүтээх тэмдгүүд нь түүнд өгөгдсөн тул илдний шархтай атлаа амилсан араатанд зориулан хөрөг бүтээ гэж дэлхий дээр нутаглагсдад хэлэн, тэрээр дэлхий дээр нутаглагсдыг

мэхэлдэг. Түүнд араатны хөрөгт амьсгал өгөх нь өгөгджээ. Ингэснээр тэрхүү араатны хөрөг ярьж, араатны хөрөгт мөргөдөггүй бүх хүмүүсийг алуулах юм. Тэрээр том жижиг, баян ядуу, чөлөөт хийгээд боол хүмүүсийн болон бүгдийн баруун гаран дээр нь, эсвэл духан дээр нь тэмдэг тавиулснаар тэмдэг, араатны нэр, эсвэл нэрийн нь тоотой хүнээс өөр нэг ч хүн худалдаж, худалдан авч чадахгүй болох ажээ. Энд мэргэн ухаан байна. Учир нь энэ нь хүний тоо бөгөөд түүний тоо бол зургаан зуун жаран зургаа юм.

Хуурамч эш үзүүлэгч

Газар доороос гарч ирсэн араатан нь Христийг эсэргүүцэгчдийг шүтдэг хүмүүсийг билэгдэж байна. Бурхан Өөрийн ард түмэндээ эш үзүүлэгчдийг илгээдэг байсан. Тэр гайхамшгийг үзүүлж байсан. Харин одоо Сатанд эрх мэдэл өгөгдсөн бөгөөд хуурамч эш үзүүлэгчид гайхамшгийг үзүүлэх болно. Тэр гайхамшгуудыг үзүүлэх чадалтай бөгөөд харин Бурханы хүн гэдгээ үргэлж батлахгүй. Есүс хэлсэн нь "Тэр өдөр Надад олон хүн "Эзэн минь, Эзэн минь бид Таны нэрээр эш үзүүлж Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?" гэж хэлэх

болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ. (Матай 7:22,23).

Есүс Сатан болон түүний дагалдагч нар хүмүүсийг хуурахыг анхааруулсан. “Хэрэв хэн нэгэн та нарт “Харагтун Христ энд байна” эсвэл “Тэнд” гэвэл бүү итгэ. Хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, хэрэв боломжтой бол сонгогдогсдыг хүртэл төөрөлдүүлэхийн тулд агуу тэмдгүүд гайхамшгуудыг харуулах болно. Үзэгтүн. Би та нарт урьдаас хэлсэн. (Матай 7:23-25).

Тэр “араатан” хурга шиг харагддаг боловч луу шиг ярьдаг байв. Тэр эелдэг дөлгөөн харагдах боловч түүний яриа түүнийг Сатанд үйлчилдэг гэдгийг илчилдэг. “Сатан ч өөрийгөө гэрлийн тэнгэр элч болгон хувиргадаг учраас гайхах юм алга.Тиймээс хэрэв түүний зарц нар бас өөрсдийгөө зөвт байдлын зарц нар болгон хувиргах аваас энэ нь гайхмаар юм биш аж. Тэдний төгсгөл үйлсийнх нь дагуу байх болно. (2 Коринт 11:14б,15). Тэр араатанг (Христийг эсэргүүцэгч) дүр төрхөө өөрчлөхийг зөвшөөрсөн. Энэ нь магадгүй Матай 24:15 мөн эш үзүүлэгч Даниелын хэлсэнчлэн (Даниел 9:27) сүйрэлд хүргэх зэвүүцлийг төрүүлсэн байж болох юм. Ингэж сүмийн ариун газарт зогссоноор Бурханы уур хилэнг авчирсан.

Яагаад хүмүүс ингэж хууртагдаж байна вэ? Есүс шашинлаг хүмүүст тэдний алдаа болохыг хэлж байсан. “Та нар Судрыг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээсээ болж төөрөлдөж байна. (Матай 22:29б).

Хэрэв таны дотор Есүс байхгүй, Үнэний сүнс болон Бурханы библийн үнэн үг оршихгүй байвал та амархан хууртагдах болно. Хүмүүс амархан хууртагддаг учир нь муу ёрын сүнсний итгүүлэх ажил их тархсан байдаг.

“Харин хожмын цагт зарим нь итгэлээ орхиж, мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүдийн номлолд анхаарлаа хандуулна гэж сүнс тодорхой хэлдэг. (1Тимот 4:1). “Тиймээс Бурхан тэдний дээр төөрөгдлийн ажиллагааг

илгээдэг. Тэгээд тэд худал хуурмагт итгэх болно. Ингэснээр үнэнд итгээгүй, бузар мууг таалсан бүх хүн яллагдах юм. (2 Тесалоник 2:11-12).

Ариун бус гурвал

Энэ гурван холбоо нь – Луу (Сатан), Христийг эсэргүүцэгч, Хуурамч эш үзүүлэгч гэсэн ариун бус холбоо бөгөөд Бурханы гурвал болох Эцэг Бурхан, Хүү, Ариун Сүнс гэсэн холбоог дуурайдаг. Есүс Бурханы Хүү гэж дуудагддаг. Христийг эсэргүүцэгч “тамын хүүхэд [устгагч] гэж дуудагддаг. Энэ мөн Сатаны хүүхэд гэсэн утгатай. Ариун Сүнс жинхэнэ итгэгч нарыг Есүс уруу хөтөлж авч явдаг шиг Хуурамч эш үзүүлэгчийн гол ажил нь Христийг эсэргүүцэгчдэд мөргүүлэх явдал юм. Ариун Сүнс Бурханы хүмүүсийг тамгалдаг бол харин Хуурамч эш үзүүлэгч Сатанд итгэдэг хүмүүст тэмдэг тавьдаг.

Араатны тэмдэг

Араатны тэмдэг нь итгэгч биш хүмүүст байх бөгөөд тэд нар ямар ч барааг худалдан авч эсвэл худалдаж чаддаг байсан, Христийг эсэргүүцэгчдэд мөргөснөөр нь тэднийг таних юм. Тэмдэг хүний баруун гар эсвэл духан дээр тавигдсан байна. Ийм тэмдэг хэзээ ч бүү ав, үхэлд хүргэх өлсгөлөн байсан ч тэр. (Тэнгэрийн улсад та хэзээ ч өлсөхгүй). Энэ тэмдэг нь эзэмшигчтэй. Та Сатан болон Бурханы тэмдгийн хоёуланг нь сонгож эзэмших боломжгүй юм. Та аль нэгэнд нь үйлчлэхээ сонгох хэрэгтэй. Есүс хэлэхдээ “Хоёр Эзэнд үйлчлэдэг зарц байдаггүй. Учир нь тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлана. Эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцдэг. Та нар Бурханд ба эд баялагт зэрэг үйлчилж чадахгүй гэв. (Лук 16:13).

Араатны тоо:666

Энэ тооны тухай олон таамаглал утга байдаг. Сударт 6 гэдэг тоо нь хүний тоо байдаг ба төгс тэнгэрлэг тоо болох 7-гийн тоонд хүрдэггүй. 6-гийн тоо нь зүүний шашинлаг

нууцлаг тоо юм. Энэ дугаар нь 666 (гурван 6) Христийг эсэргүүцэгчдийн дугаар бололтой. Эцэстээ энэ нь Христийн эсрэг гарч ирэх хүний тоо. Долоо нь төгс тоо бөгөөд, Сатан энэ тоонд хүрч чадаггүй.

ХИЧЭЭЛ 25. 144,000 ШИНЭ ДУУ СУРАВ.

Илчлэлт 14:1-5

“Харагтун, Сион уулан дээр Хурга зогсож байхыг би харлаа. Духан дээрээ Түүний нэр ба Эцэгийнх нь нэр бичээстэй зуун дөчин дөрвөн мянган хүн Түүнтэй хамт байлаа. Асар их усны чимээ, хүчит аянгын нүргээн шиг дуу тэнгэрээс сонсогдлоо. Миний сонссон дуу бол босоо ятгачид ятгаар тоглож буй эгшиг ая мэт байлаа. Тэд сэнтийний өмнө болон дөрвөн амьтан, мөн

ахлагчдын өмнө шинэ дуу дуулав. Дэлхийгээс худалдаж авагдсан зуун дөчин дөрвөн мянган хүнээс өөр хэн ч тэр дууг сурч чадсангүй. Тэд бол өөрсдийгөө эмсээр бузарлаагүй хүмүүс юм. Учир нь тэд ариун аж. Тэд бол Хургыг хаашаа ч явсан, Түүнийг дагадаг хүмүүс. Тэднийг Бурхан болон Хурганы төлөөх анхны үр жимс болгон хүмүүсийн дундаас худалдан авсан ажээ.

Аврагдсан хүмүүс Хургыг дагасан нь

Энэ 144,000 хүн нь илчлэлт номны 7-дугаар бүлэгт гардаг хүмүүс юм. Тэд нар Еврей итгэгч нар бөгөөд төгсгөл хүртэл Бурханд үйлчилсэн. Тэд духан дээрээ Тэнгэрлэг Эцэгийн тэмдэгтэй бөгөөд энэ нь араатны тэмдэг биш юм. Тэд Есүс Христэд үйлчлэхээр амьдралаа зориулсан. Эдгээр итгэгч нараар дамжуулан бид нар өөрсдийн одоогийн амьдралдаа олон юм сурч болно.

1. Тэд эмэгтэй хүнтэй завхайраагүй. Тэд онгон байсан. Судар хэлэхдээ, “Бүгд гэрлэлтийг хүндлэгтүн. Ор дэр нь бузартаагүй байг. (Еврей 13:4а). Хэдий тийм ч Бурханаас ганц бие байхаар дуудагдсан хүмүүс ч байдаг. (Матай 19:12). Паул ийм байсан. “Гэрлээгүй болон бэлэвсэн хүмүүст хандаж, хэрэв та нар над шиг байгаа хэвээрээ

байвал тэдэнд сайн гэж би хэлдэг. (1 Коринт 7:8). Эдгээр Христийн дагалдагч нар нь мөн сүнсний хувьд онгон байсан.Тэд үнэнчээр үйлчилж байсан бөгөөд өөрсдийгөө араатны төрхөөс хамгаалж байсан. Тэд Есүст үнэнч дуулгавартай байсан.

2. Тэд Хургыг хаашаа ч явсан Түүнийг дагадаг. Есүс хэлэхдээ, "Хэрэв надад үйлчлэх хүн байвал, Намайг дага. Хаана Би байна, тэнд бас Миний зарц байх болно. (Иохан 12:26а).

3. Тэдний аманд ямар ч худал байхгүй." Зөв шударга хүн худал хуурмаг зүйлийг үзэн яддаг. (Дуулал 13: 5а).

4. Тэд Бурханы сэнтийний өмнө гэм буруугүй. Энэ хэр боломжтой вэ? Бидний аврагч Бурхан бол " таныг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, гэм зэмгүйгээр зогсоож чадна. (Иуда 24б ишлэл).

Баяр хөөртэй дуу тэнгэрт байдаг

"Таны өмнө баяр хөөр дүүрэн байдаг. Таны баруун мутарт үүрд баяр жаргал байдаг. (Дуулал 16:11б). Бурханд талархах бидний талархал шинэ дуугаар илэрхийлэгдэж болно. " Тэр миний аманд шинэ дуу болох бидний Бурханд өргөх магтаалын дууг оруулав. Олон хүн хараад эмээж, Эзэнд итгэх болно. (Дуулал40:3). Яагаад яг одоо Бурханыг өөрийн зүрх сэтгэлийн дуугаар магтаж болохгүй гэж!

ХИЧЭЭЛ 26. ГУРВАН ТЭНГЭР ЭЛЧИЙН НОЦТОЙ ИЛГЭЭМЖ

Илчлэлт 14:6-13

"Тэдний амнаас ямар ч худал олдсонгүй. Тэд гэм зэмгүй. Тэнгэрийн дундуур өөр нэгэн тэнгэр элч нисэж явахыг би харав. Газар дээр суугчид ба аливаа үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд

тунхаглах мөнхийн сайн мэдээ түүнд байна. Тэр чанга дуугаар

- Бурханаас эмээгтүн. Түүнд алдрыг өргө. Яагаад гэвэл Түүний шүүх цаг ирчихээд байна. Тэнгэр ба

газрыг, тэнгис ба усны ундаргуудыг бүтээсэн Түүнд мөргөгцөө галээ. Өөр нэгэн тэнгэр элч буюу хоёр дахь нь араас нь даган

- Агуу Вавилон, өөрийнхөө садар самууны тачааллын дарснаас бүх үндэстэнд уулгасан тэр нурлаа, нурлаа гэж байлаа. Өөр нэгэн тэнгэр элч буюу гурав дахь нь тэднийг даган чанга дуугаар

- Хэрэв хэн араатанд болон хөрөгт нь мөргөж, духан дээрээ, эсвэл гар дээрээ тэмдэг авна, тэр хүн Бурханы уур хилэнгийн дарсыг мөн уух болно. Энэ нь Түүний уур хилэнгийн аягаид шингэлэлгүй хольсон дарс юм.

Тэр хүн ариун тэнгэр элч нарын ба Хурганы өмнө гал, хүхэр дотор зовж тарчилна. Тэдний зовлон тарчлалын утаа үеийн үед суунаглана. Араатанд ба түүний хөрөгт мөргөгсөд, Түүний нэрийн тэмдгийг хүлээн авагч аливаа хүн өдөр ч, шөнө ч амрахгүй. Бурханы тушаалууд хийгээд Есүст итгэх итгэлийг сахьдаг ариун хүмүүсийн тэвчээр энд байна. - Одооноос эхлэн Эзэн дотор үхэгсэд нь ерөөлтэй еэ, гэж бичигтүн гэх дуу тэнгэрээс гарахыг би сонсов. Сүнс

- Тиймээ, тэд ажлаасаа салж амраг. Учир нь үйлс нь тэднийг дагадаг гэж айлддаг.

Тэнгэр элч нар

Библид олон удаа тэнгэр элч нар Бурханы хүмүүст туслах юмуу Бурханы дайсанг устгаж байгаа тухай гардаг. "Тэд бүгдээрээ авралыг өвлөх хүмүүсийн төлөөх үйлчлэлд илгээгдсэн үйлчлэгч сүнснүүд биш үү? (Еврей 1:14).

Энэ бол араатанг шүтэх биш харин Бүтээгч Бурханыг шүтэх эцсийн дуудлага. Гурав дахь тэнгэр элч хүнд хэцүү анхааруулгыг авчирсан. Араатны тэмдэгтэй хүмүүс мөнхөд зовж тарчилна. Үүнийг мэдэх нь хавчигдаж буй итгэгч хүмүүст тэвчээр хатуужилтай болоход туслах юм. "Учир нь цаг зуурын ялихгүй зовлон нь бидэнд мөнх алдрыг үлэмж арвинаар бий болгож байна. (2 Коринт 4:17).

Итгэгч хүмүүсийн хувьд үхэл нь ерөөл юм.

Итгэгч хүмүүсийн хувьд үхэл нь мөнхийн жаргал уруу хөтөлдөг. Итгэгч хүмүүс үхлийг өнгөрөөсөн бөгөөд

үнэндээ тэд үхлийг харахгүй. (Иохан 5:24, 11:26). Бурхан бидний бүх зүйл дээр хамт байдаг. “Үхлийн харанхуй хөндийгөөр туулавч, Би хор хөнөөлөөс айхгүй, Учир нь та надтай хамт байна. (Дуулал 23:4). Паул хэлсэн нь “Миний хувьд амьдрах нь Христ, үхэх нь ололт юм. (Филиппой 1:21). “Зөв шударга хүнийг муугаас холдуулж. (Исаиа 57:16). Бие нь үгүй болсон ч Эзэнтэй хамт байдаг. (2 Коринт 5:8).

ХИЧЭЭЛ 27. ДЭЛХИЙГЭЭС ХОЁР УРГАЦ АВСАН НЬ

Илчлэлт 14:14-20

“Үзэгтүн, би нэгэн цагаан үүл харав. Тэргүүн дээрээ алтан титэмтэй, мутартаа хурц хадуртай, Хүний Хүүтэй адил нэгэн нь тэр үүлэн дээр заларч байлаа. Өөр нэгэн тэнгэр элч сүмээс гарч ирж, үүлэн дээр Залрагчид хандан

- Хадуураа илгээ. Дэлхийн тариа боловсорч, ургац хураах цаг болсон тул хадаж аваач гэж чанга дуугаар хашхирч байна. Үүлэн дээр Залрагч хадуураа дэлхий дээгүүр ширвэсэнд дэлхий хураагдсан байлаа. Тэнгэр дэх сүмээс өөр нэгэн тэнгэр элч гарч ирэв. Түүнд бас хурц хадуур байв. Галыг захирах

хүчтэй өөр нэгэн тэнгэр элч тахилын ширээнээс гарч ирээд, хурц хадуртай тэнгэр элчид хандан

- Хурц хадуураа илгээ. Үзэм нь боловсорсон тул дэлхийн усан үзмийн модноос үзмийн багцыг хураагаач гэж чанга дуугаар дуудан хэлэв. Тэнгэр элч хадуураа дэлхий рүү ширвэж, дэлхийн усан үзмийн багцыг хураагаад, Тэдгээрийг Бурханы уур хилэнгийн агуу их шахуургад хаялаа. Шахуурга нь хотын гадна шахагдаж, шахуургаас цус гарч, морины хазаарт хүрэм, мянга зургаан зуун стадиа газар урслаа.

Ургац хураагдсан нь

Дэлхий дээр байгаа жинхэнэ итгэгч нарыг Их Эзэн Есүс ургац мэт хураах болно. Тэр дэлхий дээр байхдаа өөрийгөө Бурханы үгийг тариалагч хэмээн тодорхойлсон. Үр нь дөрвөн янзын хөрсөн дээр ургасан байна.(Матай

13:3-9, 18-23):

(1) Замын хажууд. Бурханы үгийг сонссон боловч ойлгоогүй хүмүүс, ёс суртахуунгүй байдлыг эрхэмлэсэн, хатуу хөрсөн дээр суулгасан үрийг идэх гэсэн шувуу мэт.

(2) Чулуурхаг газар. Бурханы үгийг сонсоод баяр хөөртэй байх боловч түүнд баттай суурь байхгүй, Бурханы үгээс болж хавчигдах үед тэр бүдрэх болно. Тэр дэлхийн гүехэн хөрсөн дээр унасан үр мэт байх бөгөөд нар гарах үед хатах болно.

(3) Өргөстэй ургамал дунд. Бурханы үгийг сонссон боловч дэлхийн заль мэхэнд хутгалдсан, тэр ямар ч үр жимсгүй болно.



(4) Сайн хөрсөн дээр. Бурханы үгийг сонсоод ойлгосон, түүний дотор байгаа Христийн амьдрал үр жимс ургуулах болно. Үр суулгаснаас 100 дахин илүүг хураах болно. Есүс хэлэхдээ "Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин хэрвээ тэр үхвэл олон үр бий болгоно. Өөрийн амийг хайрлагч хүн түүнийгээ алдана. Энэ ертөнцөд өөрийн амийг үзэн яддаг

хүн түүнийгээ мөнх аминд хүртэл хамгаалах болно. (Иохан 12:24б,25).

Христийн шинэ амьдрал бий болоход танд гэрийн үхэл үгүй бөгөөд харин та зөвт байдлын ургац болно. Өөр нэгэн сургаалдаа Есүс хоёр өөр төрлийн ургац байхыг хэлсэн. Улаан буудай болон хогийн ургамал. Дайсан улаан буудайн дунд хогын ургамлыг тариалах болно. Есүс хэлсэн нь "Ургац хураатал хамтдаа ургаг. Ургац хураах цагт би хадах хүмүүстээ <Эхлээд зэрлэг өвсийг зулгааж, боогоод шатаахад бэлэн болго. Харин буудайг цуглуулж амбаарт хийцгээ> гэж хэлнэ гэв. (Матай 13:30).

Усан үзмийн ургац хураагдсан нь

Энэ ургац хэр их өөр вэ? Гэмшээгүй, ёс суртахуунгүй хүмүүс шүүгдэхэд бэлэн болоход Бурханы уур хилэн тэдэн дээр бууж тэд усан үзэм мэт шахагдах болно. Хүн шударга бус явдалд унатал Бурханы уур хилэн түүн дээр буухгүй."Нүгэл нь биеллээ олохоороо үхлийг авчирдаг аж. (Иаков 1:15б). Ийм хэрэг явдал болох үед цус цалгих болно. Хармагедоны тулаан дээд цэгтээ хүрэх үед цусан гол 200 миль хүртэл үргэлжилнэ. (Хичээл 32 хар).



ХИЧЭЭЛ 28. ЯЛАЛТЫН ДУУ

Илчлэлт 15:1-8

"Би тэнгэрт агуу бөгөөд гайхалтай өөр нэгэн тэмдгийг харав. Эцсийн долоон гамшиг бүхий долоон тэнгэр элч байв. Яагаад гэвэл тэдгээрээр Бурханы уур хилэн төгссөн юм. Би галтай холилдсон шилэн тэнгис мэт зүйлийг, мөн араатан ба түүний хөрөгтэй нь, түүний нэрийн тоотой нь тэмцэлдсэн тэмцэлд ялсан хүмүүс Бурханы босоо ятгыг бариад тэрхүү шилэн тэнгис дээр зогсож байхыг харав. Тэд Бурханы боол Мосегийн дууг болон Хурганы дууг дуулав.

-Төгс Хүчит Эээн Бурхан минь, Таны үйлс агуу бөгөөд

гайхалтай. Үндэстнүүдийн Хаан Таны замууд зөвт бөгөөд үнэн. Өө, Эээн, Танаас эмээхгүй, нэрийг тань алдаршуулахгүй хэн байх вэ? Учир нь зөвхөн та ариун билээ. Бүх үндэстнүүд Таны өмнө ирж, мөргөнө. Учир нь Таны зөвт үйлс илчлэгдсэн. Үүний дараа намайг хартал тэнгэр дэх гэрчлэлийн асрын сүм нээгдэв. Цэвэрхэн бөгөөд гялалзсан маалинган хувцастай, цээжээрээ алтан бүс бүсэлсэн, долоон гамшигтай долоон тэнгэр элч сүмээс гарч ирлээ. Дөрвөн амьтны нэг нь үеийн үед амьдрагч Бурханы уур хилэнгээр дүүрэн долоон

алтан аягыг долоон тэнгэр элчид өгөв. Бурханы алдраас болон Түүний хүчнээс гарах утаагаар сүм дүүрэв. Долоон

тэнгэр элчийн гамшиг дуусах хүртэл сүмд хэн ч нэвтэрч чадсангүй.

Авралын дуу

Хурганы цус болон Бурханы хүчээр Израилын ард түмэн Египет дэх боолчлолоос чөлөөлөгдсөний дараа Мосе дуулж байсан. “Эзэн бол миний хүч ба дуу, Тэр миний аврал болсон. Энэ бол миний Бурхан, би Түүнийг магтах болно. (Египетээс гарсан нь 15:2а). Одоо хүмүүс Хурганы цусаар бүгдийг ялсан (Илчлэлт 12:11) бөгөөд тэд нар Хурганы болон Мосегийн дууг дуулж байна.

ХИЧЭЭЛ 29. ДОЛООН ТЭНГЭР ЭЛЧ БА БУРХАНЫ УУР ХИЛЭНГИЙН ДОЛООН АЯГА

Илчлэлт 16:1-21

Сүмээс долоон тэнгэр элчид

- Явагтун, Бурханы уур хилэнгийн долоон аягатайг дэлхий дээр асга гэж чанга дуугаар хэлэхийг би сонсов. Эхнийх нь явж аягатайгаа дэлхий дээр асгав. Араатны тэмдэгтэй болон түүний хөрөгт мөргөсөн хүмүүст муухай, хортой яр гарав. Хоёр дахь нь аягатайгаа тэнгист асгалаа. Тэнгис нь үхсэн хүний цус мэт болоход түүний доторх амьд юм бүхэн үхэв. Гурав дахь нь аягатайгаа гол мөрөн болон усны ундаргууд дээр асгасанд, цус боллоо. Усны тэнгэр элч

-Өө, Ариун Нэгэн минь, Та эдгээрийг шүүсэн тул, байгаа, байсан Та зөвт юм. Яагаад гэвэл тэд ариун хүмүүсийн ба эш үзүүлэгчдийн цусыг урсгав. Та тэдэнд уулгахаар цус өгсөн. Тэднийг ингэвэл зохино гэхийг би сонсов. Тахилын ширээ

-Тийм ээ, Төгс Хүчит Эзэн Бурхан минь, Таны шүүлт бол үнэн бөгөөд зөвт гэхийг би сонсов. Дөрөв дэх нь аягатайгаа наран дээр асгалаа. Хүмүүсийг галаар төөнөхийг түүнд зөвшөөрчээ. Хүмүүс шатам халуунаар төөнөгдсөн ч

эдгээр гамшгуудыг захирах эрхтэй Бурханы нэрийг доромжиллоо. Тэд Түүнд алдрыг өргөө хэмээн гэмшсэнгүй. Тав дахь нь аягатайгаа араатны сэнтий дээр асгав. Түүний хаанчлал харанхуй болж, тэд өвдсөндөө хэлээ хазалж, зовиур, шархнаасаа болж тэнгэрийн Бурханыг доромжлов. Тэд өөрсдийнхөө үйлсэд гэмшсэнгүй. Зургаа дахь нь аягатайгаа агуу их Евфрат мөрөнд асгасанд ус нь ширгэв. Ингэснээр нар мандах зүгээс ирэх хаадад зам бэлтгэгдэх юм. Лууны амнаас, араатны амнаас, хуурамч эш үзүүлэгчийн амнаас мэлхий шиг гурван бузар сүнс гарахыг би харав. Учир нь тэд бол тэмдгүүдийг үйлдэн, Төгс хүчит Бурханы агуу өдрийн дайнд хамтад нь цуглуулахаар бүх дэлхийн хаад дээр гарч очих чөтгөрүүдийн сүнснүүд юм. “Харагтун, Бн хулгайч шиг ирнэ. Сэрүүн байж, хувцасаа сахьдаг хүн ерөөлтэй еэ, Эс

тэгвэл, тэр хүн нүцгэн явж, ичгүүрийг нь хүмүүс харах вий,” Тэд хаадыг еврейгээр “Хармагедон” гэгддэг газарт цуглуулсв. Долоо дахь нь аягатайгаа агаарт асгав. Сүм дотроос сэнтийнээс

- Энэ дууслаа гэх чанга дуу гарав. Цахилгаан гялбаж, дуу гарч, аянга бууж, газар асар хүчтэй хөдлөв. Хүнийг дэлхий дээр байх болсноос хойш болж байгаагүй тийм хүчтэй, агуу хөдлөлт болов. Агуу хот гурван хэсэг болон хуваагдаж, үндэстнүүдийн хотууд нурав. Агуу их Вавилон Бурханы өмнө дурсагдсан учраас Бурхан Өөрийн догшин уур хилэнгийн дарсны аягыг түүнд өгөв. Арал бүр зугтаж, уулс олдсонгүй. Нэг талант жинтэй асар том мөндрүүд хүмүүсийн дээр тэйгэрээс буухад мөндрийн гамшгаас болж хүмүүс Бурханыг доромжлов. Учир нь үүний гамшиг үлэмж агуу байлаа.

Бурханы уур хилэнгийн долоон аяга

Энэ долоон уур хилэнгийн аяга нь долоон бүрээт гамшигтай ижил юм. Гэвч эдгээр гамшигууд илүү хатуу ширүүн юм. Эхний гамшиг нь дэлхий дээр, хоёр дахь нь далай дээр, гурав дахь нь гол мөрөн дээр, дөрөв дахь нь

тэнгэрт, тав дахь нь хүн төрөлхтөн дээр, зургаа дахь нь Евфрат болон цугларсан арми дээр, долоо дахь нь Бурханы уур хилэнгийн эсрэг цугларсан улс үндэстнүүд дээр бууна.

Бурханы шүүлт шударга

“Бурхан шударга тул Тэр та нарыг зовоогчдод зовлонгоор хариулж харин зовсон та нарт болон бидэнд хариуд нь тайвшралыг өгнө. Тэр үед Эзэн Есүс хүчирхэг тэнгэр элч нарынхаа хамт дүрэлзэх гал дотор тэнгэрээс илчлэгдэн, Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайн мэдээг дагадаггүй хүмүүсээс өшөө авах ажээ. Тэд мөнх сүйрлийн төлөөсийг төлж, Эзэний оршихуй болон Түүний хүчний алдраас сална. (2 Тесалоник1:6-9). Хэрэв Бурхан гэмтэй хүмүүсийг шүүхгүй бол Тэр шударга биш болно. Усны тэнгэр элчийн анхааруулснаар итгэгч болон эш үзүүлэгчдийн цус урссан тул тэд мөн цус уух ёстой. (Илчлэлт 16:6). Гэм нь шүүлттэй нийцдэг. Бурхан бүх зүйлийг Библийн дагуу хийж байсан. Фароан Еврей шинэ төрсөн эрэгтэй хүүхдүүдийг хаяж (алж) байсан бол, Бурхан Египетийн эхэнд төрсөн хүүхэд болон тэдний армийг алж Улаан тэнгис уруу хаясан. Хаман Мордехайг дүүжлэх гэж дүүжлүүр барьсан боловч өөрөө дүүжлэгдсэн. “Нүхийг ухагч хүн өөрөө түүн уруугаа унана. Өөдөө шидсэн чулуу өөрийн толгой дээр унана. (Сургаалт үгс 26:27).

Зөв шударгын төлөө зовж байгаа хүмүүсийн залбиралд Бурхан хариулдаг. “Эзэн дарлагдсан бүхний төлөө Зөв шударга үйлсийг болон шүүлтүүдийг үйлддэг. (Дуулал 103:6). Энэ шүүлт нь там уруу урьдаас төсөөлөгдсөн байна. Шатаж буй нар зовлон зүдгүүрийн шархыг шатаах болно. Тэд харанхуй доторх зовлон зүдгүүрийг тэсвэрлэсэн юм.

Хармагедонд цугласан нь

Гэмшихын оронд улс үндэстнүүд Бурханы эсрэг дайтахаар цуглах болно. Тэд муу ёрын сүнсээр удирдуулан Хармагедонд (Мегиддо уул) цугларах болно. Мегиддо гэдэг нь “алах, хядах, тастах.” гэсэн утгатай.

Мегиддо уул нь Иезрелл (Естриолан) Хөндий бөгөөд Хуучин гэрээний үед алдартай дайны талбар байсан. Палистины хойд хэсэгт байдаг энэ тал газар нь Дэлхийн хамгийн том тулаан болоход тохирсон газар. Долоо дахь аягатай гамшиг нь маш аймшигтай байгалийн гамшгийг авчирна. Газар хөдлөлт болон 100 фунт жинтэй мөндөр хот дээгүүр орох бөгөөд арал болон уулууд алга болно. Энэ үед итгэгч хүмүүс Бурханы уур хилэнгээс айх шаардлаггүй." Яагаад гэвэл Бурхан биднийг уур хилэнгийн төлөө бус, харин бидний Эзэн Христээр дамжуулан авралыг олж авахын төлөө томилсон юм. (1 Тесалоник 5:9).

Хүмүүс яагаад гэмшдэггүй вэ?



Илчлэлт ном дахин дахин бидэнд дэлхий дээр байгаа хүмүүс гэмшихгүй байгааг харуулж байна. Яагаад?

1.Тэд хатуу зүрхтэй. "Зүрх бол бүх зүйлээс хуурамч бөгөөд эдгэршгүй өвчтэй юм. Үүнийг хэн ойлгож чадах билээ? (Иеремиа 17:9).

2.Хүмүүс гэм нүгэлдээ дуртай байдаг. "Тэрхүү ялалт

ийм билээ. Гэрэл ертөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм. (Иохан 3:19).

3.Хүмүүс Бурханыг сонсохоос татгалздаг. “Тэд өөрсдийн зүрхийг цахиур мэт болгосон учраас тэд түмэн цэргийн Эзэн өөрийн сүнсээр эртний эш үзүүлэгчдээр дамжуулан илгээсэн хууль болон үгсийг сонсож чадаагүй. Иймд түмэн цэргийн Эзэнээс агуу уур хилэн ирсэн. (Зехариа7:12).

4.Хүмүүс Бурханд алдар магтаалыг өргөдөггүй”Яагаад гэвэл тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан хэмээн түүнийг алдаршуулсан ч үгүй, түүнд талархал өргөсөн ч үгүй. Харин тэд бодол санаандаа хоосорч , мунхаг зүрх сэтгэл нь харанхуй болжээ. (Ром1:21).

5.Хүмүүс зөв зүйлийг хүлээж авдаггүй. Та тэднийг хөнөөсөн, тэд сульдаагүй. Та тэднийг устгасан. Гэвч тэд зөв болохоос татгалзсан. Тэд нүүр царайгаа хаднаас ч хатуу болгож, гэмшихээс татгалзсан юм. (Иеремиа 5:3а). “Олон зэмлүүлэвч хүзүү нь хөшсөн хэвээр байгч хүн Нэг л өдөр эдгэшгүйгээр ойчих болно. (Сургаалт үгс 29:1).

Гэмшээгүй хүмүүст зориулсан Бурханы анхааруулга

“Би та нарыг дуудсан, харин та нар үл хэрэгссэн. Гараа сунгахад минь хэн чинь ч анхаарсангүй. Та нар бүх зөвлөгөөг минь үл ойшоон, зэмлэлийг минь эс хүссэн. Та нарын гамшиг сүйрэл дээр чинь би инээж, Айдас хүйдэст нэрвэгдэх цагт чинь би элэг доог хийнэ. Айдас хүйдэс шуурга мэт ирж, гамшиг хуй салхи мэт нөмөрч, Зовлон зүдгүүр, гай тотгор та нарт ирэхэд би тийн хандана. Тэр үед тэд намайг дуудах боловч би хариу эс өгнө. Тэд намайг хичээнгүйлэн хайх боловч эс олно. Яагаад гэвэл тэд мэдлэгийг үзэн ядаж, Эзэнээс эмээхүйг эс сонгов. Тэд миний зөвлөгөөг хүлээж авахгүй, Миний бүх зэмлэлийг хайхраагүй. Тийнхүү тэд өөрсдийн үйлсийн үр жимсийг идэж, Өөрсдийн сэдсэн зүйлдээ сэтгэл ханамжтай байх болно. (Сургаалт үгс 1:24-31).

Есүс түүн дээр ирсэн хүн бүрийг хүлээн авдаг

Бидний зүрх сэтгэл хатуу, зөрүүд, мөн гэм нүглийн боол байхад л Бурханы Ариун Сүнс бидэнд зөөлөн хайраар хандах нь хичнээн гайхамшигтай вэ! Хэрэв бид гэмээ гэмшин Түүнийг сонсож Түүн уруу очвол Тэр биднийг хүлээн авч хайрын гараа сунгах болно. Ямар гайхалтай Бурханы аврал вэ! Хэзээ ч Ариун Сүнсийг бүү эсэргүүц. Гэмшихээ бүү зогсоо. Маргааш таны зүрх илүү зөөлөн болохыг хэн мэдэх билээ? Зүрхнийхээ хатуурлыг эсэргүүц. “Харагтун, одоо бол” Авралын өдөр” байна. (2Коринт 6:26). Хэрэв таны Сүнс зовж байгааг мэдэвчлэл Есүс түүн дээр ирсэн хүнийг хүлээж авдгийг санагтун. “Эцэгийн Надад өгдөг бүхэн над уруу ирнэ. Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй. (Иохан 6:37).

ХИЧЭЭЛ 30. ВАВИЛОН УСТГАГДСАН НЬ

Илчлэлт 17:1-18

“Долоон аягатай долоон тэнгэр элчийн нэг нь ирж надтай ярилцан

- Нааш ир. Их усны дээр суух агуу янхныг шүүх шүүлтийг би чамд харуулъя. Дэлхийн хаад тэр эмтэй завхайрлыг үйлдэн, дэлхий дээр нутаглагсад түүний завхайрлын дарснаас ууж согтуурцаав гэв. Тэнгэр элч намайг Сүнс дотор цөлд авчрав. Би долоон толгойтой, арван эвэртэй, доромжлолын нэрсээр дүүрэн час улаан араатан дээр суух нэгэн эмэгтэйг харлаа. Тэр эмэгтэй нил ягаан болон час улаан өнгийн хувцастай

бөгөөд алт, үнэт чулууд, сувдаар гоёсон байв. Тэр жигшүүрт юмс болон өөрийн завхайрлын бузар юмсаар дүүрэн алтан хундагыг гаргаа барьжээ. Түүний духан дээр “Дэлхийн янхнуудын ба жигшүүрт юмсын эх агуу их Вавилон” гэсэн нууц нэр бичигдсэн байв. Тэр эм ариун хүмүүсийн цуснаас болон Есүсийг гэрчлэгчдийн цуснаас уугаад согтохыг би харав. Би түүнийг хараад, ихэд гайхлаа. Өнөөх тэнгэр элч надад

-Чи юунд гайхна вэ? Энэ эмэгтэйн болон түүнийг авч яваа долоон толгойтой,

арван эвэртэй араатны нууцыг би чамд хэлье. Чиний харсан нь араатан байсан боловч одоо байхгүй. Тэр ёроолгүй гүнээс гарч ирэн, сүйрэл уруу явах гэж байна. Ертөнцийн сууриас хойш амийн номд нэрс нь бичигдээгүй дэлхий дээр нутаглагсад тэр араатныг хараад гайхах болно. Тэр байсан боловч одоо байхгүй., дараа ирнэ. Энд мэргэн ухаан бүхий оюун санаа байна. Долоон толгой бол тэр эмэгтэйн сууж байгаа долоон уул бөгөөд долоон хаан юм. Тав нь унасан бөгөөд нэг нь байгаа. Нөгөө нь хараахан ирээгүй аж. Тэр ирэхдээ хоромхон зуур саатах ёстой. Байсан, одоо байхгүй өнөөх араатан бол найм дахь нь юм. Тэр бол өнөөх долоогийн нэг нь бөгөөд сүйрэл уруу явна. Чиний харсан арван эвэр бол хаанчлалыг хараахан хүлээн аваагүй байгаа арван хаан юм. Гэвч тэд араатантай хамт нэг цагийн турш хаад мэт эрх мэдлийг хүлээж

авна. Тэд нэг зорилготой бөгөөд өөрсдийн хүч, эрх мэдлийг араатанд өгнө. Тэд Хурганы эсрэг дайн хийх бөгөөд Хурга тэднийг ялах болно. Учир нь Тэр бол Эздийн Эзэн, Хаадын Хаан билээ. Түүнтэй хамт байгчид нь дуудагдсан, сонгогдсон, итгэмжит хүмүүс юм гэв. Тэр надад

- Янхан эмийн сууж байгаа чиний харсан ус бол ард түмэн, хурсан олон, үндэстнүүд ба хэлтнүүд юм. Чиний харсан арван эвэр ба араатан нь янхныг үзэн ядаж, түүнийг хоосруулж, нүцгэлж, махан биеийг нь идээд, түүнийг галаар шатаах болно. Учир нь Бурханы үгс биелэгдэх хүртэл нийтлэг зорилготой байснаар болон араатанд тэдний хаанчлалыг өгснөөр Бурхан өөрийнхөө зорилгыг биелүүлэхийн тулд тэдний зүрхэнд үүнийг хийсэн юм. Чиний харсан тэр эм бол дэлхийн хаадыг хаанчлах агуу хот мөн гэв.

Вавилоны үүсэл- Хуурамч шашин

Бурхан үнэн чуулган болох сүйт бүсгүйг Есүст бэлдэж байна. Гэвч бас хуурамч чуулган байдаг бөгөөд үүнийг янхан эм эсвэл биеэ үнэлэгч гэж тодорхойлдог. Биеэ үнэлэгчийн духан дээр үнэт эдлэлийн нэр бичигдсэн

байдаг.Шашинлаг Вавилон Бабелын цамхагаас эхэлдэг.(Эхлэл 11:1-9). Ноагийн ач хүү Нимрод хаант улсаа тэнд байгуулсан. .(Эхлэл 10:8-10). Анх тэнд дуулгаваргүй хүмүүс Бурханы эсрэг тэмцсэн юм. Энэ түүхийг авч үзвэл Нимрод хорон санаат Семеримус гэдэг хүүхэнтэй суудаг. Тэр өөрийн хүү Таммузыг Бурханы амласан Аврагч болгохыг оролдож байсан. Энэ муу ёрын сүнслэг систем дэлхий дахинд тархсан бөгөөд ээж хүүгийн итгэлээр суурьлагдсан байдаг. Тэд газар бүр өөр нэртэй байдаг. Астрерод болон Таммуз (Феоник), Афродить болон Эрос (Грек), Венус болон Купит (Ром).

Энэ ээж хүүгийн сургаалаар Семеримус өөрөө Бурханд хүрэх зам гэж сургадаг байсан. Тэр өөрийгөө Тэнгэрийн Хатан гэж дуудсан. Түүний хүү Таммуз ан хийж байхдаа бодон гахайд алуулж 40 хоногийн дараа дахин амилсан гэж хэлдэг. Үүний улмаас шашинлаг чуулган түүнийг дахин амилсан хэмээн 40 хоногийн турш мацаг барин баяр болгон тэмдэглэдэг. Энэ мацаг барилтын дараа Иштар хэмээх шашны баяр болдог. Өнгөтэй өндөгүүдийг солилцож иддэг байжээ. Т үсгээр тэмдэглэсэн халуун бялууг барьж Таммузыг санан иддэг байжээ. Бурхан Абрахамд хуурамч бурхадаас хол байлгахгаар болон өөрийг нь амласан газар аваачихаар дуудсан. Бурхан өөрт нь дуулгавартай улс үндэстнийг байгуулахыг хүссэн. Гэвч Израилийн хаан Ахабын эхнэр Иезебелийн нөлөөгөөр Израиль үндэстэн эргээд Баалд мөргөж эхэлсэн. (Хаадын дээд 16:29-33).Он жилүүдийн дараа Бурхан Эш үзүүлэгч Езекиелд Иерусалимийн сүмд жигшмээр зүйл болж байгаа илчлэлтийг өгсөн. "Дараа нь Тэр намайг Эзэний өргөөний хойшоо харсан хаалганы үүд уруу авчирлаа. Харагтун, Эмэгтэйчүүд Таммузын төлөө уйлан тэнд сууцгааж байв. (Изекиел 8:14). Бурхан Израилийг эш үзүүлэгч Иеремиагаар дамжуулан хуурамч шашинд мөргөхийг оролдож байна хэмээн зэмэлсэн. "Эмэгтэйчүүд нь тэнгэрийн хатанд боов хийхийн тулд зуурсан гурил нухдаг бөгөөд Намайг уурлуулахын тулд ондоо бурхдад ундаан

өргөлийг асгадаг. (Иеремиа 7:186). Тэд тангараг хүртэл өргөсөн “Тэнгэрийн хатанд тахилууд шатааж, түүнд ундаан өргөлүүдийг цутгахаар тангаргалсан тангаргуудаа бид заавал биелүүлнэ,” гээд та нар өөрсдийн амаар ярьж, өөрсдийнхөө гараар биелүүлсэн юм. Явж өөрсдийн тангаргуудаа баталж, тангаргуудаа заавал биелүүл”

(Иеремиа 44:256). Жинхэнэ итгэгч нар Бурханы үгийг гуйвуулахаас сонор сэрэмжтэй байх хэрэгтэй. Паул Тимотод ийм зүйл болохыг хэлсэн. “Учир нь хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болох цаг ирнэ. Тэд өөрсдийн хүслийн дагуу өөрсдөдөө багш нарыг бөөгнөрүүлэх бөгөөд тэдний чих үнэнээс эргэж, үлгэр домгуудад хандах болно. (2 Тимот 4:3а-4). Эдгээр чуулганууд дэлхийн шашин бүрийг төлөөлдөг. Илчлэлт номны 17 бүлэгт хуурамч чуулганууд Христийг эсэргүүцэгчдийг гэгээрүүлдэг. Эхэндээ хуурамч чуулган хөгжин цэцэглэнэ. Гэвч Христийг эсэргүүцэгч болон арван хаан урвагч чуулганыг байгуулах бөгөөд түүнийг Эзэн устгах болно.

ХИЧЭЭЛ 31. АРИЛЖАА ХУДАЛДААНЫ ВАВИЛОН ГАШУУДСАН НЬ

Илчлэлт 18:1-24

“Үүний дараа агуу их эрх мэдэлтэй тэнгэр элч тэнгэрээс буухыг би харав. Дэлхий Түүний цог жавхлангаар гэрэлтэв. Тэр хучит дуугаар хашхиран

-Агуу Вавилон нурлаа, нурлаа. Тэрээр чөтгөрүүдийн нугагладаг газар, бузар сүнс бүрийн орогнох газар, бүх бузар жигшүүрт шувуудын үүр болсон байна. Учир нь түүний завхайрлын тачаалын дарснаас бүх үндэстэн ууж

согтоцгоожээ. Дэлхийн хаад түүнтэй завхайрч, дэлхийн худалдаачид түүний хээнцэр тансагийнх нь хүчээр баяжицгаав гэв. Би тэнгэрээс өөр нэг дуу гарахыг сонсов.

- Миний ард түмэн, та нар тэр эмийн нүглүүдэд нь хамтрагч болохгүйн тулд болон түүний гамшгийг хүлээж авахгүйн тулд түүнээс гарагтун. Яагаад гэвэл түүний нүглүүд нь тэнгэрт тулгал овоорсон бөгөөд Бурхан

түүний гэм бурууг санасан. Түүний төлсөнчлөн түүнд буцааж төл. Үйлсийнх нь дагуу түүнд хоёр дахин их буцааж өг. Түүний найруулж байсан аяганд нь хоёр дахин их найруулж өг. Тэр өөрийгөө хичнээн их алдаршуулж, хээнцэр тансаг байсных нь хэмжээгээр түүнд тарчлал уй гашууг өг. Учир нь тэр зүрхэндээ "Би хатан хаан мэт суудаг. Би бэлэвсэн эм биш бөгөөд уй гашууг хэзээ ч үзэхгүй" гэж хэлдэг. Тиймээс нэг өдөр түүний гамшиг болох үхэл, гашуудал, өлсгөлөн нь ирнэ. Түүнийг галаар шатаана. Яагаад гэвэл түүнийг шүүгч Эзэн Бурхан хүчтэй. Түүнтэй завхайран, хээнцэр тансаг амьдарсан дэлхийн хаад түүнийг шатахад гарах утааг хараад уйлж, гашуудна. Тэд түүний тарчлалаас айсандаа зайдуу зогсоод

-Агуу хот, хүчит хот Вавилон золгүй еэ, золгүй еэ. Цагийн дотор шийтгэл чинь ирлээ гэцгээнэ. Дэлхийн худалдаачид уйлж, түүний төлөө гашуудна. Учир нь түүний ачаа барааг дахиж хэн ч худалдаж авахгүй. Ачаа бараа нь гэвэл алт, мөнгө, эрдэнэсийн чулууд, сувд,

нарийн маалинга, нил ягаан даавуу, торго, часулаан даавуу, анхилуун үнэртэй



төрөл бүрийн мод, зааны ясан эдлэлүүд, хамгийн үнэтэй модоор ба зэс, төмөр, гантгаар хийсэн янз бүрийн эдлэлүүд, шанц, халуун ногоо, утлага, анхилуун үнэртэн, гүгэл, дарс, чидуны тос, нарийн гурил, буудай, үхэр, хонь, морьд, тэрэг, боол ба хүний амь байв. Сэтгэл чинь хүсэн тэмүүлдэг үр жимс чамайг орхисон. Хээнцэр, тансаг байсан бүх юмс чамайг орхин одсон. Тэдгээр нь дахиж олдохгүй. Түүнээс баяжсан эдгээр зүйлийн худалдаачид, түүний тарчлалаас айсандаа зайдуу зогсоод уйлж, гашуудан

- Нарийн маалинга, нил ягаан, час улаан хувцас өмссөн, алт болон үнэт чулуунууд, сувдаар гоёсон агуу хот золгүй еэ, Ийм үлэмж их баялаг ганцхан цагийн дотор сүйтгэгдэв гэцгээнэ. Усан онгоцны ахмад бүр, зорчигч бүр,

тэнгисээр амь зуулгаа олдог
бүхэн зайдуу зогсоод галынх
нь угааг харангаа,

Агуу их хоттой адил ямар
хот байна вэ? гэж хашхирч
байлаа. Тэд толгой дээрээ
шороо цацаж, уйлж,
гашуудаж, хашхиралдан

Агуу их хот золгүй еэ,
золгүй еэ, Тэнгист усан
онгоцтой бүхэн түүний
баялгаар баяжсан билээ. Хот
ганц цагийн дотор сүйрлээ.
Өө, тэнгэр ээ, ариун хүмүүс
ээ, элч нар аа, эш үзүүлэгчид
ээ, тэр хотын улмаас
баярлагтун. Учир нь Бурхан
та нарын төлөө түүнийг
шийтгэв гэв. Хүчит нэгэн
тэнгэрийн элч тээрмийн саар
том чулуу шиг чулууг авч
тэнгис уруу чулуудангаа

Агуу хот Вавилон ийнхүү
хүчээр доош хаягдана. Тэгээд
хойшид олдохгүй. Босоо
ятгачид, хөгжимчид,
бишгүүрчид, бүрээчдийн
эгшиг аялгуу цаашид чиний
дотор сонсогдохгүй. Алив
урлалыг урласан ямар ч
дархан чиний дотор
олдохгүй. Тээрмийн чимээ
чиний дотор цаашид
гэрэлтэхгүй. Сүйт залуу, сүйт
бүсгүйн дуу чиний дотор
цаашид сонсогдохгүй. Яагаад
гэвэл худалдаачид чинь
дэлхийн агуу хүмүүс байсан.
Яагаад гэвэл ид шидэнд чинь
бүх үндэстэн мэхлэгдсэн юм.
Эш үзүүлэгчид, ариун хүмүүс
болон дэлхий дээр алагдсан
бүх хүмүүсийн цус чиний
дотроос олдсон юм гэлээ.

Дэлхий Вавилоны төлөө гашуудсан нь

Арилжаа хийдэгийн хувьд “Нууцлаг Вавилоны” төлөө
дэлхий гашуудсан. Учир нь дэлхий түүний ачаар баяжсан
юм. Гэвч дэлхий гашуудаж байхад харин тэнгэрийн улс
баяр хөөртэй байв. Зовогсдийн цусан өшөөг авав.” Өшөө
авалт нь Минийх, Би буцааж төлнө гэж Эзэн айлдав гэж
бичигджээ. (Ром 12:19б).

Итгэгч хүмүүс дэлхийгээс тусгаарлагдана.

Итгэгч хүмүүс гэмтэй дэлхийн нэг хэсэг байж болохгүй
эс бөгөөс тэд нарын эсрэг ирэх Бурханы шүүлтийн өмнө
тэд зовох болно. Вавилоны дэлхийн энэ тогтолцооноос
зугтах хэд хэдэн зүйл энд байна. Тэр эмэгтэй өөрийгөө
алдаршуулсан, тансаг амьдралаар амьдран,

Бурхангүйгээр өөрийгөө элбэг дэлбэг байлгаж, хүмүүсийг мөлжин буруу аргаар мөнгө олсон. “Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай гэж Эзэн айлддаг. “Бүзар юманд бүү хүр. Би та нарыг хүлээн авч, Та нарын Эцэг чинь болно. Та нар ч Миний хөвгүүд, охид болно” гэж Төгс хүчит Эзэн айлддаг” гэжээ. (2 Коринт 6:17б-18а).

“Харин ариун хүмүүст үл нийцэх садар самуун, аливаа бузар булай, шунал нь та нарын дунд бүү дурсагдаг. Бузар булай болон мунхаг яриа, эсвэл тоглоом тохуу нь зохимжгүй. Харин оронд нь талархлаа өргө. Садар самуун, бузар булайг, шүтээнийг шүтэгч, шунахай ямар ч хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар ойлго. Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Яагаад гэвэл эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. Иймд тэдний хамсаатан байж болохгүй. Учир нь та нар урьд нь харанхуй байсан. Харин одоо та нар Эзэн дотор гэрэл ажээ. Гэрлийн хүүхдүүд шиг яв. Учир нь алив сайн, зөвт байдал ба үнэн дотор гэрлийн үр жимс байна. Ингэхдээ Эзэнд таалагдах юманд суралц. (Ефес 5:3-10). “Бусдын нүгэлд ч бүү оролц. Өөрийгөө цэвэр байлга. (1 Тимот 5:22).

ХИЧЭЭЛ 32. ЭЗЭН БУРХАНЫ ХААНЧЛАЛ

Илчлэлт 19:1-21

“Үүний дараа хурсан олон түмний дуу мэт чимээ тэнгэрт гарахыг би сонсов. Тэд

Халлелуяа, Аврал, алдар, хүч нь бидний Бурханд байдаг. Яагаад гэвэл Түүний шүүлт үнэн бөгөөд зөвт. Учир нь завхайрлаараа дэлхийг ялзруулж байсан агуу их янхныг Тэр шийтгэв. Тэр Өөрийн боолуудын

цусны өшөөг түүнээс авсан гэлээ. Хоёр дахь удаагаа тэд

-Халлелуяа, Түүний утаа нь үеийн үед суунаглана гэв. Хорин дөрвөн ахлагч болон хорин дөрвөн амьтан унаж, сэнтийнд залрагч Бурханд мөргөж Амен, Халлелуяа, гэв. Сэнтийнээс дуу гарч

- Түүний бүх боолууд аа, Түүнээс эмээгч их, бага хүмүүс та нар бидний

Бурханд магтаалыг өргө гэв. Хурсан олон түмний дуу хоолой шиг, их усны шуугиан шиг, хүчит аянгын нүргээн шиг дуу гарахыг би сонсов.

- Халлелуяа, Төгс Хүчит Эзэн “бидний” Бурхан хаанчилдаг. Баярлан хөөрч, баясан цэнгэж, Түүнд алдрыг нь өргөцгөөе. Учир нь Хурганы хурим болж, Түүний сүйт бүсгүй өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэрхэн нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь тэрхүү нарийн маалинга бол ариун хүмүүсийн зөвт үйлс юм. Тэр надад

“Хурганы хуримын зоогонд уригдасад ерөөлтэй еэ” гэж бичигтүн” гээд

Эдгээр нь Бурханы үнэн үгс мөн гэлээ. Намайг тэнгэр элчид мөргөхөөр хөлд нь унасанд тэр надад

Ингэсний хэрэггүй. Би бол чиний болон Есүсний гэрчлэлтэй ах дүүсийн чинь хамтран зүтгэгч боол билээ. Бурханд мөргө. Учир нь Есүсний гэрчлэл бол эш үзүүлэгчийн сүнс мөн гэв. Би тэнгэр нээгдсэнийг харлаа. Харагтун, Цагаан зүсмийн морь болон түүнийг унаж яваа Нэгэн нь “Итгэмжит бөгөөд үнэн” гэгддэг. Тэр

зөвт байдал дотор шүүдэг, дайтдаг. Түүний мэлмий нь галын дөл шиг, тэргүүн дээр нь олон титэм байна. Өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй нэр дээр нь бичээстэй байна. Тэр цусанд дүрэгдсэн дээл өмсжээ. Түүний нэрийг “Бурханы Үг” гэдэг ажээ. Цагаан өнгөтэй цэвэрхэн, нарийн маалинган хувцас өмссөн, тэнгэр дэх дайчид цагаан зүсмийн морьд унан түүнийг дагаж байв. Түүний амнаас нь хурц сэлэм цухуйх агаад түүгээр Тэр үндэстнүүдийг устгах юм. Тэр үндэстнүүдийг төмөр таягаар захирах болно. Тэрээр Төгс Хүчит Бурханы догшин уур хилэнгийн дарсан шахуургыг шахна. Тэр дээл болон гуян дээрээ “Хаадын Хаан,” ээдийн Ээи” гэж бичсэн нэртэй ажээ. Наран дээр нэгэн тэнгэр элчийн зогсож байхыг би харав. Тэр чанга дуугаар хашхиран тэнгэрийн дундуур ннсэж буй бүх шувуудад

Ирцгээ. Бурханы их зоогон дээр чуулагтун. Ингэснээр та нар хаадын мах, хүчит эрсийн мах, морьд болоод морьтонгуудын махыг эрх чөлөөт хүмүүс ба боолчуудын, их бага бүх

хүмүүсийн махыг идэх юм хэмээн хэлэв. Морь унасан Түүний эсрэг болон дайчдынх нь эсрэг дайтахаар цугласан араатан болоод газрын хаад, тэдний дайчдыг би харав. Өнөөх араатан болоод түүнтэй хамт эш үзүүлэгч баригдав. Энэ хуурамч эш үзүүлэгч нь араатны өмнө тэмдгүүдийг

үйлдсэнээрээ араатны тэмдгийг хүлээн авсан хүмүүс болон араатны хөрөгт мөргөсөн хүмүүсийг мэхэлсэн юм. Тэр хоёрыг амьдаар нь шатаж буй хүхэртэй галт нуурт хаяв. Бусад нь морь унасан Нэгэний амнаас цухуйх сэлмэнд алагдсан бөгөөд бүх шувууд тэдний маханд цадав.

Тэнгэр Бурханд талархав.

Та тэнгэрт хэдэн удаа Бурханд талархсаныг ажигласан уу? "Халлелуяа" гэдэг нь Еврей үг бөгөөд "Еховад таларх" (Эзэнд таларх) гэсэн утгатай. Бид тэнгэрээс илүү талархлыг Эзэнд өргөвөл бидний амьдрал илүү сайхан байна. "Эзэн, миний ам Таны магтаалыг тунхаглахын тулд Миний уруулыг нээгээч. (Дуулал 51:15).

Хийх зүйлс

Хоосон зайг бөглөж яагаад тэнгэрт баяр хөөр болсоныг олж мэд:

1., бидний Бурханд байдаг. (Ишлэл1).
2. Түүний шүүлт бөгөөд(2)
3. Завхайрлаараа дэлхийг ялзруулж байсан агуу их Тэр (2).
4. Тэр өөрийн цусны түүнээс авсан гэлээ. (2).
5. "Халлелуяа" төгс хүчит Эзэн!(6).
6. Хурганы болох гэж байна. (7).
7. Түүний сүйт бүсгүй өөрийгөө(7).

Хурганы хурим

Баяр хөөртэй үйл явдал нь Хурганы хурим! Есүс Христ бол Хурга. Бүх жинхэнэ итгэгч нар Түүний сүйт бүсгүй.

Паул хэлэхдээ: “Учир нь би та нарыг ариун онгон охин мэт Христийн өмнө аваачихаар ганц нөхөртэй сүй тавиулсан. (2Коринт 11: 26).

Сүйт бүсгүй бэлэн болов! Христийн сүйт бүсгүй болох бид нар бэлэн байгаагаа хэрхэн мэдэх вэ? Сүйт бүсгүй итгэгч хүмүүсийн зөвт байдлын цэвэрхэн нарийн маалингаар хувцасласан. Бид нарын өөрсдийн зөвт байдал энд хангалтгүй юм. Христ загалмай дээр үхсэнээр, Тэр бидний ариусгаж Өөрийнхөөрөө зөвтгөсөн юм. “Тэр чуулганыг үгээр дамжуулан усанд угааж цэвэрлэн, ариусгаад түүнийг ямар ч толбогүй, ямар ч үрчлээсгүй бөгөөд тиймэрхүү ямар ч зүйлгүй, харин ариун, гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө алдарт чуулган болгох гэсэн ажээ. (Ефес 5:256-27). Сүйт бүсгүйн өмссөн хувцас нь авралын бэлэг юм. Та Христийн авралыг авсан уу? Есүс хүн нэг бүрийг Христийн хуримын зөвт хувцсыг авах хэрэгтэйг дүрслэн хэлсэн. Бид өөрийн хувцсыг өмсөж болохгүй. “ Бид бүгдээрээ бузар мэт болсон бөгөөд бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт болсон. (Исаиа 64:6а). Есүс хэлсэн нь “Тэнгэрийн хаанчлалыг хүүгийнхээ хуримын найрыг хийсэн хаантай зүйрлэж болно.

Харин хаан зоогийн зочдыг харахаар орж ирээд хуримын хувцас өмсөөгүй нэгэн хүнийг хараад, түүнд “Анд минь, чи хуримын хувцасгүйгээр хэрхэн энд орж ирэв?” гэхэд тэр үг дуугүй байв. Тэгтэл хаан зарц нартаа” түүний гар, хөлийг хүлээд гаднах харанхуйд хая. Тэнд тэр уйлж шүдээ хавирах болно” гэж хэллээ.

(Матай 22:2 ,11-13). Бид аврагдсаны дараа, Бидний дотор байгаа Түүний сүнс зөвт үйлс дотор байх хүч чадлыг бидэнд өгөх болно. Бид өөрсдийн хүчээр зөвт байдал дотор явах боломжгүй юм. “Хуулиас гардаг өөрийнхөө зөвт байдалтай биш, Харин Христэд итгэх итгэлээр ирдэг, итгэлийн үндсэн дээр Бурханаас ирдэг зөвт байдалтай Түүний дотор би олдохын тулд юм. (Филиппой 3:9).

Заримдаа Эзэн Есүс биднийг томоожуулах (сахилгажуулах) хэрэгтэй болдог. Ингэснээр бид улам

Түүн шиг болох юм. “Бүх сахилга нь тухайн үедээ баяр хөөртэй бус, харин уй гашуутай мэт санагдавч дараа нь түүгээр сургагдсан хүмүүст зөв байдлын амар амгалан бүхий үр жимсийг төрүүлж өгдөг. (Еврей 12:11).

Есүс дайтахаар ирнэ.

Сударт Эзэнг “Дайтагч хүн” гэсэн. “Эзэн дайчин мэт урагшилж, дайнч мэт зүтгэн босож, дуугаа өндөрлөн дайнд уухайлж, Өөрийн дайсныг дарна. (Исаиа 42:13). Ямар айдас төрүүлмээр зүйлийг бид харж байна вэ! Хүчирхэг гайхамшигтай цагаан морьтой Христ Өөрийн армия удирдан тэнгэрээс дайтахаар ирнэ! “Тэнгэрүүдийг баясгаж, газар дэлхийг баярлуул. Далай болон түүний доторх бүх юмсыг нүргэлүүл. Учир нь тэр ирж байна. Учир нь Тэрээр газар дэлхийг шүүхээр ирж байна. Тэрээр ертөнцийг зөв шударгаар, Хүмүүсийг Өөрийн зөв байдлаар шүүнэ. (Дуулал 96:11,13).

Алдаршуулагдсан Христ Өөрийн хүмүүсийн хамт ирнэ. “Харагтун. Эзэн мянга мянган ариун нэгэнтэйгээ ирэв. Энэ бүгдийн дээр шүүх ажиллагаа явуулж, бүх бурханлаг бусчуудыг бурханлаг бус замаар үйлдсэн бүх бурханлаг бус зүйлсээр нь болон бурханлаг бус нүгэлтнүүдийг Түүний эсрэг ярьсан бүх хатуу үгсээр нь буруутгахын тулд юм. (Иуда 14б,15).

Бүх үндэстнүүд Бурханы эсрэг Хармегедонд цуглах бөгөөд Христ Өөрийн дайснуудаа устгах болно. “Тэр өдөр Би Иерусалимын эсрэг ирэх бүх үндэстнүүдийг устгахыг эрмэлзэнэ. (Зехариа 12:9). “Гагцхүү үнэн зөвөөр ядуусыг шүүж, газрын зовогсдод зориулан шударга шийдвэр гаргана. Тэрээр амныхаа саваагаар газрыг дэлдэж, уруулынхаа амьсгалаар хилэнцтэнийг ална. (Исаиа 11:4). “Таны дээл яагаад улаан, Таны хувцас яагаад усан үзмийн шахуурга гишгэгч мэт байна вэ?” Би мөн уур хилэнгээр тэднийг гишгэж, уурлан тэднийг дэвсэлсэн. Тэдний шүүс нь Миний дээл уруу үсэрч, Би Өөрийн бүх хувцсаа бузарласан билээ. (Исаиа 63:2-3б).

Христийг эсэргүүцэгч болон хуурамч эш үзүүлэгч баригдсан нь

Араатан (Христийг эсэргүүцэгч) болон хуурамч эш үзүүлэгч нар галт нуурт хаягдах болно. Хожим нь Сатан мөн галт нуурт хаягдах болно. (Илчлэлт20:10). Үхэл шүүгдсэний дараа үхэл ба Үхэгсдийн орон(Там) галт нуурт хаягдах болно (Илчлэлт20:14). Амийн номонд бичигдээгүй хэн боловч галт нуурт хаягдах болно. (Сүнслэг амьдралыг хүлээж аваагүй гэмээ гэмшээгүй болон Есүсийг зүрх сэтгэлдээ байлгаагүй хүмүүс). (Илчлэлт20:15). Та Бурханы авралын бэлгийг бүү хойшлуу! Хэрэв та Есүсийг хүлээн авч Бурханы хүүхэд болсон бол баярлагтун! "Харин нэрс чинь тэнгэрт бичигдсэн гэдэгт баялагтун гэв. (Лук 10:206)

ХИЧЭЭЛ 33. ИТГЭГЧ НАР ХРИСТИЙН ХАМТ ХААНЧЛАХ БОЛНО.

Илчлэлт 20:1-10

"Гартаа ёроолгүй гүний түлхүүр, асар том гинжтэй тэнгэр элч тэнгэрээс бууж ирэхийг бн харав. Тэрээр диавол ба Сатан болох эртний могой буюу лууг бариад, түүнийг хүлж, мянган жилийн турш ёроолгүй гүнд хаяжээ. Тэгээд мянган жилийг нь дуустал үндэстнүүдийг цаашид мэхлүүлэхгүйн тулд түүнийг түгжээд лацдав. Үүний дараа тэр ахархан хугацаанд суллагдах ёстой аж. Би сэнтийнүүдийг харав. Тэд дээр нь зарларчээ. Тэдэнд шүүх эрх өгөгдсөн байлаа. Мөн

Есүсийн гэрчлэл болон Бурханы үгээс болж цаазлуулсан хүмүүсийн болон араатанд ба түүний хөрөгт мөргөөгүй дух хийгээд гар дээрээ араатны тэмдгийг хүлээн аваагүй хүмүүсийн сүнснүүдийг би харав. Тэд амилаад Христтэй хамт мянган жилийн турш хаанчилжээ. Үхэгсдээс үлдсэн нь мянган жилийн турш амилсангүй. Энэ бол анхны амилалт юм. Анхны амилалтанд багтсан хүн ерөөлтэй агаад ариун юм. Хоёр дахь үхэл тэднийг захирах ямар ч хүчгүй ажээ.

Харин тэд Бурханы ба Христийн тахилч нар болцгоож, Түүнтэй хамт мянган жилийн турш хаанчлах болно. Мянган жил төгсөх үед Сатан шоронгоосоо суллагдан, дэлхийн дөрвөн өнцөгт буй үндэстнүүдийг, Гог болон Магогийг мэхлэн, тэднийг дайнд хамгад нь цуглуулахын тулд гарч ирнэ. Тэдний тоо

тэнгисийн эргийн элс шиг аж. Тэд газрын энгээр нэг тарж, ариун хүмүүсийн хуаран, хайрлагдсан хотыг бүсэлжээ. Тэнгэрээс гал бууж тэднийг залгив. Тэднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа. Тэнд ч мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байгаа аж. Тэд өдөр шөнөгүй үеийн үед тарчилна.

Эхний амилалт

Есүс хоёр амилалтын тухай ярьсан. “Үүнд бүү гайхагтун. Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон, гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлсийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ. (Иохан 5:28-29). Эш үзүүлэгч Даниел хоёр амилалтын тухай бичсэн. “Газрын шороонд бузарлагдсан нойрсогчдоос олон нь сэргэж, нэг хэсэг нь мөнх амь уруу, харин нөгөө хэсэг нь ичгүүр болон мөнхийн жигшил уруу явна. (Даниел 12:2).



Эхний амилалтанд бүх итгэгч нар үхлээс босно. “Учир нь бүрээ дуугарч, үхэгсэд үл муудах уруу амилуулагдаж, бид ч өөрчлөгдөнө. (1Коринт 15:526).

Христ Өөрийн хүмүүсийн хамт хаанчдах болно

Аврагдсан хүмүүс Христтэй хамт хаанчлана. Илчлэлт номны 20-р бүлэгт 1000 жил хаанчлана гэжээ. Илчлэлт номонд гардаг “миллиеанум” гэдэг нь Латинаар “милле” гэсэн үг бөгөөд “мянга” гэсэн утгатай. Итгэгч хүмүүс энэ

хэсгийг өөр өөрөөр орчуулдаг. Мянган жил гэдгийг үгчлэх шаардлаггүй гэж үздэг хүмүүс амиллиеанист гэж дууддаг. ("а" гэдэг нь үгүй гэсэн утгатай).

Тэд Христ загалмай дээр ялах үед Сатан хүлэгдсэн гэж үздэг бөгөөд энэ мянган жил одоо Христ сүнсээр итгэгч нарыг удирдаж байгаа билэг тэмдэг болж байна гэж үздэг. Зарим итгэгч нар Христ Сатаныг эцсийн удаа ялсны үр дүнд Христтэй хамт мянган жил хаанчлана гэж итгэдэг. Эдгээр итгэгч нарыг постмиллиеанист гэж дууддаг. (пост гэдэг нь дараа гэсэн утгатай). Энэ хэсгийг үгчлэн ойлгодог итгэгч нар Христ иргэн ирээд, Тэр амилсан итгэгч нарын хамт Сатаныг хүлэгдсэн байх үед мянган жил ноёлох болно. Тэгээд Сатан суллагдаад эцсийн удаа улс үндэстнүүдийг мэхлэх болно. Хүмүүс үхсэний дараа (гэмээсээ болж үхсэн хүмүүс) амилж шүүгдэх болно. Эдгээр итгэгч нар мянган жилээс өмнө Христ ирнэ гэж үздэг ба эдгээр хүмүүсийг премиллеанист гэж дууддаг. (пре гэдэг үг нь өмнө гэсэн утгатай). Итгэгч хүн бүр өөрийн үзэл бодлоо бусад итгэгч хүмүүстэй хүндэтгэлтэй даруухнаар хуваалцах хэрэгтэй. Юу чухал вэ гэвэл бид нар Христийг иргэн ирэхэд өөрсдөө бэлэн байгаад зогсохгүй бусдад анхааруулах хэрэгтэй. Бүх Библид итгэдэг итгэгч нар Есүс дахин ирж шинэ тэнгэр шинэ газарт хаанчлана гэдэгтэй санал нийлдэг. Бурханд талархъя!

Сатаны сүйрэл нь гарцаагүй юм.

Анх Сатан тэнгэрт гайхамшигтай байсан. Түүний бардамнал түүнийг унагасан. "Аяа, Үүрийн хүү, гялбаат цолмон. Чи яаж тэнгэрээс унав аа? Үндэстнүүдийг дордуулагч чи газарт хаягдлаа. Учир нь чи зүрхэндээ" Би тэнгэр уруу гарна. Би Бурханы оддын дээр сэнтийгээ босгоно. Би умардын хамгийн чанадад чуулганы уулан дээр заларна. Би үүлсийн орой дээр гарна. Би Өөрийгөө Хамгийн Дээд нэгэн болгоно" гэсэн. Гэвч чи Үхэгсдийн орон уруу, нүхний хамгийн гүнд хүртэл хаягдана. (Исаиа 14:12-15). "Сүйрлийн өмнө бардам зан явдаг бол бүдэрч


унахын өмнө дээрэлхүү зан явдаг. (Сургаалт үгс 16:18). Бардамнал дуулгаваргүй байдлыг дагуулдаг. Бардамнал, дуулгаваргүй байдал хоёр хоёулаа Сатанд байсан. “Учир нь тэрслэх нь ид шидийн нүгэл адил, захирагдахгүй байх нь гэм ба шүтээнд мөргөхтэй адил билээ. (1 Самуел 15:23а). Яг Сатаныг шүүсэн шигээ Бурхан бардамналыг шүүх болно. “Учир нь харагтун, зуух мэт шатаж буй өдөр ирж байна. Омог бардам бүх хүмүүст болон мууг үйлдэгч бүр тохуурхагдана. (Малахи 4:1а). Бид Бурханы нигүүлслийн өмнө өөрсдийгөө даруухан дуулгавартай байлгацгаая! Гэвч тэр илүү их нигүүлслийг өгдөг. Тиймээс” Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлсэл өгдөг” гэдэг. Эзэний оршихуйд өөрсдийгөө даруу болго. Тэгвэл Тэр та нарыг өргөмжлөх болно.

(Иаков 4:6б,10).

ХИЧЭЭЛ 34. НОМНУУД НЭЭГДЭЖ ҮХЭЛ ШҮҮГДЭВ.

Илчлэлт 20:11-15

“Цагаан өнгөтэй агуу их сэнтий болон дээр нь Залрагчийг би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар олдсонгүй. Үхсэн их бага хүмүүс сэнтийний өмнө зогсож байхыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэгэн ном дэлгээстэй байсан бөгөөд тэр нь амийн ном юм. Үхэгсэд нь өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номд бичигдсэн зүйлсээр шүүгдэв. Тэнгис дотроо байсан үхэгсдийг гаргаж өгөв. Тэдний нэг бүр нь үйлсийнхээ дагуу шүүгдэв. Тэгээд үхэл ба үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. Хэрэв хэн нэгний нэр амийн номд бичигдсэн нь олдохгүй бол тэр хүн галт нуурт хаягдсан байна.



Хоёр дахь амилалт

Эхний удаа амилсан хүмүүс ерөөгдсөн бол харин үхсэн итгэгч биш хүмүүс галт нуур уруу хаягдах болно. Ямар аймшигтай хувь заяа вэ! Тэд амийн номноос гадуур шүүгдэх бөгөөд тэдний ажил үйлс номонд бичигдэхгүй. Зөвхөн аврагдсан хүмүүсийн нэрс Хурганы амийн номонд бичигдэнэ. Таны нэр Амийн номонд бичигдсэн үү? Та зөвхөн Есүс Христийг хүлээж авснаар Амийн номонд бичигдэнэ. Гэмээ уучлуулан бусдад сайн мэдээ болон үнэгүй бэлэг болох мөнхийн амьдралын тухай ярих нь танд хэр чухал вэ!

Хоёр дахь үхэл

Дэлхий дээр байгаа бүх өвчин, уй гашуу махан биеийн үр дүнд ирдэг Үхэл нь салалт юм. Махан биеийн үхэл нь сүнсийг биеэс нь салгадаг. Нөгөө талаар сүнслэг үхэл нь сүнсийг Бурханаас салгадаг. Хоёр дахь үхэл нь Бурханаас салгадаг үхэл бөгөөд мөнхийн гал мөн зовлонд үүрд унагадаг. Зөвхөн нүгэл нь уучлагдаагүй хүмүүсийн хувьд “Тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв. (Илчлэлт 21:8б). “Учир нь Бурханы зөвт байдлыг мэдэлгүй, өөрсдийнхийгөө тогтоохыг эрмэлзэн тэд Бурханы зөвт байдалд үл захирагдав. (Ром 10:3). Дахин амилсан итгэгчдийн хувьд хоёр дахь үхэл нь ямарч хүч чадалгүй юм. “Ялагч нь хоёр дахь үхлээр хохирохгүй. (Илчлэлт2:11б)

Амийн ном

Мөнхийн амьдарлыг хүлээж авсан хүн бүрийн нэр амийн номонд бичигдсэн байдаг. Библид ингэж бичигджээ. “Есүс бол Христ, Бурханы хүү мөн гэдэгт та нарыг итгүүлэхийн тулд бичигдсэн бөгөөд ингэснээр итгэлээр дамжуулан та нар Түүний нэрээр амьтай болох юм. (Иохан 20:31). “ Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүгийн дотор байна. Хүүтэй хүнд амь бий.Хүү байхгүй хүнд амь байхгүй. (1Иохан 5:11б,12) “Хэрэв хэн

нэгний нэр амийн номонд бичигдсэн нь олдохгүй бол тэр хүн галт нуурт хаягдах болно.(Илчлэлт 20:15).

Хэрэв та шинэ амьдралыг Есүсээр дамжуулан хүлээн авсан бол галт нуураас аврагдсандаа Бурханд таларх! Хэрэв та хараахан шинэ амьдрал Христээс аваагүй бол яг одоо Түүнийг зүрх сэтгэлдээ урь. Тэр танд шинэ амьдрал өгөх үед танд Ариун сүнсний хүч чадал өгөгдөх бөгөөд ингэснээр Бурханлаг амьдралаар амьдрахад тань таныг удирдах юм.

ХИЧЭЭЛ 35. ШИНЭ ИЕРУСАЛИМ ШИНЭ ДЭЛХИЙ БУУВ.

Илчлэлт 21:1-27



“Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одож тэнгис байхгүй болов. Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдсэн, Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа. Сэнтийнээс чанга дуу гарахыг би сонсов.

Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно.

Тэд Түүний ард түмэн болж, Бурхан Өөрөө тэдний дунд байж “тэдний Бурхан нь болно”. Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо. Сэнтийнд Залрагч


-Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд

Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үиэн гэв. Тэр надад Энэ нь дууслаа. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булагаас өгнө. Ялагч нь эдгээр зүйлсийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно. Харин хулчгар,

итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв. Сүүлчийн долоон гамшгаар дүүрэн долоон аягатай долоон тэнгэр элчийн нэг нь ирээд надтай ярилцан

-Нааш ир. Би чамд Хурганы эхнэр болох сүйт бүсгүйг үзүүлэе гэв. Тэр намайг сүрлэг өндөр уулан дээр Сүнс дотор аваачаад Бурханаас гарч, тэнгэрээс буун ирж буй ариун хот Иерусалимыг үзүүллээ. Түүнд Бурханы алдар нь байлаа. Гялбаа нь үнэт чулуу мэт бөгөөд талст шиг тунгалаг хас чулуу мэт байв. Тэр нь асар том өндөр хэрэмтэй бөгөөд арван хоёр хаалгатай байлаа. Хаалганууд дээр нь арван хоёр тэнгэр элч байлаа. Тэдгээрийн дээр Израилийн хөвгүүдийн арван хоёр овгийн нэрс бичигдсэн байв. Зүүн талд нь гурван хаалга, өмнө талд нь гурван хаалга, баруун талд нь гурван хаалга байх аж. Хотын хэрэм нь арван хоёр суурьтай агаад тэдгээрийн дээр Хурганы

арван хоёр элчийн арван хоёр нэрс байлаа. Надтай ярьсан тэнгэр элчид хот болон хаалгануудыг, мөн хэрмийг нь хэмжих алтан шугам байв. Хот дөрвөлжин бөгөөд урт нь өргөнтэйгээ адил аж. Тэнгэр элч хотыг шугамаараа хэмжихэд урт, өргөн, өндөр нь адилхан арван хоёр мянган стадиа байлаа. Тэр хотын хэрэмийг хэмжихэд, хүний хэмжээс ба мөн тэнгэр элчийн хэмжээсээр зуун дөчин дөрвөн пехус болов. Хэрэмийг хас чулуугаар хийсэн бөгөөд хот нь тунгалаг шил мэт шижир алт ажээ. Хот хэрмийн сууриуд нь төрөл бүрийн эрдэнийн чулуугаар чимэглэгджээ. Эхний суурь нь хас, хоёр дахь нь индранил, гурав дахь нь гартаам, дөрөв дахь нь маргад эрдэнэ, тав дахь нь мамагартам, зургаа дахь нь нал, долоо дахь нь хашиг,



найм дахь нь биндэргяа, ес дахь нь молор, арав дахь нь мана, арван нэг дахь нь оюу, арван хоёр дахь нь ягаан болор байв. Арван хоёр хаалга нь арван хоёр сувд ажээ. Хаалга нэг бүр нь нэгэн цул сувд байсан бөгөөд хотын гудамжинд нь тунгалаг шил мэт шижир алт байв. Би хотод ямарч сүм харсангүй. Учир нь Төгс хүчит Эзэн Бурхан ба Хурга бол тэндхийн сүм юм. Хотод дээрээс нь гэрэлтүүлэх нар, сар хэрэггүй ажээ. Учир нь Бурханы цог жавхлан түүнийг гэрэлтүүлсэн бөгөөд дэнлүү нь Хурга байлаа. Үндэстнүүд тэр гэрлээр нь алхацгааж, газрын хаад тийшээ алдраа авчирна. Хотын хаалганууд өдөр хэзээ ч хаагдахгүй. Учир нь тэнд шөнө гэж байхгүй. Тэд үндэстнүүдийн алдар хүндлэлийг тийшээ авч ирнэ. Ямар ч бузар юм болон жигшүүрт зүйл үйлддэг болон худал ярьдаг хэн ч хэзээ ч тийшээ орохгүй.

Харин зөвхөн Хурганы амийн номд нэрс нь бичигдсэн хүмүүс л орох ажгуу.

Илчлэлт 22:1-5

“Тэр надад Бурханы болон Хурганы сэнтийнээс гарах талст мэт гялалзсан амийн усны голыг үзүүлсэн нь гудамжных нь төвд байв. Голын хоёр талд арван хоёр төрлийн үр жимс ургуулан, сар бүр үр жимсээ боловсруулж буй амийн мод байлаа. Тэр модны навчис нь үндэстнүүдийг эдгээхийн тулд байлаа. Тэнд цаашид ямар ч хараал байхгүй болно. Мөн Бурхан ба Хурганы сэнтий түүний дотор байж, боолууд нь Түүнд үйлчилнэ. Тэд Түүний царайг харна. Мөн Түүний нэр тэдний духан дээр байх болно. Тэнд цаашид шөнө болохгүй. Эзэн Бурхан тэднийг гийгүүлэх учраас тэдэнд дэнлүүний гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй болно. Учир нь Эзэн Бурхан тэднийг гийгүүлнэ. Тэгээд тэд үеийн үед хаанчлах болно.

Шинэ тэнгэр шинэ газар

Бурхан шинэ газар шинэ дэлхийг бүтээнэ хэмээн амласан. “Харагтун, Би шинэ тэнгэр, шинэ газрыг бүтээнэ. Урьдын юмс санагдахгүй, бодол санаанд ч үл бууна. Харин Миний бүтээх зүйлд үүрд баярлан баясагтун. (Исаиа 65:17-18a).” Тэгэхэд тэнгэр нүргэлдээд өнгөрнө. Аливаа бодисууд



галд устгагдах бөгөөд газар болоод түүн дээрх ажлууд шатаагдана. Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр шинэ газрыг хүлээн авна. Тиймээс хайртууд минь, та нар эдгээрийг хүлээж буй учраас амар амгалан дотор болон толбогүй

бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээгтүн. (2 Петр 3:10б,13,14)

Шинэ Иерусалим

Бурхан Иерусалимыг өөрийн сонгосон хүмүүсийн нийслэл хот болгон сонгосон, Израилийн ард түмнээр дамжуулан Аврагч дэлхий дээр ирсэн. Тэнд Тэрбээр Өөрийн нэрийг мөнхрүүлэхийг Өөрөө сонгосон. Шинэ дэлхий дээр шинэ тэнгэрлэг Иерусалим нийслэл хот болон бууж ирэх төдийгүй Бурхан Өөрийн аврагдсан хүмүүсийн дунд байх болно. Хотын урт өргөн нь адилхан. (12,000 фарлонг буюу хоёр мянга хоёр зуун дөчин километр). Энэ хот нь маш гайхамшигтай үзэсгэлэнтэй хот бөгөөд хотын гудамж нь тунгалаг шил мэт шижир алтаар бүрхэгдсэн байна.

Хийх зүйлс

Хоосон зайг шинэ тэнгэр шинэ дэлхий дээр байх зүйлээр нөхөж бич.

1. Тэнд байхгүй болов. (Илчлэлт 21:1)
2. Тэр тэдний нүднээс бүрийг арчина. Тэнд цаашид байхгүй болно. Тэнд цаашид гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо.
3. Тэд [айдастай хүмүүс, Бурхан биш],, жигшүүрт, болон бүх хүмүүс тэнд байхгүй байна.(8)

4. Би хотод ямар ч харсангүй. Учир нь Төгс хүчит Эзэн Бурхан ба Хурга бол тэндхийн сүм юм.(22)

5. Хотод дээрээс нь гэрэлтүүлэх хэрэггүй.(23)6

6. Хотын хаалганууд өдөр хэзээ ч Учир нь тэнд болохгүй.

7. Ямар ч юм болон зүйл үйлддэг болон ярьдаг хэн ч хэзээ ч тийшээ орохгүй. Харин зөвхөн Хурганы амийн номд нэрс нь бичигдсэн хүмүүс л орох ажгуу.(27)

8. Тэнд цаашид ямар ч үгүй болно.

9. Эзэн Бурхан тэднийг гийгүүлэх учраас тэдэнд хэрэггүй болно.

Амийн мод

Бурхан дэлхийг бүтээхдээ мөн амийн модыг бүтээсэн. Сатан Еваг хориотой модноос жимс идэхийг ятгасан. Ева жимсийг Адамд өгч идүүлснээр гэм, үхэл дэлхий дээр ирсэн.“Тэгээд Бурхан тэр хүнийг хөөж гаргаад, амийн мод уруу хөтлөх замыг хамгаалуулахаар Еден цэцэрлэгийн зүүн талд херубууд болон зүг бүрд эргэлддэг галт илдийг байрлуулан тавьжээ. (Эхлэл 3:24). Бурхан анх Адам Еваг мөнх амьтай бүтээсэн гэвч тэд гэмд унасан, Бурхан тэд нарыг амийн модноос жимс идэхийг зөвшөөрөөгүй байсан. Бурхан гэмтэй тэд нарыг мөнх амьдруулахыг хүсээгүй. Гэмээсээ болж үхэж байгаа хүн төрөлхтний төлөө Бурхан өөрийн хүү Есүсийг илгээсэн. Ингэснээр тэд түүнээс мөнхийн амийг олж авч чадах юм. Бурханд талархъя! “Бурханы диваажинд буй амийн модноос идэхийг Би ялагч нэгэнд соёрхоно. (Илчлэлт2:76). Шинэ дэлхий дээр амийн мод



дахин ирнэ. “Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ”. (Илчлэлт22:14). Хэрэв та бусдад Есүсийг Аврагчаа хэмээн хүлээн авахад нь туславал амийн мод шиг болж болно. “Шударга зөв хүний үр жимс нь амийн мод юм. Мэргэн хүн сэтгэлийг байлдан дагуулна. (Сургаалт үгс 11:30).

ХИЧЭЭЛ 36. ЕСҮС ИРЭХ БОЛНО.

Илчлэлт 22:6-21

Тэр надад
-Эдгээр үгс нь итгэмжит бөгөөд үнэн. Эш үзүүлэгчдийн сүнсний Бурхан Эзэн удахгүй болох ёстой зүйлсийг Өөрийн зарц нартаа үзүүлэхийн тулд тэнгэр элчээ илгээв. Харагтун, Би удахгүй ирнэ. Энэхүү номын эш үзүүлэгчийн үгсийг сахигч нь ерөөлтэй еэ” гэсэн гэж хэлэв. Иохан, би бол эдгээр зүйлсийг үзэж, сонссон нэгэн юм. Би үзэж, сонсоод эдгээр зүйлсийг надад үзүүлсэн тэнгэр элчид мөргөхөөр хөлд нь унав. Тэр надад

-Ингэсний хэрэггүй, Би бол чиний болон эш үзүүлэгч ах дүүсий чинь, мөн энэхүү номын үгсийг сахигсдын хамтран зүтгэгч боол билээ. Бурханд мөргө гэв. Тэр надад ингэж хэлэв.

-Энэхүү номын эш үзүүлэгчийн үгсийг бүү лацад. Учир нь цаг ойрхон байна.

Бурууг үйлддэг нэгэн нь буруугаа үйлдсээр л байг. Бузар муу нэгэн нь бузар муу чигээрээ л байг. Зөвт нэгэн нь зөвт байдлаа хэрэгжүүлсээр л байг. Ариун нэгэн нь өөрийгөө ариунаар сахьсаар л байг.Харагтун, Би удахгүй ирнэ. Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөхийн тулд Миний шагнал Надтай хамт байгаа. Би бол Альфа ба Омега, Эхэн ба Эцэс, Эхлэл ба Төгсгөл мөн. Амийн мод уруу очих эрхтэй болохын тулд хаалгаар хот уруу орохын тулд дээлээ угаагчид нь ерөөлтэй еэ. Гадна талд нь ноход, мэргэ төлөгчид, завхай хүмүүс, алуурчид, шүтээнд мөргөгчид, болоод худлыг хайрладаг, үйлддэг бүхэн байна. Есүс Би чуулгануудын төлөө та нарт эдгээр зүйлийг гэрчлэхийн тулд Өөрийн тэнгэр элчийг илгээлээ. Би

бол Давидын Удам ба Үндэс, гэрэлт үүрийн цолмон билээ гэв. Сүнс болон сүйт бүсгүй

-Ирээрэй гэнэ. Сонсогч нь

-Ирээрэй гэж хэлэг.

Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг. Энэхүү номын эш үзүүллэгийн үгсийг сонсогч бүрд би гэрчилж байна. Хэрэв хэн нэгэн нь эдгээрийн дээр нэмэх аваас Бурхан энэхүү номд бичигдсэн гамшгуудыг түүнд

нэмэх болно. Хэрэв хэн нэгэн нь энэхүү эш үзүүллэгийн номын үгсээс хасах аваас Бурхан энэхүү номд бичигдсэн амийн модноос болон ариун хотоос хувийг нь хасах болно. Эдгээр зүйлсийг гэрчлэгч Тэр

-Тиймээ, Би удахгүй ирнэ гэж айлдаж байна. Амен. Ирээрэй, Эзэн Есүс ээ. Эзэн Есүсийн нигүүлсэл бүгдтэй хамт байх болтугай. Амен.

Зөвхөн Бурханд мөргө.

Иохан тэнгэр элчид мөргөхийг оролдсон харин тэр бүү ингэхтүн гэж хэлсэн. Сатан Есүсийг сорьж байхдаа түүнд мөргөвөл бүх дэлхийн хаант улсыг өгнө гэжээ. Харин Тэрбээр "Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил" гэж бичигдсэн байдаг гэв. (Лук 4:8). Бурхан бид нарыг Түүнд мөргөхийг хүсдэг, ЗӨВХӨН Түүнд. Бурхан Есүсийн тухай ингэж хэлсэн нь гайхамшигтай юм. "Бурханы бүх тэнгэр элч нар Түүнд мөргөгтүн" гэж айлджээ. (Еврей 1:66)

Бид Есүст мөргөж болох бөгөөд учир нь Тэр махан биеэр бидний дунд амьдарсан Бурхан юм.

Есүс өөрийн шагналтайгаа ирнэ

Есүс Түүнд үйлчилсэн итгэгч нарт шагнал амласан. "Тэд тус бүрдээ хөдөлмөрийнхөө дагуу шагналаа авах болно. (1Коринт 3:13-14). Зөвхөн Бурханы Сүнсний хүч чадлаар он цагийг тэсвэрлэсэн хүнд шагнал өгөгдөнө. "Ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Яагаад гэвэл энэ нь галаар



илэрхий болгогдох бөгөөд гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. "Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэр хүн шагналаа хүлээн авна. (1Коринт 3:13-14). Бурхан олон төрлийн титмийг амласан. "Тэгээд ахлах Хоньчинг үзэгдэхэд та нар алдрын гандашгүй титмийг хүлээн авна. 1Пётр 5:4). "Сорилтыг тэсвэрлэдэг хүн ерөөлтэй еэ, Учир нь тэр соригдчихоод, Эзэний Өөрийг нь хайрлагсдад амласан амийн титмийг хүлээн авна. (Иокоа 1:12). "Үхэл хүртэл итгэмжтэй бай. Тэгээд Би чамд амийн титмийг өгнө. (Илчлэлт 2:106). "Ирээдүйд зөв байдлын титэм нь надад зориулагдан зэхэгдсэн ажээ. Зөв шударга шүүгч болох Эзэн намайг, зөвхөн намайг ч биш, Түүний үзэгдэхийг хүсэн хүлээгч бүх хүмүүсийг бас түүгээр шагнах болно. (2 Тимот4:8).

Цангасан нэгэнд зориулагдсан амийн ус

Есүс худагас ус авах гэж ирсэн Самари хүүхэнд "амийн уснаас" үнэгүй авахыг санал болгосон. "-Энэ уснаас уух хүн бүр дахин цангана. Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно гэв. (Иохан 4:13,14). Тэр хожим нь тайлбарлахдаа "Хэрэв цангасан хүн байвал, Над уруу ирж уугтун. Надад итгэдэг хүн "Түүний дотроос амийн усны гол урсах болно" гэж Сударт хэлсэнчлэн байх болно гэв. (Иохан 7:37б-38). Тэр итгэгч нарт байх Ариун Сүнсний тухай ярьж байв.

Есүс одоо дахин амийн усыг санал болгож байна. Амийн усны голоос гарах болор мэт цэнгэг ус Бурханы болон Хурганы хаанчлалаас гарах болно. Танд урилга дахин ирсэн: Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг. (Илчлэлт 22:17б). Энэ урилга нь Бурханы сүүлчийн урьсан үг байсан. Та Түүний урилгыг хүлээн авсан уу? Хэрэв та хүлээн авсан бол ерөөгдсөн. Есүс өөрийгөө удахгүй ирнэ гэж хэлсэн. Хэрэв та Түүнийх бол, та бусад дэлхий дээр байгаа итгэгч нарын хамт Иоханд хариуг нь өгөөрэй. Гэсэн хэдий ч Ирээрэй Их Эзэн Есүс ээ.

Асуултын хариултууд

Илчлэлт номын энэхүү Библи судлалд гарсан асуултуудын хариултыг доороос харж болно. Ингэснээр та өөрийн хийсэн ажлаа шалгаж, зөв хариултыг мэдэж авч чадна.

Хичээл 2: хуудас 4-7

1. Долоон, чуулган,
2. Хөл, алтан
3. Цагаан, цас
4. Галын, дөл
5. Хүрэл
6. Усны
7. Од, Тэнгэр элч
8. Илд
9. Нар
10. Үхсэн
11. Үхэл, Үхэгсдийн орон
12. (а)Харснаа
(б) байгааг
(в) эдгээрийн дараа

Хичээл 3: хуудас 9,10

1. Од
2. Ажил үйлс, тэвчээр муу, үзэн яддаг
3. Анхны хайр
4. Диваажинд, Амийн мод

Хичээл 4: хуудас 12,13

1. Эхэн, Эцэс, Үхэл, Амилсан
2. Зовлон, Ядуу байдал
4. Үхлээр, Хохирохгүй

Хичээл 5: хуудас 15,16

1. Хурц, илдтэй
2. Нэрийг, Үгүйсгээгүй
3. Балаамын, Николайчуудыг
4. Манна, цагаан, нэр

Хичээл 6: хуудас 17,18

1. Бурхан, нүд, хөл
2. Хайр, итгэл, үйлчлэл, ажил үйлс, эхнийхээсээ
3. Иезебел, Эш үзүүлэгч, Шүтээнүүдэд
4. Хамгаалдаг, үндэстнүүдийг, садар самуун, эрх мэдэл, цолмон

Хичээл 7: хуудас 20,21

1. Долоо, долоо
2. Хиртүүлээгүй
3. Амьд, үхдэл, гүйцэлдснийг
4. Амийн ном, баллахгүй, хүлээн зөвшөөрнө,

Хичээл 8: хуудас 23,24

1. Нээхэд, хаахгүй, хаахад, нээхгүй, түлхүүртэй, үнэн, ариун
2. Хүч, үгийг, үгүйсгээгүй, тэвчээр,
3. Багана, гарахгүй, нэр, хот, шинэ

Хичээл 9: хуудас 27,28

1. Амен, итгэмжит, үнэн, бүтээлийн
3. Хүйтэн ч, халуун ч, бүлээвтэр, бөөлжих, баян, баяжсан, байхгүй, ялуу, сохор, нүцгэн
4. Заларсны, сэнтийд залрах

Хичээл 12: хуудас 40,41

1. Цагаан, нумтай, Титэм
2. Улаан, энх тайван, илд
3. Хар, дэнс
4. Цайвар ногоон, Үхэл, үхэгсдийн орон, илд, өлсгөлөн, Үхэл, араатнуудаар
5. Сүнснүүдийг, тахилын ширээ,
(а) Бурханы үгээс болж
(б) Өөрсдийн сахьсан гэрчлэлээс
6. (а) Газар хөдлөлт
(б) Харлаж
(в) Цус
(г) Унан
(д) Сална
(е) Уулс, арлууд

(б) Нуугдах, нүүрнээс, уур хилэнгээс, далдлах

Хичээл 14: хуудас 48,49

1. Улс үндэстэн, овгоос, хэлтнээс
2. цус, угаах
3. бүрхэн
4. Өлсөх, цангах
5. Наранд, халуунд
6. Хоньчлох, булгууд
7. нулимс

Хичээл 22: Хуудас 66,67

1. нарыг, сар, арван хоёр, эмэгтэй
2. муу, төрмөгц, хүүхдийн
3. үндэстнийг, төмөр, Сэнтийд
4. Бурханы, цөл, 1,260
5. Михаел, муутай, дэлхий

Хичээл 32: Хуудас 96,97

1. өөрөө, өлдөр, хүч чадал,
2. Үнэн, зөвт,
3. янхан эм, шийтгэв
4. боолуудын, өшөөг
5. хаанчилдаг
6. Хурим
7. бэлдэв

Хичээл 35: Хуудас 108, 109

1. Тэнгис
2. нулимс, үхдэл, гашуудал, уйлах, өвдөх,
3. хулчгар, итгэлгүй, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид, худалч.
4. сүм
5. нар, сар
6. хаагдахгүй, шөнө,
7. бузар, жигшүүрт, худал
8. хараал
9. дэнлүүний гэрэл

*Та Есүс Христийн тухай илүү
ихийг мэдэхийг хүсвэл доорхи
хаягуудаар зочилно уу.*

www.lamcc.us

www.ltime.fr

www.lwcc.mn